

Ч.Алтангэрэл, Д.Бямбажав, Н.Мягмарцож,  
Б.Энхтуяа, Э.Булган-Эрдэнэ

# НИЙГЭМ СУДЛАЛ

## VIII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн  
8 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2019 он

DDC 74.2  
HAA 373  
H-588

Нийгэм судлал VIII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 8 дугаар ангийн сурх бичиг /Алтангэрэл Ч. ба бус; Ред. Алтанцэцэг Т. -УБ., 2017. - 96х

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурх бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурх бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99978-61-10-8

# ГАРЧИГ

## I БҮЛЭГ ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ

1.1. Орон нутгийн орчин яагаад чухал вэ?.....	6
1.2. Орон нутгийн амьдралд тулгамдаж буй асуудлыг хэрхэн ойлгох вэ? .....	12
1.3. Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хүүхдүүд хувь нэмрээ оруулах нь.....	18
1.4. Бүлгийн дүгнэлт .....	22

## II БҮЛЭГ ХУВЬ ХҮН БА СОЁЛ

2.1. Бид нутгийнхаа өв соёлоор бахархдаг.....	25
2.2. Соёл бол хэм хэмжээ мөн.....	30
2.3. Соёл хэрхэн өөрчлөгддөг вэ? .....	35
2.4. Бүлгийн дүгнэлт .....	39

## III БҮЛЭГ ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

3.1. Орон нутгийн эдийн засгийн бүтцийн талаар бид юу мэдэх вэ?.....	43
3.2. Орон нутгийн зах зээл .....	51
3.3. Жижиг бизнесийн төсөл .....	55
3.4. Бүлгийн дүгнэлт .....	59

## IV БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХ БА ХУУЛЬ

4.1. Хүний эрхийн төлөө тэмцэл түүхийг бүтээсэн нь.....	63
4.2. Хүний эрхийн зарчмуудыг мэдэх үү?.....	66
4.3. Эрх тэгш байдал яагаад чухал вэ?.....	70
4.4. Хүний эрхийг хязгаарлах нь зөв үү? .....	74
4.5. Хүний эрхийг хангах нь нутгийн захирагааны үүрэг болох нь .....	76
4.6. Бүлгийн дүгнэлт - Хүний эрхэд ээлтэй орон нутаг .....	79

## V БҮЛЭГ ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА

5.1. Орон нутгийн удирдлагын эрх мэдэл хаанаас эхтэй вэ? .....	82
5.2. Орон нутагт тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ? .....	87
5.3. Орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад бид хэрхэн оролцох вэ? .....	90
5.4. Бүлгийн дүгнэлт .....	94

## СУРАГЧ ТАНАА

"Нийгэм судлал VIII" сурх бичиг нь эрхэм сурагч таны эрдмийн их далаид хийх аялалд тань зүг чиг заах номын нэг нь байгаасай хэмээн мэндчилж байна.

Өнөөдрийн сурагчид маргаашийн шийдвэр гаргагчид билээ. Иймд хүүхэд, өсвөр үеийнхэн нийгмийн харилцаа, соёл уламжлал, шударга ёс, хүний эрх, нутгийн удирдлага болон эдийн засгийн зохицуулалтын талаар суралцсанаар хүний эрхийг дээдэлсэн, шударга ёсыг эрхэмлэсэн нийгмийг хөгжүүлж чадна.

Та бүхэн нийгмийн гишүүн, Монгол Улсын иргэний хувьд амьдарч буй орон нутгийнхаа нийгмийн харилцааг танин мэдэж, эрхээ өдлэхийн хамт бусдын үзэл бодол, соёлын ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг болон төлөвшихөд тань энэ сурх бичиг зохих тус дөхөм болно.

"Дэлхийн түвшинд сэтгэж, нутгийн түвшинд үйлд" гэсэн үг байдаг. Энэ бол орчин үеийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж, өнөө цагийн төлөөлөл болж буй хүүхэд, залуус та бүхэнд хамгийн чухал зарчим билээ. Та нар амьдарч буй нутаг орондоо, гэр бүлдээ, наиз нөхдөдөө үлгэр дуурайлал болсон, эрх үүргээ сайтар мэдэж, хууль дүрмийг дагаж мөрддөг иргэн болохыг хүсье.

"Нийгэм судлал VIII" сурх бичигтэй хамтран хийх эрдмийн аянд тань амжилт хүсээд, аяллын замд хэрэг болох дохио тэмдгүүдийг танилцуулья. Энэхүү аялал таны амьдралд хөтөч болох мэдлэг, чадвар, арга барилд суралцахад тань тусална хэмээн найдаж байна.

## ЗОХИОГЧДЫН БАГ

### СУРАХ БИЧИГТ АШИГЛАХ ТАНИХ ТЭМДЭГ



Эргэцүүлэн хэлэлцээрэй



Бие дааж ажиллаарай



Хамтран ажиллаарай



Асуудал шийдвэрлээрэй



Тохиолдол шинжлээрэй



Эх сурвалжтай ажиллаарай



Өөрийгөө сориорой



Гэртээ хийгээрэй

## БҮЛЭГ

# ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ



## ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Орон нутгийн байгууллага, бүлгүүд
- Орон нутгийн нийгмийн асуудал
- Зөрчилдөөний шалтгаан, үр дагавар
- Зөрчилдөөнийг шийдвэрлэх арга зам
- Сайн дурын үйл ажиллагаа

## ЧАДВАР, ХЭРЭГЛЭЭ

- Орон нутгийн байгууллагууд, бусад бүлгүүдийн уялдаа холбоог зураглаж, хувь хүний амьдралд үзүүлж буй нөлөөллийг жишээгээр тайлбарлах
- Орон нутгийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, тэдгээр нь хүмүүсийн байр суурь, үүрэг, соёлын ялгаанаас хэрхэн хамаарч байгааг тодорхойлох
- Зөрчил нь байр суурь, соёлын ялгаанаас үүдэлтэй болохыг мэдэж, зөрчлийн эерэг, сөрөг талыг тодорхойлох, үл ойлголцол, зөрчлөөс сэргийлэх арга замуудыг нэрлэх

## 1.1. ОРОН НУТГИЙН ОРЧИН ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Бидний амьдарч буй орон нутгийн орчинд нийгмийн ямар бүлэг, байгууллагууд байдаг, тэдгээр нь хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлдэг тухай энэ бүлэг сэдвээр судална. Мөн өөрсдийн амьдардаг нутаг орны хэмжээнд тулгарч буй нийгмийн асуудлуудын учир шалтгааныг судлан шинжилж, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлоход суралцах болно. Хүүхдүүд бид орон нутгийнхаа нийгмийн амьдралд хувь нэмэр оруулж, зэрэг өөрчлөлт бий болгож чадна гэдгийг энэ бүлэгт өгүүлэх жишээ, тохиолдлуудаас мэдэж аваарай.



Зураг 1.1 Хотжилт хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?

Орон нутгийн орчин гэдэгт хүмүүсийн ажиллаж, сурч, амьдарч буй аймаг, хот, сум, дүүрэг, баг, хорооны хүмүүс хоорондын харилцаа, нийгмийн бүлэг, байгууллагуудын хүрээг ойлгож болно. Хэдийгээр аймаг, сумд, хот тосгод бүгд Монгол Улсад хамаарах ч байгаль газарзүйн онцлог, эдийн засгийн хөгжил, хүн амын бүлгүүд, соёл уламжлал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч орон нутаг бүр хоорондоо ялгаатай байдаг. Ялангуяа хотжилт эрчимтэй явагдаж байгаагийн улмаас орон нутгийн хөгжилд ихээхэн түлхэц үзүүлж байна. Хотжилт нь нийслэл хот, аймгийн төв зэрэг томоохон хот суурин болон хөдөөгийн сум, багийн хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлж байгаа талаар эргэцүүлэн бодоорой.



### Хамтран ажиллаарай

Цаатан иргэдийн амьдарч буй орон нутгийн орчин тун онцлог. Цаатан иргэд Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд гол төлөв амьдардаг. Одоогоор 280 орчим



Зураг 1.2 Цаатан иргэдийн ури, цаа буга

цаатан хүн байдаг бөгөөд тэд өвөлдөө 31-50 хасах хэмийн хүйтэн тайгад цаа буга маллан аж төрж байна. Цаатан хүмүүс гэр бүл болох, хурим найр хийх, цаа буга сэтэрлэх, ан ав хийх, урц гэрээ барих зэргийн хувьд бусад үндэстэн, ястнаас ялгарах өвөрмөц соёл уламжлалтай ажээ. Цаатан хүүхдүүд сум, орон нутгийнхаа сургуульд суралцдаг боловч ихэнх тохиолдолд сургуулиас гарч, цаатны амьдралаа өвлөн үргэлжлүүлдэг.

Мөн алс тайгад амьдардаг тул сумын төвд сургуульд суралцахад зохих бэрхшээлүүд тулгардаг ажээ.

Асуултын дагуу ярилцаж, дүн шинжилгээ, таамаглалаа танилцуулаарай.

- Цаатан хүмүүсийн амьдарч буй орон нутгийн гол онцлог юу вэ?
- Цаатан хүүхдүүдийн амьдралд орон нутгийн орчин хэрхэн нөлөөлдөг вэ?
- Ирээдүйд цаатан хүмүүст тулгарч болох чухал асуудлууд юу вэ?

Хүмүүсийн амьдралд орон нутгийн байгууллагууд, гэр бүл, төрөл садан, орц, хот айл зэрэг нийгмийн бүлгүүд чухал үүрэгтэй. Эдгээр байгууллага, бүлэгт болон тэдгээрийн хооронд бие биедээ итгэх итгэл, хамтран ажиллах эрмэлзэл, дотно нөхөрсөг байдал давамгайлж байна уу гэдэг нь чухал юм. Энэ талаар орон нутаг бүрд ялгаатай байдал, өвөрмөц талууд илэрдэг. Тухайлбал, зарим гудамж, байр, орцныхон айл хөршдөө санаа тавих, гудамж, орцын аюулгүй байдлыг хангах, бие биедээ зүй ёсны шаардлага тавих зэргээр амьдрах орчноо хамтдаа сайжруулахад анхаардаг. Малчдын хувьд хот айл, саахалтаараа хоршин, жилийн дөрвөн улиралд бие биедээ тус дэм болон амьдарч ирсэн уламжлалтай. Тиймээс ч “Айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг” хэмээн Монголчууд хэлэлцэж ирсэн билээ.



### Хамтран ажиллаарай

2011 онд Япон улсын Сэндай муж газар хөдлөлтийн улмаас аймшигт цунамид өртөж, олон мянган хүн амь насаа алдаж, асар их гарз, хохирол амссан юм. Далайд үүссэн цunami 40 минутын дараа эрэгт хүрсэн бөгөөд энэ хугацаанд хүмүүс амжин аюулгүй газар луу нүүн шилжих хэрэгтэй болов. Тухайн орон нутгийн хүмүүс маш хурдан зохион байгуулалтад орж бүгд эсэн мэнд үлдсэн байхад зарим газар их хэмжээний гарз, хохирол амссан байв. Эрдэмтэд эдгээр орон нутгийн нийгмийн харилцааны талаар судлаад тэрхүү нутгийн хүмүүс бусдадаа итгэдэг, илүү дотно нөхөрсөг байснаар тэдгээр хүмүүсийн амь нас хамгийн бага хохирсон болохыг тогтоожээ.



Зураг 1.3 2011 онд цunami эрэгт хүрэхээс өмнө орон нутгийн цргээдийг хоргодох байранд шилжүүлж буй нь

- Олон хүн эсэн мэнд үлдэхэд бие биедээ итгэдэг, дотно нөхөрсөг байдал хэрхэн тусалсан талаар өөрсдийн таамаглалыг дэвшүүлж ярилцаарай.
- Энэ байдал нь байгалийн гамшиг болж өнгөрсний дараа хот суурин, тосгод эргэж сэргэх, хүмүүс орон нутагтаа үргэлжлүүлэн амьдрахад хэрхэн нөлөөлөх вэ?

Бид 7 дугаар ангидаа хувь хүмүүсийн хоорондын харилцаа, нийгмийн анхдагч болон хөёрдогч бүлэг, байгууллагуудын тухай судалсан билээ. Эдгээр нь хүмүүсийн өдөр тутмын амьдралд маш чухал үүрэгтэй байдгийг сэргээн санаарай. Мөн бид олон бүлэгт нэгэн зэрэг хамаарч болдог гэдгийг эргэцүүлэн бодоорой. Жишээ нь, спортын баг, найз нөхөд, анги хамт олон, ажлын газрынхан, хот айл гэх мэт бүлэг бүр өөрийн онцлог бүхий зорилго, соёл, хэм хэмжээтэй байдаг гэдэгтэй санал нийлж байна уу?

Та бүхэн дараах дасгалыг хийхдээ өмнөх мэдлэгээ сэргээн санаж, хувь хүн ба нийгмийн бүлэг, байгууллагуудын тухай мэдлэгээ гүнзгийрүүлээрэй



## Эх сурвалжтай ажиллаарай

- Би 12 настайдаа Монгол Улсын спортын мастер, дараа жил нь эмэгтэйчүүдийн олон улсын их мастер цолыг хүртсэн. Манай аав анх шатар зааж өгч байлаа. Одоог хүртэл миний дасгалжуулагчаар ажиллаж байгаа.

Эх сурвалж: Шатрын их мастер Батхуягийн Мөнгөнтуул. 2014 он. <http://www.ssport.mn/p/210>

- Судалгааны явцад хүүхдүүдээс “Таны найз чинь танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?” гэж асуухад үүнд хамрагдсан хүүхдүүдийн 2.9% нь “байнга”, 15.6% нь “заримдаа”, 28.9% нь “маш цөн удаа”, 52.6% нь “огт үгүй” гэж хариулсан байна.

Эх сурвалж: Авлигатай тэмцэх газар. Хүүхдийн шударга байдлын үнэлгээ. Улаанбаатар. 2015 он.

- Сургуулийн алсын хараа:**

Бүсдээ бүх талаараа тэргүүлсэн шилдэг сургуулийн нэг болно.

**Эрхэм зорилго:**

Сургалтын агуулгыг орон нутгийн онцлогт тулгуурлан боловсруулж, эрүүл саруул бие бялдартай, бүхий л талаараа хөгжсөн оюунлаг иргэнийг төлөвшүүлэхэд чиглэнэ.

Эх сурвалж: Ховд аймгийн Дарви сумын бүрэн дунд сургуулийн танилцуулга. 2012.

- Твиттер бол нийтийн интернэтийн үйлчилгээ юм. Твиттерт хэрэглэгч 140 тэмдэгтэд багтаан өөрийн үзэл бодол, мэдээллээ нийтэлдэг. Түүнийг нь “tweet” буюу “жиргээ” гэж нэрлэнэ. 2011 оны байдлаар нийт 300 мянган хэрэглэгчтэй болсон байна. Твиттер компани нь АНУ-ын Сан-Франциско хотод байрладаг.

Эх сурвалж: Википедиа: Чөлөөт нэвтрэхий толь. <https://mn.wikipedia.org/wiki/Твиттер>

Дээрх эх сурвалжийг дараах асуултын дагуу шинжлэн судлаарай.

- Эх сурвалж нь нийгмийн анхдагч бүлэг, хоёрдогч бүлэг эсвэл байгууллагын тухай ойлголтын алийг илэрхийлж байна вэ?
- Нийгмийн бүлгүүдээс хувь хүнд үзүүлэх нөлөөний талаар дээрх эх сурвалжид ямар мэдээлэл өгч байна вэ?
- Нийгмийн бүлэг ба байгууллагын ялгааг тодорхойлно уу. Байгууллагын үндсэн шинж чанарыг дээрх эх сурвалжаас тодруулан ярилцаарай.
- Эх сурвалжуудын төрөл, онцлогийг тодорхойлно уу.


## Хувь хүн ба нийгмийн хамаарал

Яагаад хувь хүмүүс хоорондоо харилцаж, хоршин амьдардаг вэ? Хүн тус бүр хувь хувия бодоод, салангид амьдарч болохгүй гэж үү? Энэ талаар судалгаа хийсэн нэрт социологич Э.Дюркгеймийн үзсэнээр хувь хүмүүс, өрх гэрүүд хоршин амьдрах шалтгаан нь хоёр үндсэн хэв шинжтэй байдаг. Нэгд, хүмүүс адил төстэй зүйлээрээ буюу эрхэлж буй аж ахуйн хэвшлээрээ, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээрээ, мөн сэтгэл санаагаараа адилсаж хоршин амьдардаг. Үүнийг тэрээр “механик эв нэгдэл” гэж нэрлэсэн байдаг. Энэ нь түүхийн эрт үед болон жижиг орон нутгийн хүрээнд ихэвчлэн илэрдэг. Хоёрт, хүмүүс өөртөө байхгүй зүйлийг бусдаас авах, солилцоо хийх зорилгоор хоорондоо байнга харилцдаг.

Хүмүүс олон төрлийн ажил хөдөлмөр эрхэлдэг. Зарим нь мал маллаж, зарим нь хувцас урлаж, нөгөө хэсэг нь худалдаа эрхэлнэ. Гэхдээ тэдгээрийн дунд арилжаа, солилцоо зэрэг харилцан хамаарал үүснэ. Үүнийг тэрээр “органик нэгдэл” гэж нэрлэсэн байна. Хөдөлмөрийн хуваарь улам бүр мэргэшин ялгарах тусам нийгэм механик эв нэгдлээс органик эв нэгдэл рүү шилждэг. Орчин үеийн нийгэм бие биеэсээ харилцан хамаарсан ялгаа, онцлогтой хувь хүмүүсийн харилцаан дээр тогтох байдаг.



### Хамтран ажиллаарай



1. Дараах ойлголтыг холбогдох хүрээнд байршуулан бичнэ үү.
2. Эдгээрээс гадна өөр ямар ойлголтууд нэмж болох вэ?
  - Худалдааны төв
  - Хамаатан садан
  - Сургууль
  - Сошиал медиа
  - Найз нөхөд
  - Өрхийн эмнэлэг
  - Хот айл
  - Нэг орцныхон
  - Боловсролын тогтолцоо
  - Хороо
  - Үйлдвэр
  - Нийгмийн даатгал

**Гол санаа.** Нийгмийн харилцаа нь бүлэг, байгууллага, орон нутаг, улс үндэстэн, бус нутаг, даян дэлхийн хүрээнд явагдаж байдаг. Эдгээрээс бидний өдөр тутмын амьдрал хамгийн илүүтэй өрнөж байдаг хүрээ нь орон нутгийн нийгмийн орчин юм. Жишээ нь, гэр бүл, найз нөхөд, сургууль, хамт олон, хот айл, гудамж, сум, хороолол, нутаг усныхан үүнд хамаарна. Энэ хүрээнд өдөр тутмын нүүр тулсан, ойр дотны харилцаа зонхилох хандлагатай байдгийг анзаарч бодит жишээ гарган эргэцүүлэн хэлэлцээрэй.



Бүдүүч 1.1 Хувь хүн ба нийгэм



### Эх сурвалжтай ажиллаарай

Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн судлаачид нийгмийн бүлгүүдийн харилцаанд гарч буй өөрчлөлтийн талаар судлан үзэхдээ хот, суурин газрын хүмүүс хоорондын харилцаанд ойр дотно, нөхөрсөг байдал хэрхэн өөрчлөгджэй буй талаар дараах судалгааны дүнг танилцуулсан байна.

## Хот, суурин газрын хүмүүсийн харилцааны дотно нөхөрсөг байдал, хувиар

	1990	2012	Өөрчлөлт
Анхдагч бүлгийн харилцаа	51.7	44.1	-7.6
• Хамаатан садан, ураг төрлийн барилдлагатай хүмүүс	33.8	27.7	-6.1
• Нэг нутаг усны хүмүүс	13.6	7.3	-6.3
• Нэг орц, хашаа, гудамжны хүмүүсийн харилцаа	4.3	9.1	4.8
Хоёрдогч бүлгийн харилцаа	41.5	55.7	14.2
• Нэг хүсэл сонирхолтой (үзэл бодолтой) хүмүүс	13.6	13.2	-0.4
• Нэг ажлын газар (тасаг, салбар)-ын хамт олон	17.6	19.9	2.3
• Нэг анги, нэг он (цэрэг)- зэрэг бүлгийн гишүүд	7.9	13.6	5.7
• Адил хөрөнгө чинээтэй хүмүүс	2.4	9.0	6.6


- Анхдагч бүлгийн харилцаанд гарсан өөрчлөлтийг дүгнэж бичнэ үү.
- Хоёрдогч бүлгийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг анхдагч бүлгийн өөрчлөлттэй харьцуулан бичнэ үү.
- Энэ өөрчлөлтийн үндсэн шалтгаан, үр дагавар юу вэ?
- Ирэх 10 жилд энэ өөрчлөлт хэрхэн үргэлжлэх талаар таамаглал дэвшигүүлэн ярилцаарай.
- Дотно, нөхөрсөг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс юу вэ?



### Хамтран ажиллаарай

OpenStreetMap буюу "Нээлттэй гудамжны газрын зураг" нь сонирхсон иргэн чөлөөтэй баяжуулж, хөгжүүлж болдог дэлхий дахини цахим газрын зургийн сан юм. Энэ нь мэдээллийг хүртээмжтэй болгоход чиглэсэн иргэдийн сайн дурын үйл ажиллагааны үр дүн болно. Сурагч та бүхэн ч хувь нэмрээ оруулаарай.

Энэ сангаас дараах байршлын зургийг судлан үзэцгээ. Ингэхдээ доорх асуултын дагуу багаар хамтран ажиллаарай.



1. Газрын зураг дээрх янз бүрийн тэмдэглэгээг ажиглаж, тус бүрийн тайлбарыг жагсаан бичнэ үү.
2. Газрын зураг дээр тэмдэглэсэн объект болон байгууллагуудыг орон нутгийн хүмүүсийн амьдралын ямар хэрэгцээг хангаж байгааг харгалzan доорх хүснэгтэд ялган бичнэ үү.


Хүний хэрэгцээ	Байгууллагын нэр
Мөнгө, санхүү	
Сурч боловсрох	
Эрүүл байх	
Тоглож наадах	

Хоол хүнс, хувцас хунар	
Орон гэр	
Бусадтай харилцах	
Аюулгүй байдал	
Нийгмийн халамж	
Бусад	

3. Газрын зурагт орон нутгийн хүмүүсийн амьдралын хэрэгцээг хангадаг бусад объект, байгууллагуудыг нэмж оруулаарай. Яагаад нэмж оруулах болсноо тайлбарлаж ярилцаарай.

### Хувь хүний хэрэгцээ

Америкийн сэтгэл судлаач А.Маслоу 1954 онд хэвлүүлсэн “Сэдэл ба хувь хүн” хэмээх судалгааны бүтээлдээ хүнд олон хэрэгцээ байдаг ч тэдгээр нь дараах 5 үндсэн эрэмбээр шаталсан байдаг гэж үзжээ. Үүнд: физиологийн хэрэгцээ, аюулгүй байдлын хэрэгцээ, нийгмийн хэрэгцээ, хүндлэл хүлээх хэрэгцээ, өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ байна. Хамгийн дээд шатанд хүн хувийн онцлог, боломжкоо бүрэн нээх, чадавхияа бүрэн хэрэгжүүлэх, нийгэмдээ хувь нэмрээ оруулах зэрэг хэрэгцээг илүүтэй хангахыг зорьдог ажээ. Тэрээр А.Эйнштэйн, М.Ганди, Б.Спиноза, Т.Жефферсон зэрэг алдар хүндтэй, амжилтад хүрсэн хүмүүсийн амьдралын замналыг судалсны эцэст өөрийн онолыг дэвшүүлжээ.



Бүдүүч 1.2 А.Маслоуийн хүний хэрэгцээний шатлал

**Гол санаа.** Бидний амьдарч буй орон нутагт байгаа олон янзын бүлэг, байгууллагууд нь хувь хүмүүсийн олон янзын хэрэгцээг хангах үүрэг гүйцэтгэж байдаг. Хүмүүсийн хэрэгцээ өөрчлөгдж байдаг учраас эдгээр бүлэг, байгууллагууд зэрэгцэн өөрчлөгдөх шаардлагатай болдог. Хүмүүсийн хэрэгцээ зохицтойгоор хангагдаж буй эсэх нь орон нутагт олон янзын асуудал үүсэх нэгэн шалтгаан болдог.

### Орон нутгийн судалгаа хийхэд ашиглах судалгааны зарим аргууд

1. Баримт материал цуглуулах арга  
Баримт материалыг хувь хүн, орон нутаг, олон нийт, байгууллагаар цуглуулах боломжтой.
2. Стратификац буюу хүн амыг бүлэг, хэсэг болгож хуваан судлах аргууд  
Амьдралын хэв маяг, нийгмийн байр суурь, орлогоор нь бүлэглэн судалж болно.
3. Түүвэр судалгаа буюу асуулгын арга

Энэ нь урьдчилан боловсруулсан асуултын дагуу судлах арга юм. Аливаа асуудалд хандах хандлага, үзэл бодол, хүсэл сонирхол, үнэлэмж, баримжааллыг судлах олон нийтийг хамарсан судалгааны энэхүү аргыг хэрэглэхдээ тухайн асуудлаар төлөөлж чадах бүлэг хүмүүсийг сонгоход анхаарах нь чухал юм.



Зураг 1.4 Орон нутгийн нийгмийн судалгаа хийж буй нь



### Гэртээ хийгээрэй

1. Өөрийн амьдарч буй баг, хороо, тосгон, суурингийн сүүлийн 10 жилийн хүн амын тоо, өсөлт, бууралтын талаар харьяа баг, хороо, тосгонохоо төв дээр биечлэн очиж, холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнаас мэдээлэл авч, дүн шинжилгээ хийгээд өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврын талаар зурагт танилцуулга бэлтгээрэй.
2. Монголчуудын хувьд нүүдэл нь малын ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор өвсний сор, усны тунгалгийг даган бэлчээр сонгон нүүж амьдардгийг илэрхийлдэг. Малчид ганц өрхөөр бус хэд хэдэн айл өрх нийлж өөрсдийн нутаг усандaa нүүдэллэн амьдардаг. Ийнхүү малчин өрхүүд нутагтаа нийтлэг сонирхолтой бүлэг үүсгэж, түүнийгээ “айл аймгийн улс”, “манай саахалтынхан” гэх мэтээр нэрлэдэг. Ерөнхийдөө 2-3 өрх нэгдэн хот айл болж хоршин амьдрах нь хамгийн нийтлэг байдаг. Энэ талаар Б.Цэнддоо “Соёлын довтолгоо: Анхны хэт гүрнээс сүүлчийн нүүдэлчин” (2008) хэмээх номдоо сонирхолтой тайлбарлажээ. Уг номын хэсгийг уншаад хот айлын зохион байгуулалтын байгаль-нийгмийн учир шалтгааныг эргэцүүлэн бодож, тайлбарлаарай.

*“Хот айл нь эцэг, хүү, хүргэн, эсвэл хадам, хүргэн, худууд гэхчлэнгээр зохион байгуулагдах нь элбэг. Ерөнхийдөө эмгэн өөгөн хоёр, дунд насны гэр бүл, шинэ залуухан айл маягтай байх нь туршилага, чадамж, эрч хүчээр бие биеийнхээ дутууг нөхөх шинжтэй хараагддаг. Ийм учраас хот айлд байх мал сургийн тоо нь бэлчээрийн даацаас хэтрэхийн хэрд өөр хот айл, шинэ коммунити үүсгэн салбарлаж одно.” (Энэ бичвэрт зохиогч “коммунити” гэдэг үгээр орон нутгийн нийгмийн бүлгийг илэрхийлжээ)*

## 1.2. ОРОН НУТГИЙН АМЬДРАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ОЙЛГОХ ВЭ?



### Эх сурвалжтай ажиллаарай



1. 2-10 дугаар ангийн эцэг эхийн эргүүл үүргээ сайн биелүүлж хөдөлгөөнт эргүүлийн үед сурагчдыг явган замын халтиргаа гулгаанаас сэрэмжилж замын цас мөсийг цэвэрлэж байна. Үлгэр жишээ сайн ажиллаж буй эцэг эхчүүддээ сургуулийн захиргаа талархаж байна.

Эх сурвалж: Сургуулийн цаадаа. 2016 оны 11 сарын 11. <https://www.facebook.com/School-police>



2. Хяргас нуур-Завхан голыг хамгаалах зорилгоор “Цэнхэр эргүүл” хэмээх үйл ажиллагааг ахлах ангийн 26 сургач санаачилжээ. Эдгээр хүүхэд усны бохирдлын талаар, гол усаа хамгаалахын ач холбогдлыг иргэдэд тайлбарлаж байгаад нутгийн иргэд ам сайтай байна.

Эх сурвалж: Дэлхийн байгаль хамгаалах сан. Сурагчид усны эргүүл хийж байна. 2015 оны 7 сарын 2. [http://wwf.panda.org/wwf\\_news/?248733/](http://wwf.panda.org/wwf_news/?248733/)



3. Найрамдал паркийн орчимд гуравхан сарын өмнө босгосон нутгийн зураачийн хөшөөний гарыг хэн нэг нь хугалсан байна. Ганц хөшөө гэлтгүй нийтийн эзэмшилийн эд зүйлсийг эвдлэн сүйтгэх явдал гарсаар байна. Хэдэн жилийн өмнө хойд замын гэрэлтүүлгийн бүрхүүлийг хамгаалах явдал гарсан бол өнгөрсөн жил шинээр хийгдсэн автобусны зогсоолыг эвдсэн тохиолдол мөн гарчээ.

Эх сурвалж: Дорнодын мэдээ. Нийтийн эзэмшилийн эд хөрөнгийг сүйтгэхээ болих хэрэгтэй. 2014 оны 12 сарын 14. <http://www.dornodmedee.mn/i/1650>



4. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймагт айлын мал маллаж буй 270 хүүхдийг хамарсан суурь судалгааг 2007 онд хийжээ. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 64 хувь нь хөвгүүд бөгөөд гуравны нэг нь өөрийн төрсөн нутгаас өөр газарт, дөрөвний нэг нь хамаатан садан биш айлд, талаас илүү хувь нь эцэг эхээсээ тусдаа амьдарч, айлын мал хариулж байв.

Эх сурвалж: Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Монгол Улсын бодлогын хураангуй: Хүүхдийн хөдөлмөр 2016 оны 6-р сар. <http://www.ilo.org/wcmsp5/>

## 1. Асуултын дагуу дээрх эх сурвалжид дүн шинжилгээ хийгээрэй

### Эх сурвалжийн тухай

Эх сурвалжийн гол зорилго юу вэ? /эх сурвалж тус бүрээр/	Эх сурвалжийн агуулга нь баримт, санаа бодол, таамаглалын алийг илэрхийлж байна вэ? /эх сурвалж тус бүрээр/	Эх сурвалжийн зохиогч нь хэн бэ? /эх сурвалж тус бүрээр/
1.	1.	1.
2.	2.	2.
3.	3.	3.
4.	4.	4.

### Эх сурвалжид хөндөж буй нийгмийн асуудлын тухай

Эх сурвалжид асуудал дэвшүүлсэн гарчиг өгөөрэй.	Эх сурвалжид хөндсэн асуудлыг хэн үүсгэж, хэнд хохирол учруулж байна вэ?	Эх сурвалжид хөндсэн асуудал шинээр үүссэн үү, олон жил үргэлжилсэн асуудал үү?
1.	1.	1.
2.	2.	2.
3.	3.	3.
4.	4.	4.

## ГОЛ САНАА

Баримт нь бодитой, тодорхой, нягтлан шалгаж болохуйц мэдээлэл юм. Жишээ нь "Хүн амын тооллогын дүнгээр Монгол улсад хүний дундаж наслалт өндөр байх тусмаа илүү сайн".

Санаа бодол нь аливаа зүйлийн талаарх итгэл үнэмшил, төсөөлөл юм. Жишээлбэл, "хүн амын дундаж наслалт өндөр байх тусмаа илүү сайн".

Таамаглал нь асуудлын учир шалтгааныг өөрт байгаа мэдээлэл, мэдлэг, туршлагад тулгуурлан дэвшигүүлсэн илэрхийлэл юм. Жишээ нь "технологийн хөгжил нь хүний дундаж наслалтыг улам нэмэгдүүлнэ".

### Хувь хүний асуудал уу, нийгмийн асуудал уу?

Олонх хүмүүс нийгмийн асуудлыг өөрийн биеэр амьдрал дээрээ мэдэрч, туулсан байдаг. Жишээ нь, өвчлөх, гэр бүлийн маргаан гарах, архи хэтрүүлэн хэрэглэх, гэмт хэрэгт өртөх гэх мэт асуудлууд олон хүмүүст тохиолддог. Бид ихэнхдээ энэ мэт тохиолдлын тухай сонсоод, зөвхөн тухайн хүмүүсийн асуудал, тэднээс өөрсдөөс нь болсон гэж боддог. Гэвч хүмүүсийн амьдралд тохиолддог олон төрлийн асуудал нь нийгмийн амьдралаас буюу орчноос хамаарсан байдгийг дахин эргэцүүлж бодоорой. Жишээлбэл, ажилгүйдлийн асуудал байна. Бид ажилгүйдлийг залхуурал, ажил хийх дадал, чадвар дутмаг, тэвчээргүй байх гэх мэтээр хувь хүнтэй холbon тайлбарлаж болно. Гэвч нийгэмд олон зуу, олон мянга, магадгүй олон сая хүн ажилгүй байгааг ю гэж тайлбарлах вэ?



Зураг 1.5 "Зам чөлөөл" аян 2016 онд иргэд нийгмийн сүлжээг ашиглан явган хүний замыг таглаж барьсан хашаа, хашлага, самбар, доежоог зарлаж, чөлөөлөхийг шаардаж буй яныг зам чөлөөл гэсэн уриан доор өрнүүлж, түүний дэгүү аж ахуйн нэгжүүд явган хүний зам таглаж барьсан хашаа, доежоогоо буулгаж эхэлсэн байна.



### Хамтран ажиллаарай

Багаараа ярилцан өөрийн орон нутагт хамгийн их тулгамдаж буй нэг асуудлыг сонгон авч, дүн шинжилгээ хийгээрэй. Ингэхдээ дараах асуултын дагуу ажиллаарай.

Асуулт	Санаа авахуйц зөвлөмж	Та бүхний бичих хэсэг
Сонгосон асуудлыг хэрхэн тодорхойлсон бэ?	Асуудлыг тодорхойлоходоо хэрэгцээ талаас нь буюу хэнд ямар бэрхшээл, хохирол, дарамт, сорилт тулгарч буйг тод харуулахыг хичээгээрэй. Жишээ нь нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн хамгаалалтыг сайжруулъя гэх нь энэ асуудлыг шийдэж болох бусад арга замыг орхигдуулж болохыг бодож үзээрэй.	

Энэ асуудлыг өмнө нь чухал гэж үзэж байсан уу, одоо бодол тань өөрчлөгдсөн үү, яагаад?	Заримдаа бидний өмнө анзаарч байгаагүй, хувь хүнээс л хамаардаг гэж боддог байсан зүйл нийгмийн асуудал байдгийг бид ойлгодог.	
Энэ асуудлыг илүү сайн ойлгохын тулд ямар мэдээлэл хэрэгтэй вэ?	Эх сурвалжид юуны тухай мэдээллийг илүү дэлгэрэнгүй оруулсан бол асуудлыг ойлгоход илүү ойлгомжтой байж болох байв гэдгийг ярилцаарай.	
Эх сурвалжийн мэдээлэл, өөрийн мэдлэг, туршлагад тулгуурлан энэ асуудал яагаад үссэн талаар ямар таамаглал дэвшүүлж болох вэ?	Яагаад гэдэг асуултыг тавьж үзээрэй. Яагаад хүмүүс ийм үйлдэл хийх болов, яагаад хүүхдүүд сургуульдаа явж чадахгүй байна вэ гэх мэт асуулт тавиарай.	
Дэвшүүлсэн таамаглалаа үнэн бодитой эсэхийг шалгах, баталж нотлоход ямар мэдээлэл, ямар судалгаа хийх хэрэгтэй вэ?	Ямар төрлийн эх сурвалжаас, юуны тухай мэдээлэл авч болохыг төсөөлөөрэй.	
Орон нутагтаа энэ асуудлыг шийдэхийн тулд та бүхэн юу хийж чадах вэ?	Асуудал бүрийг жижиг гэлтгүй өөрөө болон хамт олонтойгоо хамтарч ямар тодорхой ажил хийж, санаачилга гаргаж болох талаас нь эргэцүүлээрэй.	

**Гол санаа.** Орон нутгийн хүрээнд тулгамдаж буй асуудлын шалтгааныг сайтар ойлгож, баримт нотолгоонд тулгуурлан хамтын оролцоотой шийдэх нь үр дүнтэй юм.



### Гэртээ хийгээрэй

- Бидний өдөр тутмын амьдралын хэв маягаас үүдэн хог хаягдлын асуудал орон нутаг бүрийн тулгамдсан асуудал болж байна. Таны амьдарч буй орон нутагт энэ асуудал тулгамдаж байна уу, үүнийг хэрхэн шийдэх вэ? Энэ талаар мэдээлэл цуглуулж, боловсруулж, хүснэгт, бүдүүвч, дурслэлээр илэрхийлсэн танилцуулга бэлдээрэй.
- Нийгэм дэх тэгш бус байдлын улмаас үүдэлтэй ойрын ирээдүйд танай орон нутагт ямар асуудал тулгарч болох талаар таамаглал дэвшүүлнэ үү.
- Та орон нутагтаа тулгамдсан нэг асуудал сонгож, тухайн асуудлын учир шалтгаан, үр дагаврын талаар эсээ бичээрэй. Эсээ бичихдээ аль болох олон төрлийн мэдээллийн эх сурвалж болон өөрийн шүүмжлэлт сэтгэлгээнд тулгуурлан сайтар нягтлан бичээрэй.



## Тохиолдол шинжлээрэй



Зураг 1.6 Хүмүүсийн харилцааны олон янз байдал

- Эдгээр зурагт хүмүүсийн хооронд зөрчилдөөн үүссэнийг ямар шинж тэмдгээр хэрхэн илэрхийлсэн бэ?
- Эдгээр зурагт ямар үйл явдал өрнөж байгааг тайлбарлаж, мөн бусдын байр суурийг харьцуулж сонсоорой.
- Энэ зөрчилдөөн хэрхэн даамжирч, ямар үр дагаварт хүргэж болзошгүй вэ?
- Эдгээр зургаар харуулсан зөрчилдөөнтэй нөхцөлд та бүхэн орж байсан уу?

### Зөрчилдөөн гэж юу вэ?

Зөрчилдөөн нь талуудын сонирхол, эрх ашгийг хөндсөн санал зөрөлдөөн юм. Зөрчилдөөн нь нийгмийн харилцааны салшгүй нэг хэсэг юм. Гэхдээ зөрчилдөөн ба түүний үр дагаврыг сайтар ялгаж ойлгох нь чухал. Жишээ нь, хучирхийлэл бол зөрчилдөөн биш харин зөрчилдөөний сөрөг үр дагавар юм. Зөрчилдөөнд оролцогч талууд, тэдний зорилго, эрх ашиг, санал зөрөлдөөний улмаас талуудад учирч болох эрсдэл юу вэ гэдгийг ойлгох нь чухал. Зөрчилдөөнийг шийдвэрлэхийн тулд түүний шалтгаан, нөхцөлийг сайтар ойлгох хэрэгтэй. Зөрчилдөөн нь хүмүүсийн харилцааны алдаа, буруу ойлголцол болон нийгэм, соёлын суурь шалтгаанаас үүдэн гарч болно.

Зөрчилдөөнийг дараах байдлаар ангилан үздэг.



Бүдүүч 1.3 Зөрчилдөөний ангилал

## ?! Асуудал шийдвэрлээрэй

Дараах 2 тохиолдлын аль нэгийг сонгож зөрчилдөөнийг шийдвэрлэхийн тулд авах шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлоорой. Дүрд тоглох аргыг ашиглан бүлгээр ажиллаж болно.

**Тохиолдол 1.** Нэгэн сумын захиргаанаас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлыг сонгох зорилгоор иргэдийн хурал зохион байгуулжээ. Сумын захиргаа ирэх жил болох сумын ойн баярын арга хэмжээнд ихэнх хөрөнгийг зарцуулах санал гаргасан боловч иргэд дэмжээгүй байна. Зарим малчин иргэд тэр хөрөнгөөр худаг гаргах хэрэгтэй гэсэн бол зарим иргэд сумын төвийн халуун усны газар барих санал гаргажээ. Үлдсэн хэсэг нь сумын сургуулийн дотуур байрыг засварлах санал гаргажээ. Гэвч нэгдсэн саналд хүрэлгүй маргалдаар дахин хурал хийхээр болжээ.

**Тохиолдол 2.** Нэгэн орон сууцны байрны оршин суугчид доод давхарт нь ўйл ажиллагаа явуулдаг караоке баарны талаар холбогдох газарт болон эзэнд нь гомдол гаргасан боловч ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. Оройн цагаар хүмүүс гэртээ амарч байх үетэй давхцан чанга дуу хөгжим хангинаж, олон хүмүүс хөлхөх гэх мэтээр тав тухыг нь алдуулдаг байна. Үндууцаж бухимдсан зарим оршин суугч баарны эзэнтэй маргаход цагдаа ирж зохицуулж байжээ.

- Зөрчилдөөний учир шалтгааныг сайтар ойлгохын тулд юу хийх вэ?
- Зөрчилдөөнийг шийдэх арга замуудыг олохын тулд юу хийх вэ?
- Дахиж энэ асуудлаар талуудын хооронд зөрчилдөөн гарахгүй байлгахын тулд юу хийх вэ?

### Зөрчилдөөнийг шийдвэрлэх нь

Зөрчилдөөнийг шийдвэрлэх зорилгоор зөрчилдэж буй шалтгааныг нээлттэй авч хэлэлцэн хоёр тал хүлээн авахаар нааштай шийдлийг эрж хайх, зөвшилцөх боломжит арга барилыг сонгож болно. Хэрэв шаардлагатай гэж үзвэл, харилцан хүлээн зөвшөөрсөн шийдлээ гэрээ хэлбэрт оруулан гарын үсэг зурж баталгаажуулдаг. Талууд нэгдсэн шийдэлд хүрч чадахгүй байгаа тохиолдолд хөндлөнгийн эвлэрүүлэн зуучлагчийн тусламж авч болно. Эвлэрүүлэн зуучлагч нь маргалдагч талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх, хэлцэл хийхэд туслах үүрэг хүлээдэг.


Бүдүүч 1.4 Зөрчилдөөнийг шийдвэрлэх алхмууд





## Гэртээ хийгээрэй

- Нэг өдрийн турш өөрийн орон нутаг, сургуулийн орчинд үүсэж буй маргаан, зөрчилдөөнтэй асуудлыг ажиглан тэмдэглэж, оролцогч талууд, зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээлэл бүхий танилцуулга бэлтгэж ирээрэй.
- Зөрчилдөөнийг шийдвэрлэх олон янзын хандлага бий. Үүнийг АНУ-ын судлаач К.Томас, Р.Киллман нар талуудын хамтран ажиллах сонирхол, асуудлыг шийдэх хүсэл эрмэлзэл хэр зэрэг байгаагаар нь ангилан үзжээ. Та бүхэн Томас-Киллманы загварын дагуу зөрчилдөөнийг шийдвэрлэх тухай өөрийн хандлагыг тодорхойлоорой.



Бүдүүеч 1.5 Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас-Киллманы заагвар

- Зайлсхийх:** Зөрчилдөөний гадуур үлдэх, төвийг сахих
- Сөргөлдөх:** Бусдын санал бодлыг үл ойшоох, өөрийн зорилтыг л урьтал болгох
- Буулт хийх:** Өөрийн итгэл үнэмшил, байр сууринаас ухрах, татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх
- Хамтран ажиллах:** Аль аль талдаа таатай үр дүнд хүрэхийг эрмэлзэх

- Харилцан буулт хийх:** Хэллэлцэн тохиролцож, харилцан таатай үр дүнд хүрэхийг эрмэлзэх

## 1.3. ОРОН НУТАГТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ХҮҮХДҮҮД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ НЬ



## Тохиолдол шинжлээрэй



### Келвин До

Келвин 1996 онд Африкийн Сиаппа Леон улсын хөдөөгийн нэгэн тосгонд төржээ. Түүний өсөж төрсөн орчин дайн дажинд нэрвэгдсэн, ядуу тарчиг байв. Тэрээр 11 настай байхаас бие даан инженерийн ухаанд суралцаж, мөн өөрийн богино долгионы радио ажиллуулж байжээ. Келвин элдэв төрлийн хаягдал, металл эд ангиуд цуглувулж зайд, радио дамжуулагч, дуу өсгөгч зэрэг радио ажиллуулахад хэрэгтэй төхөөрөмжүүд зохион бүтээжээ. Эмээ, ээж нь түүнийг хог түүлээ гэж ихэд дургүйцдэг байсан гэдэг. Түүний хаягдал эд анги ашиглан шинээр бүтээсэн цахилгаан үүсгүүр үндэсний зохион бүтээгчдийн уралдаанд түрүүлж, энэ мэдээ

нийгмийн сүлжээгээр тарж, түүний талаар хүн болгон мэдэх болжээ. Келвин 16 настайдаа АНУ-ын Харвардын их сургуульд уригдан бүтээлээ танилцуулсан юм. Тэрээр одоо орон нутагтаа өөрийн инженерийн компани байгуулан ажиллуулж, шинэ бүтээгдэхүүн гаргахаар ажиллаж байна.

- Келвин орон нутаг, хөдөөгийн ямар асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулж байна вэ?
- Келвиний амьдралын орчин түүнд хэрхэн нөлөөлсөн тухай таамаглал дэвшүүлээрэй.
- Келвиний амжилтад нөлөөлсөн хувь хүний, гэр бүлийн, нийгмийн орчны нөлөөлөл юу байсан тухай таамаглал дэвшүүлж, ярилцаарай.
- Келвингийн ижил төстэй тохиолдол, түүх мэдэх бол бусадтайгаа хуваалцаарай.

Хүүхдүүд бид амьдарч буй нийгмээ өөрчилж чадна гэдэгт зарим хүмүүс эргэлздэг. “Би одоо нийгмийг өөрчилнө гэж юу байх вэ дээ” “Бид чинь хүүхдүүд шүү дээ” гэх мэтээр өөрсдийгөө чамлах тохиолдол их байдаг. Гэвч хүүхдүүд бид орон нутаг, улс орон, олон улсын түвшинд өөрчлөлт авчирч чадах тодорхой үйл ажиллагааг санаачлан үр дүнд хүрэх боломж бий. Нийгмийн бүх асуудлыг нэг месөн өөрчлөх нь бэрхшээлтэй. Харин тодорхой нэгэн асуудлыг шийдэхийн тулд зөв төлөвлөж, бусадтай хамтран ажиллах нь амжилтад хүрч байсан жишээ олон бий. Нийгмийн асуудлыг илрүүлэн, хүмүүсийн анхааралд хүргэнэ гэдэг асуудлыг шийдэхтэй нэгэн адил чухал ажил юм шүү.




### Хамтран ажиллаарай

1. Оюуны довтолгооны аргыг ашиглан сургууль, орон нутагтаа тулгамдаж буй асуудлын жагсаалт гаргаарай. Жагсаалтаа дахин ярилцаж, шийдвэрлэхэд хүүхдүүд та бүхний хувь нэмрээ оруулах боломжтой 3 асуудлыг тодруулаарай.
2. Одоо дараах үнэлгээний хүснэгтийн дагуу жагсаалт дахь 3 асуудлаа харьцуулан үзээрэй. Түүний дараа 1 асуудлыг сонгон аваарай.

Асуудал 1	Асуудал 2	Асуудал 3	Шалгуур
			Энэ асуудлыг шийдвэрлэх нь орон нутгийн хүмүүсийн амьдралд шууд, бодитой ач холбогдолтой юу?
			Энэ асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжтой юу?
			Энэ асуудлыг хүмүүс сайн мэддэг үү?
			Энэ асуудалд хүмүүс их эмзэглэж, шийдвүүлэхийг хүсдэг үү?
			Энэ асуудлын шалтгаан, нөхцөлийг ойлгох бүрэн боломжтой юу?
			Энэ асуудлыг шийдсэнээр гарах тодорхой үр дүн юу вэ?
			Энэ асуудлыг шийдвэрлэхэд хэр зэрэг мөнгө, санхүү хэрэгтэй вэ?
			Энэ асуудлыг шийдвэрлэхэд хэдий хугацаа шаардах вэ?

3. Сонгож авсан асуудлыг шийдвэрлэхд хамгийн чухал үүрэгтэй, мөн хамгийн их нөлөө үзүүлж болох хувь хүн, бүлэг, байгууллагуудыг тодорхойлж, зураглал хийгээрэй.



4. Сонгосон асуудлыг шийдвэрлэснээр тодорхой ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг сайтар ярилцаж тодорхойлоорой. Энэ нь зорилгодоо хэрхэн хүрэх аргаа тодорхойлох болон хамтран ажилласны дараа зорилгодоо хүрсэн эсэхээ дүгнэхэд зайлшгүй хэрэгтэй юм шүү.

Хүрэх үр дүн 1	
Хүрэх үр дүн 2	
Хүрэх үр дүн 3	

5. Эдгээр үр дүнд хүрэхийн тулд хийх ажлууд буюу үйл ажиллагааныхаа стратегийг ярилцаж тодорхойлоорой.

Зорилт	Цаг хугацаа	Хийх ажлууд	Нөөц боломж	Гол оролцогчид
Жишээ: Сургууль руу ирэх явган хүний замд гэрлэн дохиотой болно	Жишээ: 4 дүгээр сарын 15 гэхэд хүүхдүүдийн дунд судалгаа явуулах	Жишээ: Хорооны даргатай уулзалт хийнэ.	Жишээ: Манай багш нар биднийг дэмжиж байгаа.	Жишээ: Хот төлөвлөлтийн газар

6. Одоо хийх ажлуудаа долоо хоног тус бүрээр төлөвлөөрэй.

### 3-р долоо хоног

- ....
- ....

### 2-р долоо хоног

- ....
- ....

### 1-р долоо хоног

- ....
- ....

## Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагаа гэдэг бол өөрийн хүсэл эрмэлзлээр, үнэ хөлсгүйгээр орон нутаг нийгмийнхээ төлөө хийж байгаа ажил юм. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох, авьяас чадвараа зориулахыг хүсэж байгаа хүмүүс өөрийн ажлын болон хувийн цагаа харамгүй зарцуулдаг. Мөн тэтгэврийн насны иргэд, эмэгтэйчүүд, сургуулиасаа чөлөө аван сайн дурын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж байгаа залуучуудын тоо ихээхэн нэмэгдэж байгаа тухай олон баримт жишээ гарах болжээ.

Сайн дурын ажиллагаа нь орон нутагт, нийгэмд үр ашгаа өгөөд зогсохгүй тухайн сайн дурын ажилтанд ч зохих сайн үр нөлөө авчирдаг. Сайн дурын ажилд оролцох нь иргэний үүргээ биелүүлж, тогтвортой, иргэний нийгэм байгуулахад хувь нэмрээ оруулж байгаа хэрэг юм.



Зураг 1.7 Нийслэлийн 117 дугаар сургуулийн 7б ангиин сурагч “Эко жаал” З.Буянхишиг Сэлбэ голын дагуу жижигхэн хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлаа ангиин хоёр наиз, аавтайгаа хамтран эхлүүлж буй нь.

Сайн дурын үйлсэд хүчин зүтгэж байгаа залуучуудад өөрийгөө хөгжүүлэх, амьдарч ажиллаж буй нийгэмдээ бие хүн болон төлөвшихдээ үнэтэй дадлага, туршлага болдог байна. Хүүхэд, өсвөр үеийнхний сайн дурын үйл ажиллагаа олон чиглэлээр явагдаж болно. Үүнд:

- Ахмад настанд чиглэсэн
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн
- Хүүхэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн
- Үндэсний ба олон улсын асуудалд чиглэсэн.

### Хүснэгт 4.1 Хувь хүний сонирхол ба сайн дурын үйл ажиллагааны хувилбарууд

Хувь хүний онцлог	Сайн дурын ажлын жишээ
Олон хүмүүстэй байх дуртай бол	Марк цуглуулагчийн болон зоосон мөнгө цуглуулагчийн бүлэгт орох
Байгаль орчинд тустай ажил хийх хүсэлтэй бол	Хог дахин боловсруулах үйл ажиллагаа, цэвэрлэгээ, цэцэг мод тарих
Биеийн хөдөлгөөн хийх дуртай бол	Өөрийн чадаг спорт болон дасгал хөдөлгөөн, марафонд оролцох
Хүнд туслах дуртай бол	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд залуучуудад туслах
Урлагийн ямар нэгэн сонирхолтой бол	Дуу, шүлэг, бичлэг болон уран уншлагаар туслах (харьяа баг, хорооны цэцэрлэг болон хүүхдүүдэд) бичиг үсэг заах
Орон нутгийн олон нийтийн үйл ажиллагаанд дуртай бол	Нийгмийн халамжийн зураглал гаргах, олон төрлийн гамшигаас сэргийлэх, тусламж үзүүлэх
Гадаад хэл соёлд сонирхолтой бол	Гадаад хэлний орчуулга, монгол хэл гадаад хүнд заах, тайлбарлагч хийх

## 1.4 БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэ бүлэгт орон нутгийн нийгмийн орчин нь бидний амьдралд чухал үүрэгтэй болохыг танин мэдлээ. Бидний гэр бүл, наиз нөхөд, сургууль болон бусад нийгмийн бүлэг, байгууллагууд, тэдгээрийн хоорондын харилцаа нь уг нийгмийн орчинг тодорхойлж байдаг тухай хамтдаа судалж мэдлээ. Орон нутгийн нийгмийн орчин нь түүх, газар зүй, эдийн засаг, соёл зэрэг олон хүчин зүйлээс хамаарч хоорондоо ялаатай ажээ. Цаашид улам бүр даяаршиж байгаа дэлхий ертөнцөд орон нутгийн нийгмийн орчин хэрхэн өөрчлөгдөх талаар та бүхэн тунгаан бодоорой. Орон нутагтаа сайхан амьдрах таатай орчныг хүмүүс өөрсдөө бүтээж, сайжруулах боломж байдаг. Хүүхдүүд бид ч орон нутагтаа тулгамдаж байгаа асуудлыг жижиг гэлтгүйгээр илрүүлж, шийдвэрлэхэд нь хувь нэмрээ оруулж болохыг энэ бүлэгт үзсэн билээ.



### Хамтран ажиллаарай

Энэ бүлэгт үзсэний адилгаар өөрийн амьдарч буй сум, дүүрэг эсвэл хорооны “Орон нутгийн орчны газрын зураглал”-ыг хамтдаа хийгээрэй. Дараах асуултаас сонгож, зураглалдаа тусгаарай.

- Айл өрх болон төрөл бүрийн байгууллага, газруудын байршилд ямар нэгэн онцлог байна уу, байвал ямар учиртай байна вэ?
- Айл өрхийн оршин сууж байгаа зохион байгуулалт өөрчлөгджэй байна уу?
- Орон нутгийн иргэд хоорондоо тогтмол уулздаг, мэдээлэл солилцдог, харилцдаг ямар газрууд байна вэ?
- 5 жилийн өмнөхтэй харьцуулахад орон нутгийн орчинд ямар өөрчлөлт гарсан бэ, яагаад?
- Та бүхний бодлоор орон нутгийн хүмүүст хэрэгцээтэй ямар шинэ байгууллага, газруудыг хаана байгуулж болох вэ?
- Орон нутгийн орчинд хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй газрууд байна уу?



### Тохиолдол шинжлээрэй

Сурагчид та бүхэн дараах 2 зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх вэ? Багт хуваагдаж, дүрд тоглоорой.

**Тохиолдол.** Нэгэн орон сууцны байрны нэгдүгээр давхарт байрладаг “Бяцхан жаалууд” цэцэрлэг 10 гаруй жил ажиллажээ. Нэг өглөө байрны урд байх хоосон талбайг хашаалж барилгын ажил эхэлсэнд оршин суугчид гайхаж, тайлбар шаардан цуглажээ. Үг барилга нь “Бяцхан жаалууд” цэцэрлэгийн шинэ байр болохыг цэцэрлэгийн захирал тайлбарлаж, төрийн байгууллагын зөвшөөрөлтэй, хүүхдийн төлөө хийж буй ажил хэмээв. Гэвч оршин суугчид барилгын ажлыг зогсоохоор эсэргүүцэв.

**Тохиолдол.** Хөрш зэргэлдээ 2 сумын малчдын дунд маргаан үүсчээ. Хэдийгээр өөр өөр сумын харьят боловч малаа хариулж, зусдаг бэлчээр нь нэг ажээ. Энэ жил өмнө талын сумын зуншлага тааруу, ногооны гарц сайнгүй байсан тул хойд сумын бэлчээрт малчид малаа бэлчээв. Хойд сумын зарим малчин үүнийг эсэргүүцж

маргаан өдөөжээ.

### Дараах асуултын дагуу даалгаврыг хийгээрэй.

- Энэ зөрчилдөөний шалтгаан юу байна вэ?
- Зөрчилдөөнийг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэх вэ?
- Та бүхэн эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх хэрэгтэй болжээ. Талуудын маргааныг үр дүнтэй, шударга шийдвэрлэх арга замыг санал болгоорой.
- Маргааныг шүүн хэлэлцэх ажлын хэсэг байгуулж, талуудын байр суурь, мэтгэлцээнийг сонсоод шийдвэр гаргаарай.



### Хамтран ажиллаарай

2016 онд Нийслэлийн хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн газрын санаачилгаар өсвөр насын хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудлын талаар “Бид өсвөр үеийнхэн” цахим санал асуултыг YOLO.MN сайт болон нийгмийн сүлжээгээр дамжуулан авчээ. Та бүхэн дараах 2 асуултын хариултыг хувиар тооцон, график үүсгэж, үр дүнг дүгнэж хэлэлцээрэй. Дүгнэлтээ ангиараа ярилцаж, өөрсдийн туршлагаас хуваалцаарай.

#### 1. Чамд хүндрэлтэй асуудал тулгарвал хамгийн түрүүнд хэнд хандах вэ?

Уг асуутад найз нөхдөдөө гэж 2744 хүүхэд, сэтгэл зүйчид гэж 164 хүүхэд, эцэг, эхдээ гэж 983, эмчид гэж 111 хүүхэд, гэр бүлдээ гэж 519 хүүхэд, багшдаа гэж 34 хүүхэд, ах, эгч, хамаатныхаа дотны хүнд гэж 292 хүүхэд, нийгмийн ажилтанд гэж 20 хүүхэд тус тус хариулжээ.

#### 2. Нийгмийн идэвхтэй, оролцоотой байсны давуу тал юу вэ?

Олон шинэ зүйлийг сурч мэддэг гэж 378 хүүхэд, цагийг хөгжилтэй өнгөрөөдөг гэж 151 хүүхэд, багшид сайн танигддаг гэж 89 хүүхэд, өөрийгөө хөгжүүлэх боломж нэмэгддэг гэж 717 хүүхэд, нэр хүндтэй болдог гэж 109 хүүхэд, бусад давуу талууд гэж 112 хүүхэд хариулжээ.

#### 3. Дараах сорилд хариулж мэдлэгээ шалгаарай

	Манай орон нутагт	Мэднэ мэдэхгүй	Сайн мэдэхгүй
1	Баг, сум, хорооны эмнэлэг (өрхийн эмнэлэг) хаана байдгийг би мэднэ		
2	Анги, хамт олон, хөршөөрөө нэгдэж хийдэг ажлуудыг мэднэ.		
3	Түүх дурсгалт газруудыг нэрлэж, танилцуулж чадна.		
4	Төрийн болон олон улсын ямар байгууллагууд байдгийг мэддэг.		
5	Үйлдвэр, үйлчилгээний гол газруудын байршилыг мэднэ.		
6	Хүүхдэд зориулсан үйлчилгээ, чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг мэднэ.		
7	Айл саахалт, нэг орцны айлууд, хөршөө таньдаг.		
8	Бэртэж гэмтэх эрсдэлтэй, анхаарал болгоомжтой явах газруудыг мэднэ.		
9	Байгалийн гамшиг тохиолдвол хаана очих, ямар дүрмийг баримтлах талаар мэднэ.		
10	Аймаг, сум, хороо, дүүргийн цагдаагийн хэлтэс, тасаг хаана байрладгийг мэдэж, хэрэгтэй үед яаралтай дуудлага өгч чадна. Нийт оноо		
	Эзлэх хувь		

# III БҮЛЭГ

## ХУВЬ ХҮН БА СОЁЛ



### ТУЛГУУР ОЙЛГОЛТ


- Орон нутгийн соёл
- Соёлын үнэт зүйл
- Оюуны соёл, материаллаг соёл
- Хэм хэмжээ
- Албан ба албан бус хэм хэмжээ
- Соёлын өөрчлөлт
- Соёлын хожимдол

### ЧАДВАР, ХЭРЭГЛЭЭ

- Орон нутгийнхаа өв соёлын тухай мэдээлэлд тулгуурлан өвөрмөц байдлыг нь танилцуулж, бахархах эрмэлзлээ жишээгээр илэрхийлэх
- Хүн бусдын соёлыг ойлгох, хүндэтгэхийг илтгэх үйлдлийн төрлүүдийг нэрлэх, тайлбарлах
- Орон нутаг дахь соёлын хожимдлын асуудлыг судалж, асуудлыг шийдэхэд оруулах өөрийн хувь нэмрийг тодорхойлох

## 2.1 БИД НУТГИЙНХАА ӨВ СОЁЛООР БАХАРХДАГ

Соёлыг бүтээгч болон тээгчээс нь шалтгаалж хувь хүний, бүлэг байгууллагын, орон нутгийн, улс үндэстний, хүн төрөлхтний соёл гэж ангилдаг. Бид өмнөх ангидаа өөрийн болон гэр бүлийнхээ соёлыг судалж, хувь хүн, гэр бүл, сургуулийн соёлд хамаарах дасгал даалгавруудыг хийж байсан. Харин энэ ангидаа соёлын дурсгалт газар, соёлын хэм хэмжээ өөрчлөлтт хожимдлын асуудлыг орон нутгийн соёлын жишээн дээр судалж, холбогдох дасгал даалгавруудыг хийж гүйцэтгэх болно.



Будүүч 2.1 Ямар шалгуураар соёлыг ангилж байна вэ?

Соёл нь тухайн нийгмийг бусад нийгмээс ялгах шинж, тухайн нийгмийн хөгжлийнх нь үндэс төдийгүй хүмүүс хойч үедээ өвлүүлдэг үнэт зүйл юм. Эх хэл, бичиг үсэг, аман аялгуу, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ном судар, шастир, урлаг, эрдэм мэдлэг гэх мэт олон үнэт зүйлийг дурдаж болно.

Орон нутгийн соёлд тухайн нутгийн зон олны хөгжлийн үндэс болж буй, эрт эдүгээд эрхэмлэн дээдэлж, хойч үедээ өвлүүлэн хөгжүүлсээр ирсэн бүхий л үнэт зүйлсийг багтаан үздэг. Үүнд:

- нутгийн иргэдийн аж төрөх ёс, хэл, аялгуу, аман болон бичгийн соёл
- ёс, зан заншил, шашин шүтлэг
- дуу хөгжим, бүжиг, тэдгээрийг гүйцэтгэх арга барил
- түүх, соёлын дурсгалт газар
- ямар нэгэн үйл ажиллагааг хийх арга барил, туршлага, дадал чадвар
- соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, бүтээх, эзэмших, ашиглах, түгээн дэлгэрүүлэх, нийтийн хүртээл болгоотой холбоотой бүхий л үйл ажиллагаа багтана.

Тухайн нутаг дэвсгэрийн хөгжил, бүтээн байгуулалт, нутгийн удирдлага, сургууль, цэцэрлэг, амралт сувиллын газар, орон нутгийн телевиз, радио, сонин, хэвлэлийн газар, соёл амралтын болон амьтны хүрээлэн, спорт клубийн үйл ажиллагаа гэх мэт соёлын үйл ажиллагаа эрхэлдэг олон байгууллага бий. Номын санч, багш, архивч, зохиолч, сэтгүүлч, бүжигчин, бүжиг дэглээч, жүжигчин, зураач, гар урлаач, ой хамгаалагч гэх мэт соёлыг бүтээх бас хамгаалахтай холбоотой олон мэргэжил байдаг.

Аливаа улс орны үнэт баялаг нь хүн мөн. Тэгэхээр хүний хөгжих бололцоо орчин хэр зэрэг бүрдсэн, хүн амын өсөлт, эрүүл мэнд, амьдралын түвшин ямар байгаа зэрэг үзүүлэлт нь тухайн орон нутгийн соёлын чухал үзүүлэлт болдог. Манай улсад сүүлийн жилүүдэд шилжилт хөдөлгөөн эрчимтэй явагдаж байна. Шилжин явагчдын дийлэнх нь Улаанбаатар хот болон төвийн бүсийн аймгуудад ирж суурьшдаг. Эдгээ манай улсын хүн амын тал орчим хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Энэ нь тухайн орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байр, их дээд сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэтээр манай орны бус нутгуудын соёл, хөгжлийн түвшин харилцан адилгүй байгаатай холбоотой юм. Иймд иргэд өөрийн төрж өссөн нутаг орондоо тав тухтай, тогтвортой оршин суух нөхцөлийг бүрдүүлэх нь аль ч аймаг, сумын хөгжлийн бодлогын гол асуудал болж байна. Эдгээр асуудлаас заримыг нь дурдъя.

- мэргэжлийн ажилчид бэлтгэж, ажлын байрны хангамжийг сайжруулснаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг багасгах
- бус, аймаг, сумын бүх шатны сургалтын орчин, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
- боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх, хүүхэд залуучуудаа сургах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, соёлын ажилтнуудыг сургах төсөл, хөтөлбөртэй байх, эргээд орон нутагтаяа ажиллах боломжийг бүрдүүлэх
- эдийн засаг, нийгэм, хүн амын оршин суух таатай орчныг бүрдүүлэх, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх
- сургууль цэцэрлэг, бүх шатны сургуулийн тоог нэмэгдүүлэх, сэргээн засварлах
- сургууль цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоог нэмэгдүүлэх, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх
- түүх, соёлын дурсгалт зүйлсийг сэргээн засварлах, урлаг, соёлын өвийг сэргээх, уламжлуулан өвлүүлэх ажлыг зохион байгуулах
- рашаан сувиллуудын ашиглалтыг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх
- биеийн тамирыг бүх нийтийг эрүүлжүүлэхэд чиглүүлэн хөгжүүлэх, бус нутгийн хэмжээнд спортын ордон, танхimuудтай болох
- байгаль, орчны бохирдол, утааг багасгах, хог хаягдлыг дахин боловсруулах арга хэмжээ авах
- дулаан, цахилгаан, цэвэр усны хангамжийг нэмэгдүүлэх
- сайн дурын үндсэн дээр хөдөлмөр, хөрөнгөө нэгтгэн хоршоо, фермерийн аж ахуй, нөхөрлөл байгуулахыг дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөтгэн ажлын байрыг нэмэгдүүлэх гэх мэт.



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

Уншсан мэдээллээ ашиглан дараах асуултын дагуу ажиллана уу.

1. Мэдээллийн үндсэн утга санаа юу байв?
2. Газарзүйн хичээлээр эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан Монгол Улсын газрын зурагт зүүн бус, баруун бус, төвийн бүсийг зааж, өөрийн орон нутгийн хил хязгаарыг дүрслэн тэмдэглээрэй.
3. Дурдсан асуудлуудыг эдийн засгийн, соёлын, улс төрийн гэсэн бүлгүүдэд ангилна уу. Ямар шалгуур ашиглаж болох вэ?

4. Танай орон нутагт дээр дурдсан асуудлууд байгаа юу? Хэрвээ байгаа бол нэрлэнэ үү.
5. Нэрлэсэн асуудлуудаас аль нь хамгийн тулгамдсан асуудал вэ?
6. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, бизнесмен, малчид, сурагчдын дэм оролцоо ямар байх вэ?


Манай улсын аль ч нутагт мянга мянган жилийн өмнөх түүхийн дурсгалууд арвин бий. Судлаачид, эрдэмтэд монгол нутагт амьдарч байсан түүхийн дурсгал болох хадны сүг зураг, гэрэлт хөшөөний бичээс зэргийг тайлан уншсанаар тухайн үеийн соёлын тухай асар их мэдээллийг бий болгосон байдаг.

**Гол санаа.** Соёлын үнэт зүйлс нь эртний болон одоо үеийнхний эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлс, тэдгээртэй харьцах зан үйл, арга ухаан юм. Орон нутгийн соёлд тухайн нутгийн зон олны хөгжлийн үндэс болж буй, эрт эдүгээд эрхэмлэсээр ирсэн, бас хойч үедээ өвлүүлэн үлдээх хүсэлтэй бүхий л үнэт зүйл хамаарна.



### Хамтран ажиллаарай

Дараах бүдүүвчийг ашиглан орон нутгийнхаа соёлын талаар зураглал бүтээгээрэй. Үүнд: цэгийн оронд тухайн үнэт зүйл танай орон нутагт байдаг эсэх талаар ярилцаж, жишээ гаргаарай.




Бүдүүвч 2.2 Манай орон нутгийн үнэт зүйлс

Орон нутгийн соёл нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Аялал жуулчлал нь тухайн орон нутгийн ард түмний амьдралын хэв маяг, өв соёлтой газар дээр нь танилцдаг соёлын харилцааны онцгой хэлбэр юм. Орон нутгийнхаа баялаг өв уламжлал, ёс заншил, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлыг хайрлан хамгаалах нь тухайн орон нутгийн бодлогын нэг хэсэг болдог. Жуулчдад зориулсан гар урлал, бэлэг дурсгалын зүйлс, үзвэр, үйлчилгээг бий болгох гэх мэт арга хэмжээ

нь орон нутгийн соёлыг дэлхий нийтэд таниулах, сурталчлах, орон нутагтаа шинэ ажлын байр, бизнес үүсэх боломж төдийгүй, нутгийн хүмүүс өөрийн соёлоор бахархах бахархлыг улам нэмэгдүүлэх ач холбогдолтой.

**Гол санаа.** Хүний болон хүн, байгаль хоёрын харилцан үйлчлэлийн дүнд бий болсон гайхамшигт бүтээл, бүх талын ач холбогдол бүхий түүхийн дурсгалт газрыг багтаасан бус нутгийг дурсгалт газар гэж нэрлэдэг. 2012 оны байдлаар ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд манай улсаас гурван газрыг бүртгэжээ. Үүнд, Увс нуурын ай сав газрыг байгалийн өвөөр, Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, Монгол Алтайн хадны сүг зургийн цогцолборыг түүх соёлын дурсгалт газраар тус тус бүртгэжээ.

Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль зэрэгт түүх, соёлын өв, дурсгалт зүйлс, археологийн дурсгалыг арчлах, хадгалах, өвлүүлэх, санамсаргүй байдлаар илэрсэн тохиолдолд хувь хүн болон нийслэл, орон нутгийн бүх хүн, байгууллага хяналт тавих, хамгаалах үүрэгтэйг заасан байdag.



Бүдүүвч 2.3 Соёлыг ийнхүү ангилах шалгуур нь юу вэ?

Соёл нь биет (материаллаг) ба биет бус (оюуны) гэсэн хоёр хэлбэртэй. Материаллаг соёлд байшин барилга, хөшөө дурсгал, археологийн олдвор, машин техник гэх мэт тодорхой биет зүйлс хамаардаг. Оюуны соёлд шашин, домог үлгэр, зан заншил, баяр наадам, шинжлэх ухаан, мэдлэг, боловсрол, урлаг гэх мэт биетээр оршин байх боломжгүй, зөвхөн хүний оюун санаагаар дамжин өвлөгддөг зүйлсийг багтаадаг.



### Бие дааж ажиллаарай

Уншсан мэдээллээ ашиглаад дараах даалгаврыг хийгээрэй.


1. Орон нутгийн соёл гэдгийг өөрийн үгээр тайлбарлаарай.
2. Танай орон нутгийн гол бахархал болсон үнэт зүйл юу вэ?
3. Соёл (а), материаллаг соёл (б), оюуны соёл (в) гэсэн ойлголтуудын хамаарлыг зөв үзүүлсэн бүдүүвч аль нь вэ? Сонгосон бүдүүвчийнхээ дагуу жишээ гарган тайлбарлаарай.

Бүдүүвч 1.	Бүдүүвч 2.	Бүдүүвч 3.



## Хамтран ажиллаарай

**Тохиолдол.** Би зуны амралтаараа хөдөө амарч байлаа. Нэгэн өдөр автобус хөлөглөсөн жуулчид манай гадаа ирэв. Хөтөч монгол эмэгтэй надад “Солонгос улсын жуулчид танай нутгаар аялж явна. Миний дүү орон нутгийнхаа түүхэн дурсгалт газар, зан заншил, бэлгэдлийн талаар мэдээлэл бэлтгэж өгнө үү” гэж хүссэн юм. Жуулчдад зориулсан мэдээлэл бэлтгэхдээ “Бид орон нутгийнхаа түүх, соёлоор бахархдаг” сэдэвт зургийг ашиглаарай гээд дараах зургийг надад өглөө. Ингээд би саахалт айлынхаа 2 хүүхдийн хамтаар жуулчдад зориулсан танилцуулга мэдээлэл бэлтгэх боллоо.



Зураг 2.1 Бидний орон нутаг

Туршилтын ажлын зөвлөмж:

- Багаар ажиллана. Эхлээд орон нутгийнхаа соёлын үнэт зүйлсийн жагсаалт гаргана. Тухайлбал, түүхэн хүмүүсийн хөшөө дурсгал, төв талбай, тусгай хамгаалалттай газар, домог, бэлгэдэл гэх мэт. Зурагт жишээ болгон Архангай аймгийн нутагт орших дурсгалт газруудын зургаас үзүүлж байна.
- Уг жагсаалтаас өөрсдийнхээ танилцуулж чадах үнэт зүйлийг сонгон “Бид орон нутгийнхаа түүх, соёлоор бахархдаг” сэдвээр танилцуулга бэлтгээрэй.
- Танилцуулгад уг бүтээл ямар түүхийг өгүүлдэг, яагаад хайрлан хамгаалах, бахархах ёстой талаар мэдээлэл оруулна.



## Гэртээ хийгээрэй

Даалгавраас аль нэгийг сонгон хийгээрэй.

- Өгөгдсөн загварын дагуу орон нутгийнхаа соёлын дурсгалт газруудын байршлын зураглал боловсруулаарай

**Зөвлөмж:** Эдгээр дурсгалт газрын үнэ цэн ач холбогдлыг 2-3 өгүүлбэрт багтаан бичээрэй.

Байршлын тэмдэглэгээ, нэр	Таних тэмдэг
	Овоо, тахилгатай уул, Дархан цаазтай болон дэлхийн байгалийн өв Тусгай хамгаалалттай газар Музей Түүхэн дурсгалт газар Хөшөө, дурсгал

2. “Бид орон нутгийнхаа соёлоор бахархдаг” сэдвээр өмнө бэлтгэсэн танилцуулгаа баяжуулан илтгэл бэлтгэж хэлэлцүүлэх. Хэмжээ А4-ын 2 нүүрт багтана.

### Зөвлөмж:

- “Бид орон нутгийнхаа түүх, соёлоор бахархдаг” сэдвийн хүрээнд өөрийн танилцуулсан соёлын үнэт зүйлд холбогдох мэдээлэл нэмж цуглуулна. Ном, сурх бичиг, судалгааны материал, нутгийн иргэдийн дунд тархсан аман түүх, домог яриа, цахим мэдээллийн хэрэгсэл гэх мэт эх сурвалжуудыг ашиглана.
- Соёлын үнэт зүйл болон цуглуулсан мэдээ баримтдаа тулгуурлан илтгэлийн сэдвийг томьёолно.
- Сэдэвтэйгээ уялдуулан илтгэлийнхээ зорилгыг нэг өгүүлбэрээр бичнэ.
- Дэвшүүлсэн зорилгын дагуу үндсэн хэсгээ бичнэ. Цуглуулсан мэдээ, баримтаасаа эшлэл аваарай.
- Илтгэлийн төгсгөлд дэвшүүлсэн зорилгын биелэлт буюу дүгнэлтээ 2-3 өгүүлбэрээр бичнэ.
- Дүгнэлтийн дор 2 мөр зайд авч “Ном зүй” гэж гарчиг тавиад ашигласан ном, сурх бичиг, мэдээ, баримтадаа цагаан толгойн үсгийн дарааллын дагуу жагсаан бичнэ. Хэрвээ цахим эх сурвалж ашигласан бол хаягийг ном зүйн хэсгийнхээ дараа бичнэ.
- Илтгэлээ хэлэлцүүлнэ. Илтгэлтэй холбоотой асуултад хариулна.

## 2.2. СОЁЛ БОЛ ХЭМ ХЭМЖЭЭ МӨН

Соёл нь нийт хүн төрөлхтний зүгээс хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээхийг хүсэж байдаг үнэт зүйлс мөн гэдгийг орон нутгийн соёлын хүрээнд авч үзлээ. Харин энэ удаа соёлыг хэм хэмжээ болох талаас нь судлан, амьдарч аж төрж буй орчиндоо хэрхэн биеэ авч явах, бусдын соёлд хэрхэн хандах талаар судлах болно.

Хүмүүс бүхий л амьдралынхаа турш ямар нэг соёлын орчинд амьдарч байдаг. Харин тэрхүү соёл нь өдөр тутмын харилцааны хэм хэмжээг өөртөө агуулж байдаг. Тухайлбал, зөв боловсон яриа, даруу төлөв, тусч, хөдөлмөрч, хичээнгүй, нямбай, хашир хянамгай, бусдыг хүндэлдэг, туйлбартай тэвчээртэй гэх мэтээр биеэ зөв авч явах ёс зэрэг нь бидний өдөр тутмын баримталдаг хэм хэмжээ, хувийн соёл юм. Бас орчноо цэвэр байлгах, хичээл сургуульдаа явах, амарч зугаалах зэрэг бүх

үйлдэлд өөрийн гэсэн хэм хэмжээ бий. Жишээ нь, замын хөдөлгөөний соёл нь зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой бөгөөд иргэн бүрийн эрхэм үүрэг болж байдаг. Бидний аливаа үйл хэм хэмжээ шаардаж байдаг учраас бид хэн нэгний авир үйлдэлд “соёлтой”, “соёлгүй”, “бүдүүлэг” гэсэн ойлголтуудыг хэрэглэн үнэлгээ өгөх нь бий. Өөрөөр хэлбэл, соёл нь хүнд буй эерэг, зохистой, бас төлөв төрхгүй, зохисгүй шинж байдлын хэмжүүр, үйлдлийн удирдамж болж байна гэсэн үг.

Иймд соёл нь нийгмийн бүх гишүүдийн даган мөрддөг эрхэм чанар, хэм хэмжээг илэрхийлж байдаг. Тухайлбал, үнэнч шударга байх, хүмүүнлэг байх, нэр төрөө эрхэмлэх, ахмад үеэ хүндлэх, байгаль орчноо хайрлах зэрэг нь бидний ямагт эрхэмлэдэг хэм хэмжээ билээ. Хэрэв үнэнч байхыг эрхэмд үзвэл түүнээс хазайхыг урвалт, худал хуурмаг гэж шүүмжилнэ, хэрвээ цэвэр нямбай байхыг эрхэмд үзвэл бохир заваан байхыг арчаагүй байдал гэж үнэ. Мөн түүнчлэн цахилгаан, усаа ариг гамтай хэрэглэх, ахуй үйлчилгээний хөлс мөнгөө цаг хугацаанд нь төлөх, радио, телевизийнхээ дууг шөнийн цагт хэт чангалахгүй байх, орцны түлхүүрээ байнга авч явах, айл хөрштэйгээ найрсаг харилцах гэх мэт оршин сууж буй газартаа ч бид ямагт хэм хэмжээг баримталж байдаг.

**Гол санаа.** Өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил, уламжлал тэргүүтнийг бүхэлд нь хүмүүсийн харилцаа, нийгмийн дэг журмыг зохицуулж байдаг хэм хэмжээ гэдэг. Тэдгээр нь зөв боловсон хувцаслах, зөв ярих дүрэм журмаас эхлээд муу үйл үйлдэж болохгүй гэдэг сургаал хүртэл өргөн хүрээг хамардаг. Энэ утгаараа хэм хэмжээ нь хувь хүн, бүлэг байгууллага, нийгмийн соёлыг илтгэн харуулдаг гол үзүүлэлт мөн.



Зарим хэм хэмжээг мөрдөж буй эсэхийг гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагсад нь хянана. Жишээлбэл, сургач хичээл дээр үймүүлбэл, найз нөхөд болон багш нь анхааруулна, харин ажилтан ажилдаа хоцрох нь цалингаа хасуулахад хүргэнэ гэх мэт. Зарим хэм хэмжээг хэрхэн баримталж буйг төр хянана. Жишээлбэл, манай улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль үйлчилдэг. Хэрвээ хэн нэгэн гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж байгааг мэдсэн тохиолдолд хүмүүс иргэний үүргээ илрүүлж энэ талаар зохих байгууллагад мэдэгдэх гэх мэт.



### Бие дааж ажиллаарай

Дээрх мэдээлэлд тулгуурлан дараах асуултад хариулаарай.


- Соёл бол хэм хэмжээ мөн гэжээ. Энэ нотолгоонд үндэслэл гаргаарай.
- Хэм хэмжээ ба соёл гэсэн ойлголтууд ямар хамаарлтай вэ?
- Хэм хэмжээ /a/, соёл /b/ гэсэн ойлголтуудын хамаарлыг аль бүдүүвчээр илэрхийлж болох вэ? Яагаад





## Хамтран ажиллаарай

Та бүхэн амьдарч буй орчиндоо баримталдаг хэм хэмжээ, эрхэмлэдэг зан чанааруудаа дараах бүдүүвчид өгөгдсөн үзүүлэлтийн дагуу тоочин бичээрэй. Энэхүү даалгаврыг хийхэд жишээ болгох зорилгоор утсаар ярихдаа ямар хэм хэмжээг баримтлах хэрэгтэй вэ гэдгийг товч өгүүлсэн болно.



**Утсаар ярихдаа бидний эрхэмлэдэг хэм хэмжээ.** Утсаар ярих явцад тухайн хүний хувийн зохион байгуулалт, сахилга бат, дэг журам хялбархан танигдах болно. Утсаар ярихдаа бид дараах хэм хэмжээг баримтлах хэрэгтэй юм. Үүнд:

- Залгасан дугаарын харилцагч утсаа авахгүй тохиолдолд түүнийг залхтал залгахгүй байх.
- Эелдгээр мэндлэх, асуултад товч хариулах.
- Хичээл дээрээ утсаар ярихгүй, эсвэл оролдохгүй байх. Энэ нь зөвхөн өөрийн тэдийгүй бусдын анхаарлыг сарниулах муу талтай. Бас найз нөхдөө, хичээл орж буй багшaa үл хүндэлж буйгийн илрэл болно.
- Гудамж талбай, нийтийн тээврийн хэрэгсэл, бусдын дунд байхдаа хувийн мэдээллээ ярих нь тохиромжтой бус гэдгийг анхаарах.
- Өглөө эрт болон хэт орой утсаар ярихгүй байх. Зайлшгүй ярих шаардлага гарвал заавал хүлцэл өчиж училалт гүйж, яриагаа маш товч, тодорхой болгохыг хичээх хэрэгтэй.

Хүний орчин бол соёлын орчин юм. Бусадтай хүндэтгэлтэй харьцаж сурах нь хамгийн эрхэм чанар юм. Эс тэгвээс хүн, өөрийнхөө хийгээд орчныхоо тав тухыг алдуулна. Хүмүүстэй мэндлэх, училалт гүйх, өндөр настанд суудал тавьж өгөх, ажил, алба, хурал цуглаан, үзвэрт хожимдолгүй очих, бусдыг гоочлон хов ярихгүй байх, бусдыг төрх байдал, нэр төр, нас зүсээр нь ялгаварлахгүй байх, бусдыг сонсох, ярилцаж байгаа хүнийхээ ярианы дундуур орж үгийг нь тасалдаггүй байх гэх мэтээр өдөр тутмын харилцаа бүхэн соёлын илэрхийлэл байна.

Хувь хүн бүр онцгой нэгэн гэдгийг хүлээн зөвшөөрөх нь соёлын салшгүй хэсэг юм. Энэ нь бусдын соёлыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх байдлаар илэрнэ. Тодруулбал, арьс өнгө, угсаа гарвал, нийгэм-эдийн засгийн байдал, нас, бие махбодын чадвар, шашны болон улс төрийн итгэл үнэмшил зэрэгт хүндэтгэлтэй хандана гэсэн үг. Эдгэр ялгаа онцлогийг танин мэдэх, ойлгох боломж гагцхүү аюулгүй, зэрэг, бусдыг дэмжсэн орчинд нээгддэг. Өөрөөр хэлбэл, нэг нэгнээ харилцан ойлгох, хүлээцтэй тэвчээртэй байснаар хамтдаа урагшлах орон зай бий болох юм.


Бусдыг үзэн ядах, шударга бус хандах, үл тоох, нийгмийн хүрээнээс шахах, зайлуулах үйлдлийн улмаас хүнийг боолчлох, худалдах, ялгаварлах, аль нэг бүлэг, үндэстэн бусдаас ангид, тэргүүнд байх ёстой гэж үзэж байсан цаг үе түүхэнд байсан гэдгийг бид түүхийн хичээлээс мэдэх билээ.



### Бие дааж ажиллаарай

Соёл гэсэн үгийг хэрэглээд асуултын дагуу өөрийгөө шинжлээрэй.

- Бусадтай харилцахдаа та юуг илүү эрхэмд үздэг вэ?
- Бусадтай харилцахдаа ямар алдааг ихэвчлэн гаргадаг вэ? Энэ алдаанаас үүсдэг сөрөг үр дагавар юв вэ?
- Энэхүү алдаагаа засах талаар төлөвлөгөө гаргаарай гэвэл та хамгийн түрүүнд ямар заалтыг оруулах вэ?



Бүдүүч 2.5 Эдгээр хэм хэмжээний аль нь анхдагч вэ?

**Зан заншил:** Буруу, зөв гэж хатуу үнэлэгдэггүй, тухайлбал, үсээ самнах, хувцсаа тохируулж өмсөх, бусдын амар мэндийг асуух гэх мэт амьдралд байнга давтагдаг мөрдлөгөөнүүд, тухайн ард түмний ёс заншил багтана.

Монголчууд нутаг ус, голомтоо дээдлэх, хурим найрын ёс дэгийг баримтлах, угийн бичгээ хөтлөх, зочлох хүндлэх ёс гээд өөрсдийн аж төрөх хэв маяг болон нийгмийн харилцааг зохицуулж байдаг арвин баялаг ёс заншилтай.

**Ёс суртахуун.** Ёс суртахууны хэм хэмжээ нь худал хэлэхгүй байх, хулгай хийхгүй байх, үүрэг хариуцлагаа эрхэмлэдэг байх гэх мэт хүний зан араншин, авир үйлдлийг зохицуулдаг. Нөгөө талаас, эрх зүй, эдийн засаг, улс төр зэрэг бусад хэм хэмжээний үндэс, суурь болдог. Ёс суртахуун бол зөв буруу, сайн муу гэж үнэлэгддэг бөгөөд сайшаах, урамшуулах, шийтгэх хөшүүрэгтэй хэм хэмжээ юм. Жишээ нь, үүрэгт ажлаа цаг хугацаанд нь хийж чаддаг хүнийг хөдөлмөрч гэдэг гэх мэт.

Ёс суртахууны хэм хэмжээ албадлага хэрэглэдэггүй, сайн дурын үндсэн дээр хэрэгжиж байдгаараа онцлогтой. Тэдгээрийг дагаж мөрдүүлэх сахиулах хүч нь олон түмний сайшаах, буруутгах, дургүйцэх, цээрлэх зэрэг харилцаа юм.

**Албан хэм хэмжээ.** Энд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, дүрмүүд багтана. Албан ёсны хэм хэмжээг зөрчвэл хуульд заасан хариуцлага хүлээдэг. Тухайлбал, Монгол улсын иргэн бүр орлогоо зөв мэдүүлж татвар төлөх үүрэгтэй бөгөөд орлогоо нуун дарагдуулбал тorgуулахаас эхлээд эрүүгийн хариуцлагад татагдах хүртэл шийтгэл хүлээдэг.



### Гэртээ хийгээрэй

Бидний хэн нь ч бай өөрийгөө төлөөлж “би”, гэр бүлээ төлөөлж “манай гэр бүл”, бас төрөлх сумандаа манай багийнхан, аймагтаа манай сумынхан, нийслэлд ирэхлээр манай аймгийнхан, хилийн чанадад бол манай улс хэмээн чин сэтгэлээсээ өгүүлдэг. Тэгвэл та өөрийгөө тодорхой соёлын төлөөлөл болгон гол шинжүүдийг нэрлэнэ үү.

#### “Би” соёлын төлөөлөл болох нь

Би хэн бэ?	Намайг соёлын төлөөлөл болгож буй гол шинжүүд
Би хувь хүн.	
Би гэр бүлийн гишүүн.	
Би сургуулийн сурагч.	
Би орон нутгийн иргэн.	
Би монгол хүн.	

## 2.3. СОЁЛ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДДӨГ ВЭ?

Бид өмнөх сэдвээр хүмүүсийн амьдрах орчин болох соёл нь албан ба албан бус хэмжээгээр зохицуулагддаг болохыг судалсан. Одоо соёл хэрхэн өөрчлөгддөг, түүнд ямар хүчин зүйлс нөлөөлдөг, соёлын хожимдол түүний үр дагаврын талаар авч үзэх болно.



### Эх сурвалжтай ажиллаарай



Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.



Зураг 4.



Зураг 5.



Зураг 6.



Зураг 7.



Зураг 8.




Зураг 9.

#### Зураг 2.2 Орон нутгийн орчин

- Зураг тус бүрийн илэрхийлэх гол санааг нэг өгүүлбэрээр тайлбарлана уу. Тайлбарт соёл гэсэн үгийг заавал оруулаарай.
- Эдгээр зургийн аль нь ямар асуудлыг илэрхийлж байна вэ? Өгөгдсөн загварын дагуу эхлээд сурагч өөрөө, дараа нь багаараа ярилцан саналаа нэгтгэн бичээрэй.
- Таны бодлоор соёлын хожимдол гэсэн ойлголтыг аль зурагт хэрэглэж болох вэ? Яагаад?

Хэн	Зургаас дэвшиүүлсэн асуудлууд	Асуудал үүсэх шалтгаан юу вэ?	Асуудлыг шийдвэрлэж болох хувилбарууд
Миний бодол			
Бид ингэж ярилцлаа.			

Соёл нь хөдөлгөөнгүй зүйл бил. Соёл үүсч, хөгжиж бас доройтолд орж, нэг ард түмэн, улс орноос нөгөөд түгэн дэлгэрч, өнгөрсөн үеийнхнээс хойч үеийнхэнд уламжлагдан дамжиж, өөрчлөгдж байдаг. Ялангуяа, сүүлийн хоёр зуугаад жилийн дотор хүмүүсийн аж төрөх ёсонд асар их өөрчлөлт гарсан гэдгийг судлаачид тэмдэглэдэг. Хүн төрөлхтөн овог аймгаар амьдарч хоол хүнсний зүйлээ өөрсдөө бэлтгэж байсан цаг үе түүхэнд байсан гэдгийг та бүхэн мэднэ. Соёлын өөрчлөлтөд олон хүчин зүйл нөлөөлдөг.



Бүдүүч 2.6 Соёлын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг жишээгээр тайлбарлаарай

**Нээлт, бүтээл.** Аливаа шинэ бүтээл бол оршин байгаа соёлыг шинэ хэлбэртэй болгодог. Жишээ нь, 1876 онд телефон, 1903 онд агаарын тээвэр, XX зуунд компьютерийг бүтээсэн нь хүн төрөлхтний амьдрал соёлын хэв маяг, харилцаанд онцгой өөрчлөлт оруулсан билээ. Бас од гараг, эрхэс, байгалийн нууцыг танин мэдэхээс эхлээд хоол хүнсний технологи гээд шинжлэх ухааны нээлт, ололт олныг дурдаж болно. Урлаг, спортын амжилтууд ч соёлын өөрчлөлт, хөгжлийн илрэл юм.

**Соёлуудын харилцан нөлөөлөл, нэвчилтийн үйл явц.** Соёлын зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явцыг соёлын нэвчилт гэдэг. Жишээ нь, манай ард түмэн эрт дээр үеэс нүүдлийн соёл уламжлалаа хадгалсаар ирсэн билээ. XVII-XIX зууны эхэн үе хүртэл Монголд буддын шашин хүчтэй дэлгэрч, хүрээ хийдийн хэдэн зуун төвүүд байгуулагдсаныар хүн амын тодорхой хэсэг суурин маягаар аж төрөх эхлэл тавигдсан байдаг. Социалист бүтээн байгуулалтын үед дэлхийн соёлын ололтуудыг эх орондоо түгээн дэлгэрүүлэх, барилга, хот байгуулалт, урлаг, шинжлэх ухаан, боловсрол зэрэг олон салбарыг хөгжүүлэх талаар ихээхэн амжилтад хүрсэн байдаг. Үүний зэрэгцээ кирилл бичигтэй болсон, шинэ жилийн баярыг тэмдэглэдэг болсон, бас сүм хийд, ном судраа устгасан зэрэг өөрчлөлтүүд бол соёлын харилцан нөлөөлөл, нэвчилтийн жишээ юм. Эдүгээ манайд нүүдлийн болон суурьшмал иргэдийн соёл зэрэгцэн оршиж байна. 1990-ээд оноос манай улс зах зээлийн харилцаанд шилжсэнээр соёлын харилцаа улам бүр олон хэв загвараар өргөжин хөгжих болов. Өндөр хөгжилтэй улс орнуудын хэрэглээнд байгаа бүтээгдэхүүн үйлчилгээ, гар утас, интернет сүлжээ, аялал жуулчлал, загварын шоу гэх мэтээр соёлын харилцаа

улам өргөжиж байна. Хүнсний зүйл, бэлэн хувцас, өргөн хэрэглээний зүйлсийн хангамж, нийтийн хоолны газар, хувийн дээд сургууль, эмнэлэг зэрэг үйлчилгээний газрын тоо эрс нэмэгдсэн зэрэг нь иргэдийн сонголт хийх боломжийг нэмэгдүүлж байна. Ийм өөрчлөлтуудтэй зэрэгцэн язгуур соёлоороо амьдрах, өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, үндэсний соёл урлагийг олон улсын зах зээлд гаргах, хөдөөгийн хүн амд соёлын үйлчилгээг хүргэх зэрэг зорилтууд манай улсын соёлын бодлогод чухал байр суурьтай тавигдах боллоо.

**Байгаль орчны нөлөөлөл.** Хүмүүсийн амьдралын хэв маяг, соёлын өөрчлөлтөд байгалийн хүчин зүйл бас нөлөөлдөг. Жишээ нь, дэлхийн дулаарал, байгаль, цаг уурын өөрчлөлттэй холбоотой ган зудын гамшиг, цөлжилт, гол горхи, булаг шанд, нуур цөөрөм ширгэх зэрэг үзэгдэл ихэссэнээр уламжлалт мал ахуйд хандах хандлага өөрчлөгдөх, хот суурин газар шилжин суурьшигчдын тоо нэмэгдэж болно. Нөгөө талаас, байгалийн нөөцийн зүй бус хорогдол нь хүний үйлдлээс ихээхэн шалтгаалж байна. Байгаль орчин бол өнөөгийн болон хойч үеийнхний эрүүл саруул хөгжих хамгийн чухал хүчин зүйл мөн.

Соёлын өөрчлөлтүүд зарим тохиолдолд зөрчлийг бас дагуулдаг ажээ. Материаллаг хангамж, өндөр хэрэглээнд хэт их ач холбогдол өгч, мэдлэг, шударга үнэн, хүнлэг сэтгэл зэргээс илүү эрхэмд үзэх явдал гардаг байна. Зохисгүй хэрэглээ, буруу хэвшил, гэмт хэрэг, шударга бус байдал, авилга, байгаль орчинтой зүй бусаар харьцах гэх мэт үзэгдлийг нэрлэж болно. Ийм үзэгдэл ихсэхийг соёл судлалд соёлын хожимдол гэж нэрлэдэг.

Хэдийгээр соёлын хожимдол нийгмийн өөрчлөлтөд зайлшгүй илрэх дүр төрх боловч материаллаг соёлын өөрчлөлтийг дагаж материаллаг бус соёлыг зөв зохистой удирдах нь улс орон бүрийн соёлын талаарх бодлогын нэг хэсэг нь болж байдаг.

**Гол санаа.** Улс үндэстний соёлд материаллаг бүтээн босголтын зэрэгцээ хүн ардынх нь ёс суртахуун гарцаагүй чухал үүрэгтэй. Гэтэл бодит байдал дээр материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг. Үүнийг соёл судлаачид соёлын хожимдол гэж нэрлэдэг.



### Хамтран ажиллаарай

“Соёлын хожимдол нь зайлшгүй үзэгдэл мөн” сэдвээр мэтгэлцээрэй.


“Тийм” гэж үзэж байгаа сурагчид нэг тал болж нотолгоо гаргах, “Үгүй” гэж үзэж байгаа сурагчид нэг тал болж няцаалт гарган мэтгэлцэнэ.

## ?! Асуудал шийдвэрлээрэй

“Асуудлын мод” аргаар амьдарч буй орон нутгийнхаа соёл хэрхэн өөрчлөгджөк буйг илэрхийлээрэй. Багаар ажиллана.

“Асуудлын модыг” ажиллах аргачлал:

1. Том цаасан дээр ургаж байгаа мод зурна. (Зураг 2. Асуудлын мод.)
2. Модны их биед орон нутгийн түвшинд тулгамдсан, шийдэж болох нэг асуудлыг бичнэ. Тухайлбал, нутгийн аялгаар ярьдаг хүмүүс цөөрч байна, хөшөө, дурсгал эвдэрсэн, түүхээ мэдэх хүмүүс цөөрч байна, хүүхдүүд түүх, ёс заншлаа судлахыг хүсдэггүй, хайрлан хамгаалахын чухлыг ухаарагхгүй байна гэх мэт.



Бүдүүч 2.7 Асуудлын модны загвар

3. Сөрөг үр дагавраас аль нэгийг нь сонгон шийдвэрлэх арга замыг дэвшүүлэн ярилцаарай.



## Гэртээ хийгээрэй

Дараах даалгавруудаас нэгийг сонгон хийгээрэй

1. Орон нутгийн соёлд иргэдийн оролцоо ямар байх талаар хүмүүстэй ярилцаж санал цуглуулах
2. Дүүрэг, хорооныхоо (сумынхаа) нутаг дэвсгэрт байрлах музей үзэж, монгол өв соёлоо хадгалан хамгаалж, хойч үедээ үлдээхийн ач холбогдлыг хамгийн чухал гэсэн 3 үзүүлэлтээр тайлбарлах
3. “Олны хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтнэ”  
“Олны хүч оломгүй далай”  
“Олзыг олуулаа” гэсэн зүйр үгсийг орон нутгийнхаа соёлыг хадгалах, хамгаалах асуудалтай холбон ярилцлагын асуулга бэлтгэж, ярилцлага авч үр дүнг нь нэгтгэн дүгнэх
4. Сүүлийн жилүүдэд танай орон нутгийн соёл хэрхэн өөрчлөгджөк байгаа талаар жишээ баримт дурдаж шалтгааныг тайлбарлах

5. Орон нутагтаа илэрч буй соёлын хожимдлын тодорхой жишээ авч түүний шалтгаан үр дагаврыг тодруулан дүгнэлт хийж танилцуулах
6. “Би төрсөн нутгаараа бахархдаг” сэдвээр 8 мөрт шүлэг зохиох
7. Нутаг усныхаа тухай дуу эсвэл шүлгийн утга агуулгыг задлан шинжилж зургаар илэрхийлэх

## 2.4. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Та бүхэн энэхүү бүлгээр янз бүрийн дасгал даалгавар ажиллаж соёл бол үнэт зүйл бас хэм хэмжээ болохыг орон нутгийн жишээн дээр судаллаа. Үнэт зүйл, соёлын хожимдол, албан болон албан бус хэм хэмжээ, материаллаг ба оюуны соёл, соёлын нэвчилт зэрэг ойлголтуудын утга холбогдолтой танилцлаа.

Соёл нь нийт хүн төрөлхтний зүгээс хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээхийг хүсэж байдаг үнэт зүйлс, бас өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, ёс заншил, уламжлалыг зохицуулж байдаг хэм хэмжээ мөн.

Соёл бол тогтвортой зүйл биш. Тэр үүсч, хөгжиж, нэг ард түмэн, улс орноос негөөд түгэн дэлгэрч, өнгөрсөн үеийнхнээс хойч үеийнхэнд уламжлагдан дамжиж, нэг хэсэг нь бас өөрчлөгдэж, эсвэл мартагдаж байдаг. Соёлын өөрчлөлтөд шинэ бүтээл, ололт амжилт, соёлын харилцаа, байгалийн хүчин зүйлс нөлөөлдөг.

Соёлыг хүний үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүн гэдэг утгаар нь судлаачид материаллаг ба материаллаг бус гэсэн хоёр хэлбэртэй гэж үздэг.

Дүгнэлт хичээлээр та бүхэн бүлгийн агуулгад нийцсэн даалгавруудыг хийж гүйцэтгэх болно. Энэ нь мэдлэг, чадвараа бататгах, гол асуудлыг эргэцүүлэн гүнзгийрүүлэх, амьдрал ахуйдаа хэрэглээ болгох, өөртэйгээ ажиллах арга, эв дүйгээ тодорхойлоход тус дөхөм болно гэдэгт найдаж байна.



### Бие дааж ажиллаарай

1. Дараах өгөгдлийг оюуны соёл, материаллаг соёл гэсэн ангилалд оруулна уу.

“Тунгалаг тамир” роман, Сүхбаатарын хөшөө, буддын шашин, хадны зураг, урлагийн тогтолт, музейд байрлах үлэг гүрвэлийн яс, шинжлэх ухаан, амьтан ургамлын чулуужсан олдвор, сүм хийдийн туурь, зан заншил, бий биелгээ

2. Аль нь соёлын хожимдлын жишээнд хамаарахгүй вэ?

Гадаадад цагаачлах, цахим тоглоомд донтох, байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдэх, уул овоо тахих, цахимаар харилцахдаа зүй бус үг хэрэглэх, шашин шүтлэг, угсаа гарвалаар нь ялгавартай хандах

3. Аль нь албан бус хэм хэмжээ вэ?

Сурагчийн дүрэмт хувцсаа өмсөх, гэрийн даалгавраа тогтмол хийх, хичээлд хожимдохгүй байх, зөв боловсон ярих, эрүүл мэнддээ анхаарах, сургуулийн дүрэм журмыг биелүүлэх

4. “Удмаа мэдэж судраа цуглуул, угаа санаж өвгөдөө асар”

“Сарны гэрлийг уул халхална, саруул ухааныг уур халхална” гэсэн зүйр үгс ямар утга илэрхийлж байна вэ? Хувь хүний соёлын ямар хэм хэмжээг илэрхийлж байна вэ?

5. Дараах сэдвээс нэгийг сонгож эсээ бичээрэй

- Би төрсөн нутгаараа бахархдаг
- Соёлын хожимдлоос сэргийлэх талаар миний бодол
- Соёл бол өдөр тутам баримталдаг хэм хэмжээ болох нь



### Хамтран ажиллаарай

Багаар ажиллан төсөл бичиж хэлэлцүүлээрэй

**Алхам 1:** Төсөл бичихийн өмнө дараах асуултын дагуу хэлэлцүүлэг хийгээрэй.

Хэлэлцүүлгийн асуулт:

- ✓ Өөрчлөн сайжруулах, шийдвэрлэх ямар асуудлууд манай орон нутгийн /баг, хороо, сум, дүүргийн/ түвшинд байна вэ?
- ✓ Аль нь хамгийн чухал асуудал вэ?
- ✓ Уг асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломж бидэнд байна уу?
- ✓ Тухайн асуудлыг шийдвэрлэхэд мөнгө санхүү шаардлагатай юу?
- ✓ Төслийн үр дүн орон нутаг, байгаль дэлхийд, хүмүүст ашигтай байх боломж юу вэ?.

**Алхам 2:** Төслөө боловсруулна. Үүнд:

1. Шийдвэрлэх асуудлаа тодорхойлоорой
2. Асуудлыг шийдвэрлэх ямар хувилбарууд байж болох вэ?
3. Асуудлыг шийдвэрлэх багийн төлөвлөгөө боловсруулах
4. Хэн ямар ажил хариуцах
5. Ямар байгууллага, албан тушаалтан, хүмүүстэй хамтран ажиллах
6. Төслийг хэрэгжүүлэх хугацаа
7. Төслийг хэрэгжүүлэхэд мөнгө санхүү хэрэгтэй эсэх
8. Төслийг хэрэгжүүлснээр ямар үр дүн гарах вэ?

**Алхам 3:** Боловсруулсан төслөө ангийнхандаа танилцуулна.

**Алхам 4:** Төсөл хэрэгжүүлэх дарааллаа төлөвлөнө.

**Алхам 5:** Төслийн хэлэлцүүлэг хийнэ. Бусад багийн гишүүд уг төслийн ололттой тал бас сайжруулах хувилбар, санааг хэлнэ.

**Алхам 6:** Сурагчид бусад багийн төслийг дараах шалгуураар үнэлнэ. Үүнд:

- Багийн хамтын ажиллагаа
- Асуудал шийдвэрлэх арга зам оновчтой эсэх
- Баримт нотолгоо, мэдээлэл цуглуулсан эсэх
- Хууль дүрэм журamtай нийцэж байгаа эсэх
- Төслийн хэрэгжих боломж, гарч болох эрсдэлийг тооцсон байдал




### Өөрийгөө сориорой


1. Оюуны соёлын жишээг зөв илэрхийлсэн мөрийг олно уу.

A	Зан заншил	Сүхбаатарын талбай	Хөгжим	Мэдлэг
Б	Зүйр үгс	Жүжиг	Шинжлэх ухаан	Шашин
В	Ном	Машин техник	Уртын дуу	Гар утас
Г	Мэдлэг	Тоглоомын талбай	Уран зураг	Үлгэр домог

2. Аль нь зөв зураглал вэ?



3. Орон нутгийнхаа соёлд хувь нэмрээ оруулж буй байгууллагуудыг нэрлэнэ үү?



### Бие дааж ажиллаарай

Хүснэгтийг бэглөөд хариултаяа дэлгэрэнгүй тайлбарлана уу

№	Та юу гэж бодож байна вэ?	Тийм	Үгүй	Тайлбар
1	Би соёлыг бүтээгч мөн.			
2	Соёлын өөрчлөлт бүхэн хөгжил байх албагүй			
3	Аялал жуулчлал бол соёлын үзэгдэл мөн.			
4	Би уламжлалт баяр ёспол, зан үйлээ өвлөж авч чадаж байгаа			
5	Хүн бүр бусдад тус болохыг хичээх шаардлагагүй			

# ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

## БҮЛЭГ



### ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Орон нутгийн эдийн засаг, эдийн засгийн бүтэц, баялаг, аж ахуйн нэгж, орон нутгийн төсөв, орлого, зарлага, татвар.
- Орон нутгийн зах зээл, зах зээлийн харилцаа, эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэр
- Жижиг бизнесийн төсөл, бизнес санаа, бизнесийн зорилго, чиглэл, санхүүгийн тооцоо

### ЧАДВАР, ХЭРЭГЛЭЭ

- Орон нутгийнхаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах, үр дүнг илтгэх
- Орон нутгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг судалж, зах зээлийн талаар ойлголттой болох
- Жижиг бизнесийн төслийн санаа гаргах, танилцуулах

### 3.1. ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ТАЛААР БИД ЮУ МЭДЭХ ВЭ?

Бид өмнөх ангид үзсэн эдийн засгийн хичээлээр өөрийн болон өрх гэрийн хэрэгцээ, түүнийг хангах өрхийн орлого ба нөөц хязгаарлагдмал болох, өрх гэрийн гишүүдийн хөдөлмөрийн хуваарь, түүнд оролцох өөрийн хувь нэмрийн тухай судалсан билээ. Энэ бүлэг сэдвээр өөрийн амьдарч байгаа орон нутгийнхаа эдийн засгийн бүтцэц, тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар судалж мэдэх болно.




#### Эх сурвалжтай ажиллаарай

Өсөж төрсөн нутагтаа сайхан амьдрах хүсэлтэй олон хүн хөдөө орон нутагт амьдарч байна. Гэвч манай улсын сум, орон нутгийн эдийн засгийн хөгжил удаашралтай байгаагаас, иргэд хот руу тэмүүлж, хөдөө нутаг улам бүр эзгүйрсээр байна.

Орон нутгийн эрх мэдлийг иргэдийн оролцоотой нэмэгдүүлснээр тухайн орон нутгийн эдийн засгийн өсөлт нэмэгддэг гэсэн судалгааг АНУ-ын эрдэмтэд дэлхийн 52 орны жишиг судлан тогтоосон байна. Иймээс орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд тухайн орон нутгийн иргэдийн оролцоо маш чухал юм .

Эх сурвалж: МУХАҮТ,(2016).Орон нутгийн хөгжлийн сангиин бодлого. [www.khural.mn/n/8tkon](http://www.khural.mn/n/8tkon)



#### Эргэцүүлэн хэлэлцээрэй

1. Та нар дээрх эх сурвалжийг уншаад дараах асуултад хариулна уу.
  - Дээрх эх сурвалжид ямар асуудлууд хөндөгдсөн байгааг хосоороо хэлэлцээрэй. Танай орон нутаг, сум дүүрэг, баг хороонд дээрхтэй төстэй асуудал бий юу? Та нар юу гэж бодож байна вэ?

- Орон нутгийн эдийн засаг гэж юу вэ?
  - Орон нутгийн эдийн засгийн бүтцэд ямар ямар салбар орж байгааг нэрлэнэ үү.
2. Төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн ажил үүргийн онцлог, ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг болохыг дараах хүснэгтийг бөглөхдөө тодорхойлоорой. /Хүснэгтийг бөглөхдөө тухайн төрөл бүрдээр нэг байгууллагыг сонгоорой./

### Хүснэгт 3.1 Байгууллагын хэлбэр

Байгууллагын хэлбэр	Байгууллагын нэр	Ямар үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг болох.	Голлон ажилладаг хүмүүсийн мэргэжил
Төрийн байгууллага			
Төрийн бус байгууллага			
Аж аж ахуйн нэгж			

Орон нутаг гэдэг нь газар зүйн байршил төдийгүй эрх мэдэл, түүний хүрээ хязгаарыг илэрхийлдэг ойлголт юм. Орон нутгийн эдийн засаг гэдэг нь тухайн орон нутгийн хүн ам, баялаг бүтээх, орон нутгаа хөгжүүлэх тухай багц асуудлыг багтаана. Үүнд:

1. Хүн ам, эдийн засгийн бүтэц, аж ахуй эрхлэлт
2. Засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээний байгууллагуудын хэлбэр
3. Орон нутгийн зах зээлийн харилцаа
4. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын асуудал орно.

Монгол улсын Үндсэн хуульд “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн амьдралыг бие даан шийдвэрлэх ба уг асуудлыг шийдвэрлэхдээ хүн амыг зохион байгуулж оролцуулна” хэмээн хуульчилсан байдаг. |Эх сурвалж: МУ-ЫН Үндсэн хуулийн 62-р зүйл|

Хүн амын орон нутагт таран суурьшсан байдал нь орон нутгийн эдийн засагт чухал нөлөөтэй. Хүн амын бөөгнөрөл хот суурин газар их байхад хөдөө орон нутагт бага байна. Хүн амын бөөгнөрөл ихсэх тусам эдийн засгийн бүтэц томрох нь ойлгомжтой. Тухайн орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд баялгийг бий болгодог. Баялгийг бүтээж байгаа салбараар нь дараах байдлаар ангилна. Үүнд:



Зураг 3.1 Эдийн засгийн салбар

**Гол санаа.** Орон нутгийн эдийн засаг гэдэг нь аймаг нийслэл, сум дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэр дэх хүн ам, аж ахуй эрхлэлт, эдийн засгийн бүтэц, зах зээлийн харилцаа, орон нутгийн орлоготой холбоотой багц асуудлыг багтаана.

Хүмүүс нэг газар нутагт амьдрах хэв маяг, ёс заншлаараа ижилсэн хамтран амьдрах явцдаа бие биеийнхээ хэрэгцээг хангах зорилгоор өөрийн хүсэл сонирхол, мэргэжил болон өөртөө байгаа нөөцдөө тохируулан олон янзын ажил үйлчилгээ эрхэлж, орлого олж хэрэгцээгээ хангаж байдаг. Нэг хэсэг нь мал маллаж, үйлдвэрлэл эрхлэн мах, сүү, хувцас, талх, тоног төхөөрөмж зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байхад нөгөө хэсэг нь сурч мэдэх, эрүүл байх гэх мэт хэрэгцээг хангах зорилгоор боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байдаг. Эндээс байгууллагын янз бүрийн төрлүүд үүсдэг. Байгууллагуудын үйл ажиллагааны онцлогийг дараах хүснэгтээс харж болно.

#### Хүснэгт 3.2 Байгууллагын үйл ажиллагааны онцлог

№	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагааны онцлог
1	Төрийн байгууллага	Төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүргэж байдаг, төсвөөс санхүүждэг байгууллага (засаг даргын тамгын газар, сургууль, эмнэлэг гэх мэт)
2	Төрийн бус байгууллага	Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр нэгдэн үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага (үйлдвэрчний эвлэл, залуучуудын холбоо, хүүхдийн эрхийг хамгаалах төв гэх мэт)
3	Аж ахуйн нэгж	Улсын буртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагууд орно. Тэдний зорилго нь ашиг олоход оршино. (үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарууд)

**Гол санаа.** Орон нутгийн эдийн засгийн чадавхыг харуулах чухал үзүүлэлт болох баялгийг аж ахуйн нэгжүүд бий болгож байдаг.



#### Хамтран ажиллаарай

Сурагч “Б” Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт оршин суудаг ажээ. Тэр Open street map буюу Нээлттэй газрын зураг хэмээх цахим газрын зургийг ашиглан өөрийн гэрийн ойролцоо үйлдвэрлэл үйлчилгээний газруудыг олж мэджээ. Гэхдээ аль нь эдийн засгийн ямар үйл ажиллагаа явуулдаг болохыг мэдэхгүй байна. Түүнд туслаарай хүүхдүүд ээ.

Зураг 3.2 Сүхбаатар дүүргийн 7-р хорооны орчны зураг



- Сурагч “Б”-ийн гэрийн ойролцоо байгууллагуудыг ямар төрөлд хамаарахыг ангилаарай.
- Аль нэг байгууллагыг сонгон авч уг байгууллагын бүтэц зохион байгуулалтын бүдүүчийг зураарай.



Аж ахуйн нэгжүүд дараах хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

**1. Үйлдвэрлэл:** Хэрэглэгчдийн хэрэгцээ хангах чадвартай материаллаг биет зүйлс үйлдвэрлэн гаргана. (талх, гутал, ном, машин г.м)



**2. Худалдаа:** Төрөл бүрийн бараа худалдан авч хадгалах, тээвэрлэх, худалдах үйл явц. Гол анхаарах зүйл бол худалдах үнэ нь худалдан авсан үнээсээ өндөр байж чадах барааг худалдан авахад оршино. (дэлгүүр, супермаркет, барааны зах г.м)



**3. Үйлчилгээ:** Хүмүүсийн хэрэгцээг хангах зорилготой бодит бус шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд багтана. (зочид буудал, сургууль, эмнэлэг, үсчин, зурагчин, төрөл бүрийн засвар, зөвлөгөө өгөх г.м)

Зураг 3.3 Аж ахуй нэгжийн төрлүүд



### Эх сурвалжтай ажиллаарай

#### Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймаг 2015 оны байдлаар 112,5 мянган хүн амтай, 4200.0 гаруй мянган толгой малтай ба 407,7 тэрбум төгрөгийн баялаг бий болгожээ. Аймгийн үйлдвэрлэсэн нийт баялгийн 53% нь ХАА, 14% нь аж үйлдвэр, барилга, 16% нь үйлчилгээний салбар, үлдэх 17 % нь бусад салбарт ноогдож байна.

Өвөрхангай аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь хөдөө аж ахуй бөгөөд нийт малын тоогоор улсад дөрөвдүгээрт, ямааны тоогоороо хоёрдугаар байр эзэлдэг хамгийн их малтай аймгуудын нэг юм. 2011 оны аж ахуйн нэгжийн тооллогоор 913 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 637 аж ахуйн нэгж, 176 төсвийн байгууллага, 100 төрийн бус байгууллага ажиллаж байна. Ажиллагдын тоогоор авч үзвэл, нийт аж ахуйн нэгжийн дотор 1-9 ажилтантай 75%, 10-19 ажилтантай 13%, 20-49 ажилтантай 8.4%, 50 дээш ажилтантай 3.1% -ийг эзэлж байна.

(Эх сурвалж: МУУСХ,(2014). Өвөрхангай аймгийн статистикийн товчоон. УБ)

Дараах асуултад хариулаарай:

- Өвөрхангай аймаг 2015 оны байдлаар нэг хүн амд хэчинээн хэмжээний баялаг ноогдож байна вэ?
- Өвөрхангай аймгийн эдийн засгийг бүрдүүлэгч салбаруудыг дугуй диаграмаар зурж, гол салбарыг олоорой.
- Тус аймагт нийт хэчинээн байгууллага байна вэ? Хэлбэр ба ажиллагсдын тоогоор ангилаарай.
- Нийт байгууллагын дотор ААН-ийн тоо олон байгаагийн шалтгаан юу вэ?
- Тус аймагт 1-9 ажилтантай ААН 75%, 50-иас дээш ажилтантай ААН 3.1% эзэлж байна гэсэн баримтаас ямар дүгнэлт хийж болох вэ?
- Орон нутгийн баялгийг өсгөхөд аль салбарын ямар байгууллагыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаагаа ярилцаарай.



### Гэртээ хийгээрэй

**Алхам 1:** Дээрх эх сурвалжийн адилаар өөрийн оршин суугаа аймаг дүүрэг, хорооны мэдээллийг орон нутгийн төв байгууллагын мэргэжилтнээс асуух, болон статистикийн албанаас гаргадаг мэдээллийн материалыг ашиглан цуглуулаарай. Орон нутгийнхаа ерөнхий мэдээллийг дараах асуулгаар бэлтгэж дүгнэлт гаргаарай.

- Хүн амын тоо
- Тухайн онд үйлдвэрлэсэн нийт баялгийн хэмжээ
- Нийт баялгийг үйлдвэрлэхэд эдийн засгийн салбаруудын эзлэх хувь
- Нийт байгууллага, аж ахуйн нэгжийн тоо
- Бидний сайн мэдэх олонд танигдсан тухайн орон нутгийн аж ахуйн нэгжүүд

**Алхам 2:** Нийт сурагчдыг 5 баг болгон аль нэг аж ахуйн нэгжийг сонгон очиж, удирдах ажилтан, ажилтнуудаас нь асуух, ярилцах зэргээр дараах мэдээллийг авна.

- Тухайн ААН-ийн нийт ажилчдын тоо, үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалт, үйлдвэрлэн гаргадаг бүтээгдэхүүний нэр, хэмжээ, үйлчилгээний онцлог
- Тухайн жилд үйлдвэрлэсэн нийт баялгийн хэмжээ, орлого, зарлага, ашиг, төсөөт төлсөн татварын хэмжээ
- Орон нутгаа хөгжүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө ямар арга хэмжээ хэрэгжүүлж, хэдий хэмжээний хөрөнгө зарцуулж байсан тухай
- Орон нутгийн эдийн засгийн аль салбарт хамаардаг болох талаар танилцуулга бэлтгэж, бусад багийнхандаа тайлбарлаарай.

**Алхам 3:** Багуудын хийсэн танилцуулгаас

- Танай орон нутагт хамгийн олон бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлдэг ААН аль нь вэ?
- Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хамгийн их хувь нэмэр оруулсан ААН-ийг тодруулаарай.
- Бусад ААН-ийг хөгжүүлэхэд ямар асуудал тулгарч байгаа талаар өөрсдийн дүгнэлт гаргаарай.

- Орон нутагтаа уг асуудлыг шийдвэрлэх ямар боломж байгаа талаар өөрсдийн хувилбарыг дэвшүүлээрэй.

**Алхам 4:** Дээрх асуудлыг хэлэлцэхдээ багийн гишүүдээс уг асуудалтай холбоотой асуултад хариулах, санал хэлэх зэргээр хэлэлцүүлэг өрнүүлж, орон нутгийнхаа эдийн засгийг нэмэгдүүлэх зөвлөмж гаргана. Сонирхолтой үр дүн гарсан бол орон нутгийн удирдах байгууллагадаа хүргүүлж болно шүү.

### Хүмүүс баялгийг хэрхэн бүтээдэг вэ?

Хүний хэрэгцээ хангах зорилгоор үйлдвэрлэлийн нөөцийг ашиглан бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргаж байгаа хүмүүсийн зорилго чиглэлтэй ухамсартай үйл ажиллагааг үйлдвэрлэл гэнэ. Үйлдвэрлэлд ашиглаж буй бүхий л нөөц нь орц юм. Харин нөөцуүдийг хувирган бүтээгдэхүүн үйлчилгээ болгож байгааг гарц гэнэ.


Орц

Хувиргалт

Гарц

Бүдүүвч 3.1 Орцыг ашиглан гарц болгон хувиргах үйл явц

Үйлдвэрлэлд орц болгон ашиглаж байгаа нөөцийг үйлдвэрлэлийн нөөц гэнэ. Үйлдвэрлэлийн нөөцөд дараах баялгийг хамааруулна.



Бүдүүвч 3.2 Үйлдвэрлэлийн нөөц

Хүний хэрэгцээ хязгааргүй, харин боломж буюу мөнгө хязгаартай байдгийн нэгэн адил үйлдвэрлэгчид ч мөн баялгийг хүссэн хэмжээгээрээ чөлөөтэй үйлдвэрлэж чаддаггүй. Учир нь баялгийг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, ажиллах хүч, тоног төхөөрөмж, эдгээрийг худалдан авахад шаардагдах бэлэн мөнгө хэрэгтэй. Дээрх үйлдвэрлэлийн нөөц нь мөн тоо хэмжээний хувьд хязгаарлагдмал. Иймээс бид хүссэн хэмжээгээрээ биш харин байгаа үйлдвэрлэлийн нөөц, бэлэн мөнгөндөө тулгуурлан тодорхой хэмжээний баялгийг бий болгодог.



### Тохиолдол шинжлээрэй

Сурагч Батын ах Хан-Уул дүүргийн аравдугаар хороонд амьдардаг бөгөөд гэрийнхээ ойролцоо байр түрээслэн талх, нарийн боовны цех ажиллуулдаг. Ах нь өнгөрсөн жил хорооныхоо “Шилдэг баялаг бүтээгч”-ээр шалгарчээ. Бат, найзын

хамт ахынхаа талхны цехийн үйл ажиллагаатай танилцахаар нэг өдөр ажиллаж үзэв. Талх үйлдвэрлэхийн тулд юуны өмнө үйлдвэрлэлийн нөөцөө бэлтгэдэг юм байна.

Талхны үйлдвэрийн байр нь 100м<sup>2</sup>, халуун хүйтэн ус, төвийн цахилгаан сүлжээнд холбогдсон, төвөөс алслагдсан, гэр хороололд байрладаг. Талх үйлдвэрлэхэд шаардагдах түүхий эд материал болох гурил, тос, хөөлгөгч, хуурай өндөг, өтгөрүүлсэн сүү, бал бурам гэх мэт амтлагчийг ашиглан үйлдвэрлэлийн хэд хэдэн шат дамжлааар дамжин талх, нарийн боов үйлдвэрлэн савлаж, дэлгүүр болон бусад хэрэглэгчдэд тусгай машинаар зөөж хүргэдэг. Талх хийх үйлдвэрлэлийн технологийн үе шатыг бүдүүвч харуулбал:

Үйлдвэрлэлийн технологийн үе шат:



Бүдүүвч 3.3 Талх нарийн боов үйлдвэрлэх технологийн үе шат

Талхны цехэд талхчин 1, нарийн боовчин 2, технологич 1, туслах ажилтан 1 ажилладаг. Талх нь дэлбээ, цэцэгхэн, хөх тарианы талх гэх мэт хэд хэдэн төрлөөр гардаг ба шошго таних тэмдэг, уутан савлагаатай. Үнэ 800-1300 төгрөг, харин нарийн боов нь 1300 -1800 төгрөгийн үнэтэй. Тэдний бүтээгдэхүүнийг ойролцоо дунд сургууль үдийн цай хөтөлбөрт, сурагчдын дотуур байрны хүүхдүүд, цэцэрлэгийн өглөөний цайнд хэрэглэхээр тус тус худалдан авдаг ба дүүргийн хүнсний дэлгүүрүүдээр борлуулдаг болохыг мэдэж авлаа.



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Талх үйлдвэрлэхэд үйлдвэрлэлийн ямар үе шат дамжиж гарч байна вэ? Үе шат бүрийн онцлогийг хэлээрэй.
- Үйлдвэрлэлийн ямар нөөц ашиглаж байна вэ? Нөөцийг ангилаарай.
- Яагаад энэ ангилалд оруулснаа тайлбарлан ярилцаарай.



### Гэртээ хийгээрэй

- Өөрийн оршин суугаа газрынхаа аль нэг ААН-ийг сонгож аваарай
- Тухайн байгууллагын үйлдвэрлэлийн нөөцийн талаар мэдээлэл цуглувлан 4 ангилаарай.
- Мэдээллээ ашиглан үйлдвэрлэлийн шат дамжлагыг бүдүүвч зургаар дүрслэн үзүүлээрэй.
- Үйлдвэрлэн гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, үнэ, чанар зэрэгт үнэлэлт дүгнэлт хийнэ үү.
- Цаашид бүтээгдэхүн, үйлчилгээгээ сайжруулахын тулд юу хийх ёстой вэ?
- Тухайн үйлдвэрийн газар орон нутагтаа ямар нөлөө үзүүлж байна вэ?

## Орон нутгийн төсөв гэж юу вэ?

Баялаг бүтээж ашиг олсон иргэд, аж ахуйн нэгжүүд татвар төлж, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлдэг. Энэхүү төсвийн хөрөнгийн тодорхой хэсгээр орон нутгаа хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлдэг. Иймээс орон нутгийн төсөв нь төсвийн орлогоо яаж бүрдүүлэх, түүнийг хэрхэн зарцуулах санхүүгийн тооцоо юм. Энэ бүлэгт орон нутгийн төсвийн орлого юунаас бүрддэг, түүнийг хэрхэн зарцуулах, орон нутгийн хөгжилд оруулах бидний хувь нэмэр юу болох тухай судлах болно.



## Тохиолдол шинжлээрэй

Бид өмнөх хичээлээр үзсэн Батын ахын талхны цехийн орлого, үр ашгийн тооцоог хийж үзье. Тус цех өдөрт 200 талх, 100 кг боов хийдэг ба ойролцоогоор нэг сарын орлого нь 3500.0 мянган₮, түүхий эд материал худалдан авах, ажилчдын цалин, түрээсийн зардалд нийт 3180.0 мян₮ зарцуулж, 320.0 мянган₮-ийн ашиг (3500.0 – 3180.0 ) олжээ. Үүнээс татварын хуулийн дагуу олсон ашгийн 10%-ийг татварт өгдөг. Тэгвэл сард 32.0, жилд 384.0 (32.0 x 12) мянган төгрөгийн татвар орон нутгийн төсөвт төлсөн. Түүнчлэн 5 хүнийг ажлын байртай болгон сар бүр дунджаар 2.5 сая төгрөгийн цалин олгосноор эдгээр хүмүүс тогтмол орлоготой болж амьжиргаа нь дээшилжээ.

- Батын ах талхны цех ажиллуулснаар орон нутгийн төсөвт хэчнээн төгрөгийн орлого оруулсан бэ? Татвар ямар үүрэгтэй вэ?
  - Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх нь ямар ач холбогдолтой вэ?
  - Орон нутгаа хөгжүүлэхэд иргэдийн оруулах хувь нэмрийг та нар юу гэж үзэж байна вэ?



## Эх сурвалжтай ажиллаарай

Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлгчдийн хурлаар дүүргийн төсвийн талаар хэллэлцэн Баянзүрх дүүргийн 2016 оны дүүргийн төсвийн орлогын 21.6 % буюу 18139.3 сая төгрөгийг татварын орлогоор бүрдүүлэхээр төлөвлөж, төсвийн зарлагыг дараах байдлаар зарцуулхаар тусгажээ. Үүнд \сая төг

- |   |                                  |               |
|---|----------------------------------|---------------|
| - | Төсөвт байгууллагын санхүүжилтэд | <b>9437.6</b> |
| - | Жижиг дунд үйлдвэрийг дэмжих     | <b>125.7</b>  |
| - | Хүүхэд хөгжил, хамгаалал         | <b>118.2</b>  |
| - | Өндер настныг хамгаалах, дэмжих  | <b>133.4</b>  |
| - | Хот тохижуулах                   | <b>7122.6</b> |
| - | Орон нутгийг хөгжүүлэх           | <b>3739.6</b> |

Орон нутгийг хөгжүүлэх хөрөнгийг дүүргийн авто зам болон гэр хорооллын дундах гэрэлтүүлэг хийх, 12 ба 22 дугаар хороонд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, 22 ба 102 дугаар сургуулиуд болон 32 мөн 40 дүгээр цэцэрлэгийн засварын ажилд зарцуулахаар шийдвэрлэжээ.

- БЗД-ийн төсөвт татвараар хэчинээн төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн бэ?
  - Орон нутгийн төсвийн зарлагын бүтцийг хувиар илэрхийллээрэй.
  - Орон нутгийн төсвийн ихэнх хэсгийг юунд зарцуулахаар төлөвлөсөн бэ? Төсвийн орлого өсвөл ямар зардлудыг есгэх боломжтой гэж үзэж байна вэ? Энэ талаар харилцан ярилцах дүгнэлт гаргарай.

Эх сурвалж: БЗД-үйн төсвийн төслийн баримт бичүг. УБ.2015

**Гол санаа.** Орон нутгийн төсөв гэж юу вэ? Орон нутгийн хэмжээнд бий болгосон баялгийнхаа тодорхой хувиар мөнгөн хөрөнгийн сан байгуулж, дээд шатны төсвөөс дэмжлэг авч орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг санхүүжүүлэх, орон нутгаа хөгжүүлэхэд хөрөнгө оруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэмж, урамшуулалт үзүүлэхэд зарцуулж буй мөнгөн хөрөнгө.



### Бие дааж ажиллаарай

1. Орон нутгийн төсвийн орлогын гол эх үүсвэр юу вэ? Орон нутгийн төсвийн орлого өсөх нь ямар ач холбогдолтой вэ?
2. Орон нутгийн төсвийн зарцуулалтын талаар харилцан ярилцаарай.
3. Төсвөөс ямар төрлийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлдэг вэ? Тэд ямар үүрэг гүйцэтгэдэг талаар ярилцана уу.
4. Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, үргүй зардал байгаа эсэх талаар ярилцаж, шинэ санаа дэвшүүлээрэй.
5. Хамт олноороо хэвшүүлэх 1-2uriалга дэвшүүлж гаргаарай.



### Гэртээ хийгээрэй

1. Өөрийн гэрийн ойролцоо /1км орчим/ үйлдвэрлэл үйлчилгээний газруудыг хамруулан газрын зураг зурж, таних тэмдэг үүсгээрэй.
2. Тэдгээр газрыг эдийн засгийн ямар байгууллага болохыг ялган ангилаарай.
3. Ямар байгууллага олон, ямар байгууллага дутагдаж байгааг олж асуудал дэвшүүлээрэй.
4. Дэвшүүлсэн асуудлаа хэрхэн шийдвэрлэх арга замыг хэлэлцэн гаргаарай

## 3.2. ОРОН НУТГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### Зах зээлийн харилцаа гэж юу вэ?

Бид өмнөх сэдвээр хүмүүс баялгийг хэрхэн бүтээдэг, үйлдвэрлэлийн нөөцөд юу ордог болохыг судалсан билээ. Харин энэ сэдвээр зах зээл ба зах зээлийн харилцаа гэж юу болох, зах зээлийн үндсэн ухагдахуунуудтай танилцах болно.



### Хамтран ажиллаарай

1. Орон нутгийн зах зээлийн орчныг дүрсэлж, зах зээлийн харилцааг ойлгох: 4-5 хүнтэй баг болон хуваагдаж өөрсдийн орон нутгийн зах зээлийг дүрслэн дүр бүтээе. Зарим баг нь тодорхой хэмжээний мөнгөтэй (мөнгөний тоог тэмдэглэсэн цаасан мөнгө зурж ашиглаарай. Худалдан авагчдын мөнгө тодорхой хэмжээтэй байна. Нийт мөнгө 100 000 гэх мэт) худалдан авагчид, зарим баг нь борлуулах

бараа бүхий үйлдвэрлэгчид, нэг баг нь зах зээлийн үйл хөдлөлийг хянах, торгох эрх бүхий зохицуулагч болно.

- Зах зээлийн орчныг дүрслэхдээ урьдчилан зах зээлийн орчныг ажиглан судлаарай. Ингэхдээ зах зээл дэх хүмүүсийн үйлдлийг ажиглах, зарим хүмүүсийн мэдээллийг тодруулах ярилцлага хийх, бүтээгдэхүүний үнийг асуух зэрэг аргыг ашиглаарай.
  - Зах зээлийн эрэлт буюу худалдан авагчдын хүсэл, өөрт байгаа мөнгөний хэмжээнд тохируулан худалдан авах бүтээгдэхүүнийг сонгож байгаа байдлыг харуулна. Худалдан авагчдын дүр бүтээхдээ хүмүүсийн хэрэгцээ хангах, тааламжтай нөхцөлийг дэмжихэд шаардлагатай барааны чанар, үнэ, барааны өрөлт, сав баглаа, хүргэлтийн үйлчилгээний талаарх өөрсдийн санал бодлоо багаараа ярилцан тэмдэглэж мэдээлэл бэлтгээрэй.
  - Зах зээлийн нийлүүлэлт буюу үйлдвэрлэгчдийн бараагаа борлуулах хүсэл, үнээр хэрхэн өрсөлдөж байгааг харуулна. Нийлүүлэгчдийн дүр бүтээхдээ тэдний бүтээгдэхүүний чанар, үнэ хэрэглэгчдийн хэрэгцээг хэр хангаж байгааг ажиглаарай. Мөн ямар үед үнээ өсгөж, бууруулж байгаа, хэрэглэгчдэдээ барааг борлуулахдаа ямар нэмэлт үйлчилгээ үзүүлж байгаа талаарх өөрсдийн санал бодлоо багаараа ярилцан тэмдэглэж мэдээлэл бэлтгээрэй.
  - Зохицуулагчид зах зээлийн харилцаанд оролцогчдын аюулгүй байдал болон шударгаар өрсөлдөх нөхцөлийг хангах, олсон орлогод нь татвар ноогдуулна. (Нийлүүлэгчдийн олсон орлогоос 10%-ийн татвар аваарай. Энэ нь орон нутгийн төсвийн орлого болно). Дээрх үйлдлүүдээр дүрийн тоглолт хийж үзүүлээрэй.
2. Зах зээлийн харилцааг харуулсан дүрийн тоглолтын дараа багууд мэдээллээ ангидаа танилцуулна. Мэдээлэлдээ дараах асуудлыг тусгаарай.
- Манай орон нутгийн зах зээлийн орчинд байгаа хүний хэрэгцээ хангах, тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн сайн жишээ 2-3-ыг танилцуулна уу.
  - Манай орон нутгийн зах зээлийн орчинд учир дутагдалтай байгаа муу жишээ 2-3-ыг танилцуулна уу.
3. Цаашид орон нутгийн зах зээлд хэрэгжүүлбэл зохих ямар үйлдвэрлэл, үйлчилгээ, зохицуулалт байх шаардлагатай талаар 2-3 санаа дэвшүүлээрэй.

**Зах зээл гэж юу вэ?** Хүмүүс хамтран амьдрахдаа өөрсдийн хүсэл, сонирхол чадвараараа төрөлжин хөдөлмөрийн хуваарын оролцож байдаг. Энэхүү хөдөлмөрийн хуваарийн төрөлжилтийн үед бүтээгдэхүүнээ хоорондоо солилцох зайлшгүй шаардлагатай болно. Жишээ нь, оёдолчин эсвэл зохиолч өөрсдийн оёсон хувцас, бичсэн номоо хэрэгцээтэй хүнс болон бусад зүйлээр солилцож чадахгүй байсан бол энэ мэргэжлээр төрөлжихгүй байсан. Эндээс үзвэл хүмүүс арилжаа солилцоо хийж хэрэгцээгээ хангана. Арилжааг зах зээлд хийнэ.

**Гол санаа.** Зах зээл нь мөнгөтэй, түүнийгээ зарцуулах сонирхолтой худалдан авагчид буюу хэрэглэгчид, тэдэнд бараагаа борлуулж ашиг олох сонирхолтой худалдагчид буюу үйлдвэрлэгчдийн хоорондын харилцан үйлчлэл юм.

Хүмүүс хэрэгцээгээ бүрэн хангахад нөөц баялаг байнга дутагддагийг бид ойлгосон. Иймээс өөрт байгаа нөөцөөр хамгийн чухал хэрэгцээгээ эхэлж хангахыг

эрмэлздэг. Хэрэгцээт бараагаа эрж хайж буй хүмүүсийг худалдан авагчид гэнэ. Зах зээлийн эрэлт гэж юу болохыг дараах жишээн дээр тайлбарлая.

**Гол санаа.** Худалдан авагчийн хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг эрэлт гэнэ.

1. Сурагч Батаа гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор юуны түрүүн англи хэлний ном авах хэрэгтэй гэж үзэн 20.000 төгрөг цуглуулжээ. Гэтэл дэлгүүрт очтол англи хэлний номын үнэ 30.000 төгрөг болж өссөн тул мөнгө нь хүрэлцэхгүй болжээ.
2. Сурагч Туяа энэ номыг худалдан авах боломжтой ч хэрэгцээгүй байв.
3. Сурагч Цогоо энэ номыг худалдан авах хүсэлгүй бас цуглуулсан мөнгө ч үгүй байжээ.
4. Харин Болд 30.000 төгрөгтэй, бас ном зайлшгүй хэрэгтэй байсан тул уг номыг худалдан авав.

Эхний 3 тохиолдолд сурагчид нэг бол ном худалдан авах хүсэлгүй, эсвэл худалдан авах чадваргүй байгаа тул эдгээр нь бүгд эрэлт биш юм. Бараа эрэлттэй байна гэдэг нь худалдан авагч түүнийг худалдан авах хүсэл байхаас гадна худалдан авах чадвартай байхыг хэлнэ. Иймээс Болд ном авах хүсэлтэй, мөн хүрэлцэхүйц мөнгөтэй байгаа тул эрэлт үүсч байна. Болд шиг ном худалдан авах хүсэлтэй хүрэлцэхүйц мөнгөтэй хүмүүс олон бол зах зээлд уг номын эрэлт их байна гэсэн үг. Хүний хэрэгцээ хязгааргүй байдаг бол эрэлт нь тодорхой хэмжээний мөнгөөр хязгаарлагдаж байдаг.

Энэхүү хэрэгцээт барааг нь үйлдвэрлэж борлуулан, дундаас нь ашиг олох эрмэлзэл бүхий хэсэг хүмүүс хоорондоо эвлэлдэн нэгдэж аж ахуйн үйл ажиллагаа явуулна. Барааг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байгаа хүмүүсийг үйлдвэрлэгчид гэнэ. Үйлдвэрлэгчид их ашиг олох боломжтой үйлдвэрлэл эрхлэхийг илүүд үзнэ. Нийлүүлэлтийг дээрх жишээтэй холбон тайлбарлая.

**Гол санаа.** Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг нийлүүлэлт гэнэ.

1. А компани шинээр үйл ажиллагаа эхлэх гэж байна. Номын үнэ өсөж байгаа боловч махны үйлдвэрлэл эрхлэх нь илүү ашигтай байгаа тул ном, сурх бичиг үйлдвэрлэхийг сонирхогүй байна
2. Б компани тавилгын үйлдвэрлэл эрхэлдэг. Санхүүгийн хувьд нэлээд боломжийн болсон тул хажуудаа жижиг хэвлэлийн цех байгуулж, ном, сурх бичиг үйлдвэрлэвэл хэр ашиг олж болохыг судалж байна.
3. “ММ” Хэвлэлийн компани ном үйлдвэрлэх зардлаа бууруулан илүү олон ном үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

Дээрх жишээнээс харахад сурх бичгийн үнэ 30.000 төгрөг байхад үйлдвэрийн олох ашиг их байвал дээрх 3 компани аль аль нь ном үйлдвэрлэж нийлүүлэхийг эрмэлзэх ба хэрэв ашиг бага бол зөвхөн MM компани ном үйлдвэрлэж нөгөө хоёр нь татгалзана.

Тэгвэл зах зээлд нэг талаас өөрийн хэрэгцээг хангах эрэлт бүхий худалдан авагчид, нөгөө талаас тухайн хэрэгцээг хангаж чадах үйлдвэрлэгчид оролцно. Тэдний харилцааг төрөөс татварын бодлогоор зохицуулдаг. Ийнхүү зах зээлд зохицуулагчид бас оролцно.

Тэгэхээр зах зээл гэдэг нь эрэлт нийлүүлэлтийн харилцан үйлчлэл ба төрийн бодлогоор зохицуулагдаж байдаг үйлчилгээний талбар болж байна. Тухайлбал, хичээлийн жил эхлэх үед хичээлийн хэрэгслийн эрэлт ихэсдэг байх нь ээ. Эрэлт их байвал эдгээр бүтээгдэхүүнийг нийлүүлэх нийлүүлэгчид үнээ өсгөнө. Үнэ өссөнөөр олон үйлдвэрлэгчид уг бүтээгдэхүүнийг олноор нийлүүлж эхэнэ. Нийлүүлэлт их болсноор хичээлийн хэрэгсэл зах зээлд элбэг болж, үйлдвэрлэгчид бараагаа хурдан борлуулахын тулд үнээ буулгана. Иймээс зах зээл дээр эрэлт нийлүүлэлтийн харилцан үйлчлэлээр барааны зах зээлийн үнэ тогтдог.



**Үнэ гэж юу вэ?** Иргэдээс бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан аваадаа төлж буй мөнгөн дүнг үнэ гэнэ. Зах зээл дэх эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрээр бараа үйлчилгээний зах зээлийн тэнцвэрт үнэ тогтоно.

Зах зээлд эрэлт нийлүүлэлт хоёр хоорондоо тэнцэж байвал эдийн засаг тогтвортой байна гэж үздэг. Хэрэв зах зээлд барааны эрэлт их байвал тухайн барааны үнэ өсөх хандлагатай байна. Харин нийлүүлэлт их байвал барааны үнэ буурач байдаг. Үнэ тогтвортой байгаа нь зах зээл тэнцвэртэй байгаагийн илрэл юм.

Зах зээл дэх эрэлт болон нийлүүлэлтийн харилцан хамаарлыг зайрмагийн жишээн дээр авч үзье. График: Зайрмагны эрэлт, нийлүүлэлтийн муруй.




График 3.1 Зайрмагны эрэлт, нийлүүлэлтийн зах зээлийн тэнцвэр

P – зайрмагны үнэ, Q – зайрмагны тоо хэмжээ, D – эрэлтийн муруй  
S – нийлүүлэлтийн муруй, E - зах зээлийн тэнцвэрийн цэг

Графикаас харахад үнэ 850₮ байхад эрэлт 35000ш, харин нийлүүлэлт 25000 ш болж зах зээлд 10000ш бүтээгдэхүүний хомсдол үүссэн байна. Энэ

үед нийлүүлэгчид үнээ өсгөсөөр 1000₮ болсон гэж үзье. Ингэснээр зах зээлд нийлүүлэлт 40000₮ ш, эрэлт 20000₮ болж зах зээлд 20000₮ бүтээгдэхүүний илүүдэл үссэн байна. Үүний улмаас бараагаа борлуулахын тулд нийлүүлэгчид үнээ буулгаснаар 900₮ болоход эрэлт нийлүүлэлт тэнцвэржин, зах зээлийн үнэ тогтох байгааг харж болно. Ийм маягаар зах зээлд тухайн бүтээгдэхүүний үнэ эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлж, зах зээлийг зохицуулах үүрэгтэй болохыг мэдэж авлаа.

**Гол санаа.** Эрэлт, нийлүүлэлтийн муруйн огтлолцлын цэг дээр зах зээлийн тэнцвэрт үнэ тогтоно.



### Гэртээ хийгээрэй

**Даалгавар 1.** Дараах хүснэгтийг ашиглан гурилын эрэлт нийлүүлэлтийн муруйг байгуулаарай. Зах зээлийн тэнцвэрт үнэ хэд вэ? Гурилын үнэ 600, 900 төг болоход зах зээлд уг бүтээгдэхүүний илүүдэл, хомсдол ямар хэмжээтэй байгааг тодорхойлж тайлбарлаарай.

Гурилын үнэ, төг	500	600	700	800	900
Гурилын эрэлт, тн	900	850	800	750	700
Гурилын нийлүүлэлт, тн	700	750	800	850	900
Зах зээлийн илүүдэл, хомсдол (+; -)					

**Даалгавар 2.**

- Өмнө судалсан үйлдвэрийн газрынхаа тодорхой нэг бүтээгдэхүүнийг сонгон авч, ижил төрлийн бүтээгдэхүүнүүдтэй үнийг нь харьцуулаарай
- Танай гэрийн ойролцоо хүнсний дэлгүүрт аль үйлдвэрийн ямар үнэтэй ямар бүтээгдэхүүн хэдий хэмжээтэй борлуулагдаж байгааг судалж үзээрэй. Импортоор оруулж ирсэн гадаадын ямар бүтээгдэхүүн байна вэ?
- Өөрийн орон нутагтаа уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж байна уу?
- Өөрийн орон нутагт үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнүүдээс хамгийн их эрэлттэй (хомсдолтой), хамгийн их нийлүүлэлттэй (илүүдэлтэй) байгаа нэг нэг бүтээгдэхүүнийг нэрлэж, тэдгээрийг тэнцвэржүүлэх арга замыг тодорхойлоорой.

### 3.3. ЖИЖИГ БИЗНЕСИЙН ТӨСӨЛ

Иргэн баян бол улс баян.

Өмнөх сэдвүүдээр хүмүүс баялгийг хэрхэн бий болгодог, зах зээл ба зах зээлийн харилцаанд яаж оролцдог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнийн тухай авч үзсэн билээ. Энэ сэдвээр баялгийг бий болгогч бизнесийн төслийг хэрхэн бичих арга зүйтэй танилцах болно.

**Тохиолдол.** Сурагч Цогийн ах Баяр хөдөөнөөс хотод орж ирсний дараа хэсэг хугацаанд ажилгүй явжээ. Нэлээд хугацаанд ажил хайсан боловч санаанд таарах ажил олдсонгүй. Гэтэл энэ үеэр дүү нь цэцэрлэгт явж эхлэв. Тэгээд орой

бүр ээжээсээ ном уншиж өгөхийг хүсдэг байв. Ээж ч унших номоо дууссан тул заримдаа үлгэр зохиож ярьж өгнө. Үүнийг хараад Баяр хүүхдийн зусландаа багш хийж байхдаа маш олон үлгэр, оньсогоо таавар сурсан, бас хэдэн жил хүүхдийн дунд ажилласан дадлага туршлага зэрэг өөрийнхөө авьяас, мэдлэг, чадвараа ашиглан хүүхдэд хэрэгтэй зүйл хийхээр шийдлээ. Ингээд үлгэр оньсогоо, таавар, зүйр цэцэн үг зэргийг хүүхдийн нас настын онцлогт тохируулан багачуудын сонирхлыг татахаар янз бүрийн өнгө, аяс, дуу оруулан уншиж хуурцганд бичив. Энэхүү хуурцгаа цэцэрлэгийн багш нарт сонсгоход маш дуртай худалдан авахыг зөвшеөрсөн тул 10 ширхгийг тус бүр нь 500 төгрөгөөр худалдав.

Үүндээ урамшин дараа нь хуурцгаа олшруулан 1000 ширхгийг цэцэрлэг, дэлгүүрүүдээр явж бэлэн мөнгөөр болон зээлээр худалдан борлуулав. Дараа нь хүүхдийн сонин гаргах, цэцэгт мэндчилгээ хүргэх зэргээр бизнесээ өргөжүүлсэн байна. Энэ ажилд нь Цогоо маш их тусалсан бөгөөд бүтээгдэхүүнээ олшруулах, борлуулах, мөнгөний тооцоо хийх зэрэг олон аргад суралцсан билээ.

- Баярын бизнес санаа юу вэ? Түүнийг хэрхэн олсон бэ?
- Баярын давуу тал юу вэ?
- Бүтээгдэхүүнээ хэнд худалдаж, ямар хүмүүс хэрэглэх вэ?
- Цэцэрлэгийн хүүхдүүдэд өөр ямар бараа хэрэгтэй болохыг ярилцаж бизнесийн санаа гаргана уу.
- Жижиг бизнес эрхэлснээр Цог, Баяр хоёрт ямар давуу тал гарсан бэ?

Орон нутгийн төдийгүй улс орны эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл нь баялаг бүтээх явдал юм. Иргэн баян бол улс баян гэдэг үгийг бид мэднэ. Иргэн өрх гэр баян байна гэдэг нь тэдний орлого, ашиг өсөн нэмэгдэж арвижиж байхыг хэлнэ. Тэгвэл бизнесийн санаа яаж олох, түүнийг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх арга зүйд суралцах явдал чухал юм.

**Гол санаа.** Бизнес гэдэг нь тодорхой хэмжээний хөрөнгө оруулж, түүнийгээ арвижуулах үйл ажиллагааг хэлнэ. Бүх төрлийн бизнесийн гол зорилго ямар нэг орлого олоход оршино. Бизнес санаа гэдэг нь орлого олох боломжийг олж харна гэсэн үг юм.

Бизнесийн санаа дэвшиүүлэх: Хувь хүн ба бүлэг хүмүүс бизнес эрхэлснээр ажлын байр бий болгож баялаг бүтээдэг. Хүмүүс ганцаараа эсвэл, гэр бүлээрээ, найз нөхдөөрөө хамтран жижиг бизнес хийх боломж бидний эргэн тойронд маш их байдаг. Эдгээр боломжуудыг олж харан орлогоо нэмэгдүүлэх нь өрх гэр төдийгүй орон нутаг, улсдаа оруулж буй маш чухал хувь нэмэр болоод зогсохгүй баялаг бүтээгчид болж байгаа хэрэг юм. Бизнес эрхлэх нь хамгийн түрүүнд бизнесийн санаа олохоос эхэлнэ. Бизнес санаа гэдэг нь орлого олох боломжийг олж харна гэсэн үг. Бизнесийн санаа олохын тулд:

- Орлого олох ямар боломж байгааг олж харах - таны эргэн тойронд хүмүүс ямар бизнес эрхэлж байна, аль нь боломжтой санагдаж байна вэ? Түүнтэй өрсөлдөж чадах эсэх,
- Хүмүүсийн өдөр тутмын хэрэгцээг судлах - ямар эрэлт хангагдаагүй байна,

түүнийг хангах боломж байна уу?

- Бусдын бизнесийг түшиглэх - заавал өөрөө шинээр хийхийн оронд бусдын бизнесийг орон нутагтаа түгээх, салбар нээх зэрэг боломжуудаас санаагаа олно.

Бизнесийн санаагаа олсон бол бизнесээ төлөвлөнө.

Бизнес төлөвлөгөө нь бизнесийн зорилго тодорхойлох, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, хийх ажлаа төлөвлөх, эрсдэлээ тооцох, орлого зардал үр ашгаа тооцох гэсэн үндсэн бүтэцтэй байна. Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа ямар нэг аяллын зураг, төсөв зохиож байна гэж төсөөлж болох юм. Тэгвэл доорх асуултыг өөрөөсөө асуух нь зүйтэй.

1. Бид хaa хүрэхийг зорьж байна вэ? (бизнесийн зорилго)
2. Тэр газар яаж, ямар замаар явж хүрэх вэ? (үйл ажиллагааны чиглэл)
3. Замдаа бид юу хийх ёстой, ямар саад бэрхшээл тохиолдох вэ?
4. Түүнийг хэрхэн давах вэ? (хийх ажлаа төлөвлөх, эрсдэлээ тооцох)
5. Замдаа хэр зэрэг хугацаа зарцуулах, хэчнээн зардал гаргах вэ?
- (орлого зардал үр ашгаа тооцох)



Бүдүүвч 3.4 Бизнес төлөвлөгөөний бүтэц, үе шат



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

1. Доорх эх сурвалжуудаас бизнесийн ямар санаа гарч болох вэ?
2. Бизнес санааг баяжуулан бизнес болгох хувилбарууд гаргана уу?
3. Оюуны довтолгооны аргыг ашиглан орон нутагтаа тулгамдаж буй асуудлын жагсаалт гаргаарай. Жагсаалтаа дахин ярилцаж, шийдвэрлэх боломжтой 3 асуудлыг тодруулаарай.
4. Одоо дараах үнэлгээний хүснэгтийн дагуу жагсаалт дахь 3 асуудлаа харьцуулан үзээрэй. Түүний дараа 1 асуудлыг сонгон аваарай.

а) Сонгож авсан асуудлыг шийдвэрлэнээр хүрэх тодорхой үр дүн юу вэ гэдгийг сайтар ярилцаж тодорхойлоорой. Энэ нь зорилгодоо хэрхэн хүрэх аргаа тодорхойлох, дараа нь зорилгодоо хүрсэн эсэхээ дүгнэхэд зайлшгүй хэрэгтэй шүү.

Дээрх асуултад хариулж чадахуйцаар үйл ажиллагаагаа төлөвлөхийг аяллын төлөвлөгөө гэнэ.

Бизнес төлөвлөгөө нь та өөрийн бизнесийн зорилго дэвшүүлж, түүнд хүрэхийн тулд хийх ажлаа урьдчилан төлөвлөх, явцын дунд хянаж, зохицуулах гол үүрэгтэй

Хүрэх үр дүн 1					
Хүрэх үр дүн 2					
Хүрэх үр дүн 3					
б) Эдгээр үр дүнд хүрэхийн тулд хийх ажлууд буюу бизнесийн төлөвлөгөөг ярилцаж тодорхойлоорой.					
Зорилт Жишээ: цэцэрлэг болон бага насны хүүхдийн тоглоомыг орон нутгатай үйлдвэрлэх	Бизнесийн бүтэц Сурагчид чөлөөт цагаараа ажиллаж тоглоомын цех байгуулах	Үйл ажиллагааны загвар Тоглоом үйлдвэрлэх үе шат, үйлдвэрлэх бүтээгдэхүүний загвар гаргах.	Зардлын тооцоо Үйлдвэрлэлийн зардал болон борлуулалтын орлогоо тооцох	Үр дүн Баялаг бүтээх салбар нэмэгдэж сурагчид орлоготой болж, бүтээлч хүн болж төлөвшине.	

5. Эдгээр санааг хэрэгжүүлснээр орон нутгийн эдийн засагт ямар байдлаар нөлөөлөх боломжтой вэ?

Эх сурвалжууд	Үр дүн
<p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх чиглэлээр дүүргийнхээ сургуулиудад эрэгтэй, эмэгтэй сурагчдын технологийн хичээлд зориулж иж бүрэн тоног төхөөрөмж бүхий технологийн танхим тохижуулж өгсөн байна.</p> <p>(Эх сурвалж: СБД-ийн 50 жилийн ойн илтгэлээс)</p>	 
<p>Бидний хөл дор хөглөрөх, хаа сайгүй хэвтэж байдаг <b>ундааны сав, лааз</b> зэрэг хогоор сүүлийн жилүүдэд манай улсад <b>хуванцар</b> үйлдвэрлэх, хуванцрыг дахин боловсруулдаг үйлдвэрүүд нээснээр хогийг баялаг болгох боломж нээгдлээ. Хуванцрыг боловсруулж, цонх, хаалга, гэр ахуйн хэрэгсэл, сантехникийн хоолойнууд хийж байна.</p> <p>(Эх сурвалж: tml.mn/pages/хуванцар-түүхий-эдийн-үйлдвэрлэл)</p>	 
<p>Монгол орны ихэнх нутагт балт ургамлын нөөц сайтай учраас зөгийг үржүүлж өндөр ашигтай салбар болгон хөгжүүлэх боломжтой юм. Манай улсад 5-7 сая бүл зөгийг үржүүлэх бэлчээрийн нөөцтэй, жилдээ 300 тн зөгийн бал импортоор авдаг. Одоогийн байдлаар 20 гаруй өрх 270 бүл зөгийг үржүүлж байна. Нэг бүл зөгийнээс жилд 15-20 кг зөгийн бал гарган авдаг.</p> <p>Эх сурвалж: М.Билэгт сайхан.(2010). Зөгийн аж ахуй. УБ.</p>	 

Бүдүүгээ 3.5 Бизнес санаа гаргах эх сурвалжууд



## Гэртээ хийгээрэй

1. 4-5 хүнтэй баг болон хуваагдаж хөрөнгө оруулагчдад өөрийн бизнесийн төслөө танилцуулж, тэдний сонирхлыг татан хөрөнгө босгох гэж байна гэж төсөөлөөрэй.
2. Бизнес санаагаа гаргахдаа өөрийн орон нутагт хэрэгцээтэй байгаа, орон нутагтаа үйлдвэрлэж, нийлүүлж болох бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг гаргаарай. Жагсаалт гаргахдаа 58-р хуудасны 4 дэх даалгаврын үнэлгээний хүснэгтийг ашиглаарай.
3. Баг тус бүр уг жагсаалтаас аль нэг асуудлыг шийдэж болох жижиг бизнесийн төсөл боловсруулаарай. Бизнес төсөл нь дараах бүтэцтэй байна.
  - a. Бизнесийн зорилго: хэрэглэгчийн ямар хэрэгцээг яаж хангах гэж байгаагаа тодорхойлно. Жишээ нь, сурагчдын үдийн цай хөтөлбөрийн нарийн боовыг үйлдвэрлэж борлуулах.
  - b. Уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж байгааг тодорхойлох. Уг бүтээгдэхүүнийг чанартай, хямд үйлдвэрлэж буй байгууллага хүмүүстэй уулзаж, зөвлөгөө авах, асуух
  - c. Уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай үйлдвэрлэлийн нөөцөө тооцох, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шатны бүдүүвч зургаа гаргах.
  - d. Үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүний борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн зардлын тооцоог ойролцоогоор тооцож гаргах.
4. Өөрсдийн төслөө анги хамт олондоо танилцуулаарай. Уг төслийн үр дүнд орон нутгийн эдийн засгийн асуудалд ямар хувь нэмэр үзүүлж болохыг тайлбарлан ярилцаарай.
5. Бүх төслөө хэлэлцэн багш, хамт олноороо ярилцан харилцан бие биенээ урамшуулаарай.

## 3.4. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэ бүлэг сэдвийн хүрээнд орон нутгийнхаа эдийн засгийн бүтэцтэй танилцах, онцлог давуу талыг судлах, үйлдвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагаатай танилцах зэргээр хүмүүс баялгийг хэрхэн бүтээдэг, үйлдвэрлэлд ямар хүчин зүйлс оролцдог болон нөөц хязгаарлагдмал болох, хүмүүс зах зээлийн харилцаанд хэрхэн оролцдог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тухай ойлголттой боллоо. Түүнчлэн бизнес гэж юу болох, бизнес эрхлэхийн давуу талыг судлан орон нутгийн эдийн засгaa дэмжих болон өрхийн орлогоо нэмэгдүүлэхийн тулд жижиг бизнесийн төслийн тооцоо санаачлах арга зүйтэй танилцлаа. Үүний дунд бид орон нутгийнхаа эдийн засгийн бүтцийг мэдэх, нөөцийг үр ашигтай ашиглах, баялаг бий болгох, хайрлах, орон нутгийн хөгжил бидний амьдралд чухал нөлөөтэй болохыг ойлгож авлаа.



## Тохиолдол шинжлээрэй

Мөнхөө айлын том хүү, наймдугаар ангид сурдаг. Тэднийх Шаргаморьтод зуслангийн байшинтай, хашаандаа хүлэмжтэй, жимсний мод, цэцэг ургуулдаг. Мөнхөө нэг өдөр хүнсний захаар явж байтал нэгэн эмэгтэй Монголын хөрсөнд ургасан органик төмс авах гээд олж чадсангүй гэж ярихыг сонсов. Ингээд, “манайх хүлэмжинд өргөст хэмх, улаан лооль тарьдаг туршлагатай тул хашаандаа эрүүл органик төмс, хүнсний ногоо тарих боломж байгаа юм байна” гэж бодлоо. Орой нь аавтайгаа ярилцан зах зээлийн эрэлтийг судлахаар шийдэв. Сүүлийн үед хүмүүс эрүүл мэнддээ анхааран хятадын хямд чанаргүй төмс, хүнсний ногоноос татгалзан органик шинэ хүнсний ногоо хэрэглэхийг эрхэмлэх болсноос үнийн хямдыг харах биш экологийн цэвэр, чанартай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхэд ихээхэн анхаардаг болсон ба ийм бүтээгдэхүүний эрэлт нэлээд их байгааг судалж мэдэв. Иймээс эрүүл төмс, хүнсний ногоо тарьж борлуулах боломжтой юм гэдэг санаа төрөв. Юуны өмнө ногоо тарих газраа сонгон шаардагдах багаж хэрэгсэл, үр, үрсэлгээ худалдан авах, хэн ямар ажил хийх, ямар эрсдэл учрахыг тооцсон бизнес төсөл бичив. Мөнхөөд санхүүгийн тооцоо хийх нь нэлээд хүнд байсан учир аавтайгаа хамтарч хийв. Үүнийг хэрхэн хийснээ наиз нартайгаа хуваалцъя.

### Хүнсний ногоо тариалан борлуулах орлого, зарлагын тооцоо

Мөнхөө төмс 100 м<sup>2</sup>, байцай 10 м<sup>2</sup>, сонгино 5м<sup>2</sup>, лууван 5м<sup>2</sup> талбайд тарихаар болов. Ийм талбайд шаардагдах үр, үрсэлгээ, түүнийг худалдан авах зардлыг тооцъё.

### Хүснэгт 3.3 Мөнхөөгийн орлого, зарлагын тооцоо (дутууг гүйцээж тооцоорой)

Үр, үрслэг	Хэмжээ	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮
Төмс (үрийн төмс)	25 -30 кг	500	-
Байцай (үр 1-2 гр) (үрслэг )	50ш 40ш	50 100	-
Сонгино (үр төл сонгино 40 гр-аар)	800 гр		3000
Лууван (үр)	5 гр	400	500
Зардлын дүн			25000

### Орлогын тооцоо

Хураах ногоо	Авах хэмжээ	Борлуулах үнэ	Орлогын дүн
Төмс	300 кг	450	-
Байцай	60 кг	600	36000
Сонгино	10 кг	500	-
Лууван	3 кг	700	2100
Орлогын дүн			178100

Мөнхөөгийн орлого 178100 төг, зарлага 25000 төг болж ашиг нь 178100 – 25000 = 153100 төг болох урьдчилсан тооцоо гарч байна. Энэ бол орлогын урьдчилсан тооцоо бөгөөд ашиг олох боломжтой гэдгийг харуулж байна. Иймээс бусад зардлуудыг нарийвчилсан тооцоо хийж төлөвлөн, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх

алхмуудаа тодорхойлоо боллоо. Мөнхөө ногоогоо тарьсны дараа сайн ургац авахын тулд хүнсний ногоо тарьж ургуулах зөвлөмж унших, ногоо тарьдаг туршлагатай хүмүүсээс асуух, дуурайж хийх зэргээр тарьсан ногоогоо арчилж байв. Түүнчлэн услах, бордох, хортон устах зэрэг ажлыг дүү нартайгаа хуваарь гарган хийв. Азаар бороо ус ихтэй сайхан зун болж, налгар намар үргэлжлэв. Намар ногоо хураахад төлөвлөснөөс ихээхэн хэмжээний ургац авч, тэдний гэр булийнхэн бөөн баяр болов. Мөнхөө ногоогоо хураах, соортлох, хадгалах, борлуулах, орлогоо тооцох зэрэг олон ажлыг хийж сурчээ. Түүний хувьд хамгийн их баярласан зүйл бол сайн ажилласан гэж аав нь 100.0 мянган төгрөгөөр шагнасан явдал байв. Мөнхөө уг мөнгийг анх удаа өөрийн нэр дээр банканд данс нээлгэн ирээдүйн боловсролдоо зарцуулахаар хадгалсан билээ. Мөнхөө одоо эрүүл органик шинэ төмс, хүнсний ногоо тариалах ажлаа үргэлжлүүлэх ба орон нутгийн зах зээлийг шинэ төмсөөр тасралтгүй хангах болно гэж төлөвлөж байна.



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Мөнхөө зуны амралтаа хэрхэн өнгөрүүлэхээр шийдсэн бэ?
- Мөнхөөгийн орлого, зарлагын тооцоо хийх хүснэгтийн дутууг нөхөж тооцоорой.
- Ашгаа яаж тодорхойлсон бэ?
- Мөнхөө ямар зардлаа тооцогүй вэ?
- Мөнхөө ногоо тариалснаар ямар давуу талтай болсон бэ?
- Мөнхөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулсан бэ?

### Мэдлэгээ шалгах сорилго ажиллаарай.

1. Аль тохиолдолд тэнцвэрт үнэ тогтох вэ?

Эрэлтийн тоо хэмжээ	Нийлүүлэлтийн тоо хэмжээ	Илүүдэл/Хомсдол
A 90,000	60,000	-30,000
Б 80,000	80,000	=
В 60,000	100,000	+40,000

2. Аж ахуйн нэгжийн хэлбэрийг зөв илэрхийлсэн зурагтай холбоно уу?

1. Үйлдвэрлэл	2. Үйлчилгээ	3. Худалдаа
A.	B.	B.

А. 1А,2Б,3В

Б. 1Б,2В,3А

В. 1В,2Б,3А



Бид орон нутгийнхаа эдийн засгийн талаар олон зүйлийг мэдэж авлаа.  
Цаашдаа орон нутаг, улс орноо хөгжүүлэхийн төлөө хичээцгээ.



Тийм шүү. Бид орон нутаг, улс орнихоо эдийн засгийн хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулж чадна.

# IV БҮЛЭГ

## ХҮНИЙ ЭРХ БА ХУУЛЬ



### ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Хүний эрх, эрх чөлөө
- Хүний эрхийн түүх
- Хүний эрхийн зарчмууд
- Тэгш байдал
- Шударга ёс
- Олон улсын гэрээ
- Орон нутгийн захиргаа

### ЧАДВАР, ХЭРЭГЛЭЭ

- Хүний эрх, эрх чөлөөний түүхэн хөгжлийн эх сурвалжийг судлан, хүний эрхийн заяагдмал мөн чанарын үндэслэлүүдийг тайлбарлах
- Хүний эрхийн зарчмууд, иргэн, байгууллага, төр нь хүний эрхийг хундэтгэх, хамгаалах талаар хариуцлага хүлээдгийг тайлбарлах
- Орон нутгийн жишээгээр хүний эрхийн зөрчлийг ялган таньж, дүрэм журам, хуулийн хүрээнд хүний эрхийг хэрхэн хамгаалах талаар дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах

## 4.1. ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛ ТҮҮХИЙГ БҮТЭЭСЭН НЬ

Өдгөө болон ирээдүйд зөвхөн та л өөрийн эрхийг хэрэгжүүлнэ. Хүний эрх бол таны эрх. Тэдгээрийг эзэмши, хамгаал, дэлгэрүүл, Түүнийг ойлго, мөн шаард. Тэдэээрийг тэтээж баяжуулагтун.

Кофи Аннан. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан

Бид долоодугаар ангидаа хүүхдийн эрхийн тухай судалж, хүүхэд хамгаалах тогтолцооны тухай зохих мэдлэг ойлголттой болсон билээ. Мөн сургуульд дагаж мөрдөх дүрэм журмууд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалдаг талаар мэдэж авсан билээ. Суралцагчид анги дэвшиж, том болохын хэрээр харилцах хүмүүс, байгууллагууд илүү өргөн хүрээтэй болдог. Та бүхэн гэр бүлийн гишүүд, найзууд, багш нар, сургуулийн захирагатай харилцахаас гадна амьдарч буй орон нутгийн байгууллагуудтай харилцдаг. Энэ бүх харилцаанд тодорхой дүрэм журам, зохицуулалт үйлчилж, оролцогчид, иргэд дагаж мөрддөг тул эрх зүйн харилцаа гэж үздэг.

Нийгэм, орон нутгийн болон хүмүүс хоорондын харилцааг зохицуулдаг гол хэм хэмжээ нь хууль бөгөөд хуулийн гол зорилго бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулах явдал юм. Тиймээс энэ бүлгийн хүрээнд хүний эрхийн тухай ойлголт, түүхэн хөгжил, хүний эрхийн зарчмууд болон хуулиар хүний эрхийг хэрхэн баталгаажуулдаг тухай судлах болно. Мөн орон нутгийн түвшинд нийгмийн харилцаанд оролцож буй иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах арга замуудын талаар дэлгэрүүлэн судалж, өөрсдийн хувь нэмрээ оруулах боломжийг эрэлхийлэх болно.



### Тохиолдол шинжлээрэй

#### Хуулиар хааны эрхийг хязгаарласан нь:

1215 онд Английн хаан Жон “Магна Харта” хэмээх баримт бичигт гарын үсэг зурсныг хүний эрхийн түүхэн баримт бичгүүдийн нэг гэж үздэг. Учир нь “Магна Харта” баримт бичиг нь тухайн үеийн терийн засаглалын үндсэн хэлбэр болох хэмжээгүй эрхт хааны эрх хэмжээг хязгаарласан зөвшилцлийн гэрээ байсан ажээ. Магна Хартад бичсэнээр татвар ногдуулах, улсын төсөв батлах зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ хаан бусад ноёд, язгууртнуудтай зөвшилцөх ёстойг хуульчилжээ. Мөн “Магна Харта”-д тэмдэглэнсээр бүх чөлөөт эрчүүд хууль батлах үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Мөн чөлөөт хүнийг тухайн улсад үйлчилж буй хууль эсвэл шүүхийн хууль ёсны шийдвэргүйгээр баривчлах, хорих зэргээр хор учруулахгүй хэмээн иргэний эрхийг баталгаажуулсан байдаг.

#### Шийдвэрлэх асуудал

- Энэ баримт аль үеийн түүхэнд холбогдох вэ?
- Чөлөөт иргэд, ноёд, язгууртнууд өөрсдийнхөө ямар эрхийн төлөө уг баримт бичгийг санаачилж, хаанд шахалт үзүүлсэн бэ?
- Магна Хартад зааснаар хэн, ямар эрх эдэлж, ямар үүрэг хүлээх вэ?
- “Чөлөөт эр хүн” гэж ямар хүнийг хэлэх вэ? Энэ нь одоогийн “иргэн” хэмээх ойлголтоос ямар ялгаатай вэ?
- Манай улсад Магна Хартатай адилтгах ямар нэгэн баримт бичиг, хууль, гэрээ байдаг уу? Хэрэв тийм гэж үзвэл жишээ гаргаж хэлэлцээрэй.



Зураг 4.1 Магна Харта бичгийн эх хувь



Зураг 4.2 Магна Харта бичигт Английн хаан Жон гарын үсэг зурж байна.

### Түүхэн баримт:

“Магна Харта” хэмээх уг тунхаг бичигт Английн хаан Жон гарын үсэг зурж баталгаажуулснаар тус улсад үндсэн хуулт ёс хөгжих үндэс суурь тавигдсан гэж үздэг. Гэвч гарын үсэг зураад удалгүй Жон хаан бусад ноёд, тайж нарын дарамт, шахалтын доор уг Магна Хартад гарын үсэг зурсан тул энэ гэрээ хүчингүй хэмээн зарлажээ. Түүний энэ мэдэгдэл нь Англи улсад иргэний дайн гарахад хүргэж, 1216 онд Жон хаан амь насаа алдсанаар уг дайн дуусжээ.

Энэ цаг үеийн нөхцөл байдлын талаар жүжигчин Рассель Кроу гол дүрд тоглосон “Робин Гүүд” киног үзэж, түүхийн хичээлээр үзсэн мэдлэгээ сэргээн санаарай.

Хүний эрхийн тухай үзэл санаа хүн төрөлхтөнтэй хамт үүсэн хөгжиж иржээ. Дэлхий дахины тэргүүлэх шашин, соёл болон гүн ухаантнууд хүний эрхийн тухай үзэл санааны олон хэлбэр, агуулгыг дэвшиүүлэн гаргаж, шүүмжлэн хэлэлцэж иржээ. Хүн төрөлхтний түүхэнд тохиолдсон олон тооны дайн, бослого тэмцэл, хувьсгалууд дарлагдан зовсон ард иргэд, боолууд эрх, эрх чөлөөний төлөө эвлэлдэн нэгдэж, тэмцсэнээр эхэлсэн байдаг. Энэ бүгдийн үндсэн дээр хүний эрхийн түүх бүрэлдэн тогтсон аж. Тийм ч учраас “хүн төрөлхтний түүх бол хүний эрхийн төлөө тэмцлийн түүх” хэмээн хэлж болно.

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хуульчлан баталгаажуулах олон оролдлого түүхэнд гарч байсныг жишээ болгон зарим баримт бичгүүдийг авч үзье. Эдгээр баримт бичиг нь хүний эрхийн түүхэн хөгжлийн бүрэн жагсаалт биш боловч хүний эрхийн төлөө тэмцэл олон мянган жилийг дамнан дэлхийн улс орон, үндэстэн бүхэнд өрнөж байсныг батлах болно.

Хүний эрх нь жам ёсны зүйл бөгөөд хүнд өөрт нь угаас заясан, хүнээс салшгүй зүйл тул төрөөс, нийгмийн зүгээс хүний эрхийг хязгаарлан зөрчиж болохгүй гэсэн үзэл санааг эртний Грекийн гүн ухаанд тодорхой гаргаж өгчээ. Энэ үзэл санаа нь Магна Харта, Тусгаар тогтолын тунхаг, Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг олон түүхэн баримт бичгээр баталгаажиж, өнөөгийн хүний эрхийн үзэл санаа бүрэлдэн тогтжээ. Өнөө цагт улс орнууд Үндсэн хуульдаа хүний эрх, эрх чөлөөг тусган баталгаажуулж, хууль ёсоор сахин хамгаалдаг болжээ.



## Хамтран ажиллаарай

Багаар ажиллан дараах хүснэгтийг гүйцээж бичээрэй.

Хүснэгт 4.1 Хүний эрхийн түүхэн баримт бичгүүд, он дарааллаар

Нэр	Он	Хүний эрхэд холбогдох агуулга
Вавилон улсын Хаммурапи хааны хууль:	НТӨ 1750 он	Вавилон улсын анхны хаан Хаммурапи хүн төрөлхтний түүхэнд мэдэгдсэн анхны бичмэл хуулийг боловсруулжээ. Уг хуульд буруутгаж буй тал нь яллаж буй хүнийхээ гэм бурууг нотлох хүртэл тухайн яллагдагч гэм буруугүй гэж үзнэ гэсэн санааг агуулсан байдаг.
Күнзийн сургаал:	.....	Дорнын их сэтгэгч Күнз “Бусдаас хүсэж буй зүйлээ өөрөө бусдад хандуулан үйлд, бусдаас хүсэхгүй зүйлээ бусдад хандан бүү үйлд” хэмээн Ёс суртахууны алтан зарчмыг тодорхойлсон нь хүний эрхийн үндсэн зарчмуудыг агуулсан гэж үздэг.
.....	1689 он	Уг баримт бичгийг Английн Парламент 1689 онд баталжээ. Үүнд парламентын зөвшөөрөлгүйгээр татвар ногдуулах, сонгуульд саад хийх, аливаа хуулийн үйлчлэлийг зогсоох зэрэг үйлдлийг эзэн хаан хийхийг хоригложээ. Мөн парламентын хуралдаанд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг анх баталгаажуулсан байна.
АНУ Тусгаар тогтолын тунхаглал:	1776 он	..... .....



## Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Дээр дурдсан баримт бичгүүд түүхийн аль үе, ангилалд хамаарах вэ?
- Түүхийн хичээлд дээрх баримт бичиг, үйл явдлыг хэрхэн тайлбарладаг вэ?
- Эдгээр баримт бичгийн аль заалт, үзэл санаа өнөө цагт бүрэн хэрэгжиж чадаж байна вэ? Мөн огт хэрэгжиж чадахгүй байгаа заалтууд байвал энэ талаар өөрийн байр сууриа бусдад хэлж, харилцан саналаа нэгтгээрэй.
- Хүний эрхийн тухай бусад баримт бичгүүдийн талаар ширээний андтайгаа дэлгэрүүлэн ярилцаарай. Тодорхой он тоолол, түүхэн үйл явдалд холбогдох баримт бичгийн талаар мэдээлэл бэлтгэж бусдадаа танилцуулах байдлаар дээрх хүснэгтийг нэмж баяжуулаарай.
- Орчин үед ямар асуудлаар хүний эрхийг баталгаажуулах, олон улсын гэрээ байгуулахаар улс орнууд хэлэлцэж байна вэ? Энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, төрийн байгууллагуудаас мэдээлэл авч судлаарай.



## Гэртээ хийгээрэй

### Хүний эрхийн төлөө тэмцэгчид

- Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн тухай та нар юу мэдэх вэ?
- Таны хувьд хүний эрхийн төлөө тэмцэгчийн жагсаалтад хэнийг оруулах вэ?
- Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн тухай сонирхолтой мэдээлэл, баримтууд цуглуулж, аль болох дэлгэрэнгүй жагсаалт хийж баяжуулаарай.



## Хамтран ажиллаарай




Бүдүүч 4.1 Хүний эрхийн он дараалал хийх жишиг

- Ангийн сурагчид 5-6 бүлэгт хуваагдаж, хүний эрхийн түүхэн хөгжлийн он дарааллын загварчлалыг боловсруулаарай. Энэ дасгалыг гүйцэтгэхдээ түүхийн хичээллээр үзсэн мэдлэг, туршлагаа аль болох ашиглаарай.
- Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн нэр, амьдарч байсан цаг хугацаа, гол үзэл санаа, бүтээлийг дээрх үечлэлд оруулаарай. Тэдгээр хүмүүсийн гавьяя, сайн үйлс, хүний эрхийн төлөөх гол ололтуудын талаар нэмэлт мэдээлэл цуглуулж, бусдадаа тайлбарлаарай.
- Хүний эрхийн төлөө хувь нэмрээ оруулсан түүхэн хүмүүс, үйл явдлын талаар товч мэдээлэл бүхий картууд хийж, он дарааллын дагуу байрлуулаарай.
- Монголчуудын эрхийн төлөө хэн, хэрхэн тэмцсэн тухай мэдээлэл бэлтгэж, холбогдох цаг хугацааны дараалалд оруулаарай.

## 4.2. ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧМУУДЫГ МЭДЭХ ҮҮ?

- Дээрх зургийг сайтар ажиглана уу. Эхний зургийг “Тэгш байдал”, хоёр дахь зургийг “Тэгш эрх” хэмээн нэрлэжээ.
- “Тэгш байдал” ба “Тэгш эрх” хоёрын хооронд ямар ялгаа байна вэ?
- Энэ хоёр ойлголт хүний эрхтэй хэрхэн холбогдох вэ?



Зураг 4.3 Тэгш байдал, Тэгш эрх гэх хандлагын ялгааг харуулсан нь

Хүмүүс эрх, эрх чөлөөгөө здлэх, нөгөө талаас хүн бүрийн эрхийг хангах, хамгаалахын тулд хүний эрхийн зарчмуудыг тодорхойлж, мөрдлөг болгон хэрэгжүүлдэг билээ. Эдгээр зарчмууд нь хүний эрхийн тухай олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжид тусгалаа олдог. Хүний эрхийн зарчмуудыг бодитой хэрэгжүүлэх нь хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үндэс суурь болдог.



### Эх сурвалжтай ажиллаарай

.... Энэ бүгдийн эцэст хүний түгээмэл эрх хаанаас эхлэх вэ? Хүний эрх нь дэлхийн газрын зураг дээр тэмдэглэгдэж байгаагүй бичил, жижигхэн орчноос эхэлнэ. Өөрөөр хэлбэл хүмүүс, түүнтэй зэрэгцэн амьдарч буй хөршүүд, сурч буй сургууль, ажиллаж буй үйлдвэр, ферм зэргээс эхэлнэ. Тэдгээр газарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхэд бүхэн ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүй, шударга ёс, тэгш бололцоо, эрх тэгш байдлыг хүсэн хайж байна.

(Эльеонар Рузвельт, Их асуултууд, 1958 он)




### Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Эльеонар Рузвельтийн “Хүний түгээмэл эрх” хэмээх ойлголт ямар санааг илэрхийлэх вэ?
- Хүмүүс гэр бүл, амьдарч буй орчин, орон нутагтаа чухам ямар зүйлийг хүсдэг тухай хэрхэн илэрхийлсэн бэ?
- Яагаад гэр бүл, хөрш, орон нутагтаа эрхээ эдэлж чадвал дэлхий нийтээр сайн сайхан болно гэж тэрээр үзсэн бэ?
- Хүний эрхийг хамгаалахад хувь хүн ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал яагаад дэлхийд хамгийн олон хэлээр орчуулагдсан бэ?



Зураг 4.4 Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч  
Эльеонар Рузвельт



Дэлхийн хоёрдугаар дайны учруулсан гайгамшиг нь хүний эрхийг хамгаалах олон улсын нийтлэг хэм хэмжээ, тогтолцоо боловсруулахыг дэлхий нийтэд уриалсан гол алхам болов. Үүний үр дүнд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, нийгэм, хүмүүнлэгийн асуудлыг хамтран шийдвэрлэхээр улс орнууд зөвшилцэж, 1945 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагыг /НҮБ/ байгуулжээ. Улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг 1948 оны 12 дугаар сарын 10-нд баталжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг орчин үеийн хүний эрх, эрх чөлөөний “Үндсэн хууль” гэж хэлж болно.

Зураг 4.5. Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь дэлхийн 370 хэлээр орчуулагдсанаар Дэлхийн рекорд Гиннесийн номд бичигджээ.

Энэхүү тунхаглалд хүн бүр арьсны өнгө, үндэс угсаа, нас хүйс, хэл, шашина шүтлэг, нийгмийн гарал, эд хөрөнгө болон бусад байдлыг үл харгалзан адил тэгш эрхтэй болохыг тунхаглан баталгаажуулжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд үндэслэн, түүнээс салбарласан хүний эрхийн гэрээ, конвенц, олон улсын эрх зүйн баримт бичгүүд гарсаар байна.

**Гол санаа.** Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактыг хамтад нь Хүний эрхийн билл буюу хүний эрхийн суурь баримт бичгүүд гэж нэрлэдэг. Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд хүний эрхийн гэрээ, конвенц, протоколуудад идэвхтэй нэгдэн орж, хэрэгжүүлдэг. 1921 оноос өнөөг хүртэл Монгол Улс 3000 орчим хоёр талт олон улсын гэрээ байгуулж, 180-аад олон талт гэрээнд нэгдэн оржээ. Үүнээс хүний эрх, эрх чөлөөтэй шууд холбоотой 40 гаруй гэрээ, конвенцэд нэгдэн оржээ.

Тунхаглалыг дагалдан хүний эрхийн хоёр суурь гэрээг 1966 онд НҮБ-аас баталжээ. Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактад амьд явах, эрх чөлөөтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, хуулийн өмнө эрх тэгш байх, ялгаварлан гадуурхалтаасангидбайх зэрэг эрхийг баталгаажуулсан байна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нийгэм, соёлын амьдралд оролцох эрх, сурч боловсрох, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, хэл соёлоо хамгаалах, амьжиргааны зохистой түвшинд амьдрах зэрэг эрхийг баталгаажуулсан байна. Эдгээр олон улсын пакт болон тэдгээрт тусган баталгаажуулсан эрх, эрх чөлөөний тухай та бүхэн есдүгээр ангидaa дэлгэрүүлэн үзэх болно.

### Хүний эрхийн зарчмууд



- Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим:** Хүн бүр “хүн” болж төрснийхөө хувьд хамгийн эрхэм, үнэ цэнэтэй. Тиймээс ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран хүн бүрд хүндэтгэлтэй хандах ёстой.



- Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим:** Хүмүүс нас, хүйс, арьс үндэс, нийгмийн анги давхраа зэргээс үл хамааран хүн болон мэндэлснийхээ хувьд эрх тэгш байна. Хүн бүрийн эрхэм зэргийг хүндэтгэн, аливаа байдлаар алагчлах, ялгаварлан гадуурхах ёсгүй.



- Салшгүй байх зарчим:** Хүний эрх нь төрөөс олгож буй “хишиг” биш, харин хүн төрж мэндлэхэд нь хамт заяадаг түүний төрөлх чанар юм. Иймд хүний эрх нь хүн бүрийн амьдралын салшгүй хэсэг байна.



- Түгээмэл байх зарчим:** Хүний эрх нь хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлс тул дэлхийн бүх улс орон, бүс нутагт хүлээн зөвшөөрч, нэг мөр ойлгож хэрэгжүүлнэ.



- Хуваагдашгүй байх зарчим:** Иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрх нэгдмэл, хуваагдашгүй байна. Хүн бүр олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх, эрх чөлөөг бүрэн эдлэх ёстой.



**6. Харилцан хамааралтай байх зарчим:** Хүний нэг эрх зөрчигдөхөд бусад эрх мөн зөрчигдөх үндэс болно. Иймд хүний эрхийн бүхий л асуудлыг өөр хооронд нь харилцан хамааралтай, цогц байдлаар шийдвэрлэх ёстой.



**7. Тэгш байх зарчим:** Хүний бүх эрх, эрх чөлөө адил тэгш хүчинтэй байх бөгөөд нэг эрх нь бусдаас илүү чухал, давуу гэж үзэж болохгүй.



**8. Хариуцлага хүлээх зарчим:** Хүн бүр бусдын эрхийг хүндэтгэх, хангах, эрхээ шаардах, мөн хүний эрхийн зөрчилтэй тэмцэх үүрэгтэй. Мөн төр, төрийн ба бизнесийн байгууллага зэрэг нийгмийн бусад нэгж хэсгүүд хүний эрхийг хангах, хөхиүлэн дэмжих, хамгаалах үүрэг хүлээдэг.



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Орон нутгийн жишээнд тулгуурлан эдгээр зарчим хэрхэн хэрэгжиж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх хэлэлцүүлэг өрнүүлээрэй.
- Хэлэлцүүлэгтээ тулгуурлан зарчмуудыг хэрэгжилтээр нь эрэмбэлээрэй.
- Хамгийн хангалтгүй хэрэгжилт бүхий зарчмуудыг тодорхойлж, тэдгээрийг сайжруулах арга замын талаар санал боловсруулаарай.

Хүний эрхийн өмнө хариуцлага хүлээх зарчмын дагуу төр нь иргэний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах үүргийг хүлээдэг. 1992 оны Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хоёрдугаар бүлэгт 80 гаруй эрх, эрх чөлөөг тусгайлан нэрлэж, баталгаажуулсан байх бөгөөд Үндсэн хуулийн бусад бүлгүүдэд хүний эрхтэй холбогдолтой олон заалт, зарчмуудыг тусгасан байдаг.

Мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу сум, дүүрэг, баг, хороогоор дамжин төрийн үйлчилгээ иргэдэд хүрдэг. Иймд иргэд төрийн байгууллагуудад хандаж, эрхээ хамгаалуулах боломжтой. Энэ тухай бид дараагийн хичээлүүдээр дэлгэрүүлэн судлах болно.



### Хамтран ажиллаарай

#### Хүний эрхийн баримт бичгүүдийг харьцуулах нь

**Зорилго:** Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөний агуулгатай харьцуулах, хүний эрхийг хамгаалах төрийн бодлого, үйл ажиллагааны талаар асуудал дэвшүүлнэ.

**Хэрэглэгдэхүүн:** Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн хууль

**Заавар:** Дараах хүснэгтийн эхний баганад Хүний эрхийн түгээмэл тунхаглалд жагсаасан эрх, эрх чөлөөг жагсаан бичсэн. Эдгээр эрх, эрх чөлөөг Монгол Улсын Үндсэн хуульд хэрхэн тусгаж, тодорхойлсныг хоёр дахь баганын харгалзах хэсэгт тэмдэглэж хүснэгтийг гүйцээгээрэй.

### Хүснэгт 4.2 Хүний эрхийн баримт бичгүүдийг харьцуулах нь

№	Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)	Монгол Улсын Үндсэн хууль
1	Хүн бүр эрх чөлөөтэй, эрх тэгш төрсөн.	
2	Бүү ялгаварлан гадуурх. Хүн бүр ялгаатай байдлаас үл хамааран бүх эрхийг эдэлдэг.	
3	Бид бүгд амьд явах, эрх чөлөөтэй, аюулгүй амьдрах эрхтэй.	
4	Хууль хүн бүрд ижил үйлчилдэг. Хууль хүн бүрд эрх тэгш хандах ёстой.	

- Хүний эрхийн түгээмэл тунхаглалд байгаа зарим эрх Үндсэн хуульд тусгагдаагүй бол үүнийг хэрхэн тайлбарлах вэ?
- Таны бодлоор Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Үндсэн хууль тус бүр ямар давуу талтай вэ?
- Монгол улсын иргэдэд энэ хоёр баримт бичигт тусгаснаас өөр эрх бий юу?
- Хэрэв тийм бол чухам ямар эрх вэ? Одоо нэмж оруулах боломжтой юу?
- Энэ дасгалаас таны мэдэж авсан хамгийн чухал зүйл юу вэ?

### 4.3 ЭРХ ТЭГШ БАЙДАЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

“Хэрэв шударга ёс алга болбол хүмүүсийн амьдралд өөр үнэт зүйл үлдэхгүй”.  
Германы сэргээгч Иммануил Кант (1724-1804 он)



Зураг 4.6 Хүний эрх дэлхий дахинд

- Дээрх зураг тус бүрд юун тухай өгүүлж буй талаар харилцан ярилцаарай
- Хүний эрхийн зарчмуудтай хэрхэн холбогдох вэ?

Өнөөдөр дэлхийн 200 гаруй улс оронд нийт 7.2 тэрбум илүү хүн амьдарч байна. Тэдгээр хүмүүс арьсны өнгө, шашин шүтлэг, эрхлэх аж ахуй, хэл соёл, зан заншил гээд олон зүйлээрээ хоорондоо ялгаатай байдаг. Түүнээс гадна улс орон бүрийн туулж өнгөрүүлсэн түүх, төр, засгийн тогтолцоо, байгаль орчин, улс орны хөгжил зэрэг нь ч өөр байдаг. Та нар ч гэсэн бусад улс орны хүүхдүүд хэрхэн яаж амьдардаг, ямар сургуульд сурч байгаа тухай телевизээс, киноноос бас ном, сурх бичгээсээ уншиж мэддэг шүү дээ. Энэ талаар бид илүү сайн мэдэхийн тулд дараах дасгалыг ажиллацаа.



## Асуудал шийдвэрлээрэй

### Хүний эрх - Амьдралын толь

**Заавар:** Сурах бичигт дүрсэлсний адил аар олон соёл, амьдралын өөр өөр хэв маягийг тусгасан фото зургууд цуглуулаарай.

#### Зургийг ажиглах нь:

5-6 сурагч нэг бүлэг болж, өөрсдийн зургийн цуглуулгаас зургаан зураг сонгон авна. Зургуудыг сайтар ажиглан харж, дараах асуултын дагуу ярилцаарай.

- Танай бүлэг яагаад энэ зургийг сонгон авсан бэ?
- Энэ зургаас та нар өөрсдийн **амьдралын толь** болох ойр дотно, танил ямар зүйлсийг олж харж байна?
- Мөн бусдын **амьдралын цонх** болох өөр амьдралын хэв маяг, соёлоос юуг олж харж байна вэ?
- Зураг дээрх хүний байдал, сэтгэгдэл ямар байгаа бол? Тэдний итгэл найдвар, хүлээлт юу вэ?
- Өөртэй чинь адил ямар зүйлсийг та олж харж байна вэ? Үзэл бодол, итгэл найдвар, ирээдүй адил байж болох уу?
- Энэ зурагт ялгаварлан гадуурхалт, шударга бус байдал хэрхэн туссан бэ?


#### Зургийг бүлэглэх нь:

Бүх зургийг нэгтгэн ангийн ханан дээр байрлуулна. Сонгосон зургуудыг агуулга, цаг хугацаа, бүс нутаг зэрэг олон шалгуураар бүлэглэж болно. Үүний дараа мөн дараах асуултын дагуу хэлэлцээрэй.

- Зургуудад ямар нийтлэг тал байна вэ?
- Дээрх зурагт хүний эрхийн үүднээс үнэлэлт өгвөл Та юу гэж хэлэх вэ?
- Хүмүүс яагаад ийнхүү олон янзын амьдралын хэв маягтай байдаг вэ?
- Хэрвээ одоогоос 20 жилийн дараа гэвэл зургууд хэрхэн өөрчлөгдх вэ?
- Хүмүүсийн амьдралын хэв маяг, соёлын ялгааны талаар та нар ямар дүгнэлтэд хүрч байна вэ?

### Нийгэм дэх хүмүүс хоорондын ялгаа

Аливаа хүн нийгэмд өөрийн гэсэн байр суурьтай байдаг. Хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь нь тэдний хоорондын ялгаан дээр үндэслэдэг. Хүмүүс хоорондын ялгаа нь тэдний нийгмийн шинж чанараас шалтгаалан төрөлхийн ба төрөлхийн бус ялгарал гэж ангилдаг.



Бүдүүеч 4.2 Хүмүүс хоорондын ялгаатай байдал

Ялангуяа төрөлхийн ялгарал нь хүмүүс хоорондын тэгш бус харилцаа үүсэх анхдагч нөхцөл болдог. Үүнд тухайн хүний нас, хүйс, үндэс угсаа, биеийн хүч

чадал, гоо үзэсгэлэн, оюун ухааны чадамж зэрэг эцэг эхээс өвлөн авсан удамшлын шинжүүд хамаардаг. Харин төрөлхийн бус ялгарал гэдэг нь тухайн хүн өөрийн амьдралын явцад олж авсан шинж чанарууд юм. Үүнд тухайн хүний нэр хүнд, боловсрол, мэдлэг мэргэжил, ажлын туршлага зэрэг болно. Эдгээр шинжээрээ хүмүүс хоорондоо ялгаатай байгааг нийгмийн ялгарал гэдэг. Орчин үеийн нийгэмд ажил мэргэжил, амьдралын хэв маяг, нэр хүнд зэрэг нь тухайн хүний нийгэмд эзлэх байр суурийг илүү тодорхойлдог.

Хүмүүс ийнхүү хоорондоо ялгаатай байгаа нь огт буруу зүйл биш юм. Яагаад гэвэл хүн бүр өөрийн гэсэн амьдралтай, үзэл бодолтой байдаг. Харин бусдыг ямар нэгэн хэлбэрээр алагчлан үзэх нь буруу юм. Бид өөр үзэл бодол, байр суурьтай байгаа нэгийгээ хүндэтгэн харилцдаг байх нь хамгийн сайн чанар билээ.

**Тохиолдол** "Одоогийн байдлаар дэлхийн хэмжээнд нийт 257 тэрбумтан, хоёр сая орчим америк долларын саятан байна. Гэтэл дэлхийн хүн амын 20% нь болох 1.1 тэрбум хүн өдөрт 2 доллараас бага орлоготой байна" гэсэн тооцоог эрдэмтэд хийжээ.

- Яагаад ийм тэгш бус байдал үүссэн бэ?
- Баян ядуугийн ялгаа ийм их байгаа нь шударга зүйл мөн үү?
- Энэ тэгш бус байдлыг арилгахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэх явцдаа аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй хэмээх санааг хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээр болон үндэсний хууль тогтоомжид баталгаажуулж өгсөн. Хүний эрхийг хангаж, хамгаалах явцад баримтлах ёстой нэг үндсэн зарчим бол ялгаварлан гадуурхахгүй байх зарчим билээ.

Ялгаварлан гадуурхалт нь эрх тэгш байдлыг үгүйсгэж, хүний эрх зөрчигдөхөд хүргэдэг. Жишээ нь: ажил олгогч, залуу хүмүүсийг ажиллуулна хэмээх ялгаварлалаас үүдэж олон тооны хүмүүсийн хөдөлмөрлөх эрх нь зөрчигддэг байна.

**Гол санаа.** Улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний гэх мэт аливаа салбарт хүнийг яс үндэс, арьс өнгө, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс териийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн буюу бусад байдалд нь үндэслэн алагчлах буюу хязгаарлахыг ялгаварлан гадуурхалт гэнэ.

Хүний эрхийн ихэнх зөрчил нь ялгаварлан гадуурхах явдалд үндэслэн гардаг тул ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нь нэн чухал юм. Хүүхдүүд ялгаварлан гадуурхалтын талаар дараах зүйлийг зайлшгүй мэдсэн байвал зохино.

- Ялгаварлан гадуурхалтыг хуулиар хориглодог.
- Ялгаварлан гадуурхалт нь хүний эрхийн зөрчилд хүргэдэг.
- Ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлснээр өш хонзон, мөргөлдөөнд хүргэнэ.
- Өөрөөсөө үзэл бодол, гарал үүсэл, нийгмийн байдал, хүйс, шүтлэг бишрэлээр ялгаатай хүмүүст хүлээцтэй хандах үүргийг хүн бүр хүлээдэг.
- Зарим бүлэгт зориулсан тусгай хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд боломж олгох нь ялгаварлан гадуурхалт биш.

Төрийн зүгээс зарим бүлгийн гишүүдэд учирсан тэгш бус байдлыг арилгах зорилгоор “хүний эрхийг хангах түр, тусгай арга хэмжээ” хэмээх тодорхой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тухайн бүлгийн гишүүд эрхээ эдлэх тэгш боломжтой болмогц уг арга хэмжээ, хөтөлбөрийг зогсоодог тул “түр, тусгай арга хэмжээ” хэмээн нэрлэдэг. Жишээлбэл: сурч боловсрох тэгш боломж олгох үүднээс эмзэг бүлгийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл олгох, дүрвэгчдийг хоол, хүнс, эд зүйл, орон байраар хангах зэрэг болно. Иймд энэ төрлийн хөтөлбөр, арга хэмжээг ялгаварлан гадуурхалт хэмээн үздэггүй.

Өнөөгийн нийгэмд хүн бүрд эрх тэгш нэг боломж бол үнэ төлбөргүй суралцаж, өөрийн хүссэн мэргэжлээ зээмших явдал юм. Мэргэжилтэй, боловсролтой хүн зохих орлоготой, нэр хүндтэй, хамт олонтой байх бөгөөд энэ нь түүнийг аливаа ялгаварлан гадуурхалтад өртөхгүй, эрх тэгш нийгмийн гишүүн болох үндэс болно. Тиймээс сурагч та бүхэн өмнөө тавьсан зорилготой байж өөрийнхөө сонирхол, чадварт нийцсэн мэргэжлээс сонголт хийж, сайтар хичээн суралцах хэрэгтэй.



Хүү амьсгалын дутагдалд орж эндэх шаажээ. Тэр амьд гарсан ч төрөхийн хүндрэлээс болж тархи, нуруу, нугасны саажилттай болжээ. Эмч хүүг нь том болоод амьдрах чадваргүй нэгэн болж өснө гэжээ. Ээж нь эмчийн хэлснийг огт хүлээн зөвшөөрсөнгүй. Ээж нь хүүгээ хөгжлийн бэрхшээлээсээ болж бусдаас ичээсэй гэж хүсээгүй учир ердийн сургуульд сургав. Тэрээр ээж, найзуудынхаа тусламж дэмжлэгтэйгээр амжилттай суралцаж байв. Олон зүйлээр бусдаас дутуу ч түүнийг даван туулж, тэсвэрлэх хэрэгтэйг ээж нь хүүд байнга зөвлөдөг байв. Хүү цаашид их сургуульд суралцан амжилттай суралцаж төгсөв. Ээж, найзууд минь надад үргэлж урам зориг хайрладаг учир би сургуулиа амжилттай төгсөж чадлаа гэж тэр хэлжээ.



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

1. Зарим сайн, шилдэг сурагчийг бусад сурагчаас ялгаж, онцгойлон хандах нь ялгаварлан гадуурхалт мөн үү? Үүнийг зөвтгөх ямар үндэслэл байж болох вэ? Мөн бол ямар хор уршигтай вэ?
2. Хүүхдүүд бие үндэстэн, ястны онцлогоор дооглон тохуурхсан үг хэллэг хэрэглэх нь ялгаварлан гадуурхах явдал мөн үү? Яагаад?
3. Хог асгах нь зөвхөн охидын ажил гэх нь ялгаварлан гадуурхалт мөн үү?
4. Ахлах ангид суралцаж байгаа хөвгүүд, охидоос цөөн байгаа нь хүйсээр ялгаварлан гадуурхсан явдал мөн үү?
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох боломжоор үл хангагдаж буй нөхцөл байдлыг ялгаварлан гадуурхалт гэж үзэх үү?

*Шийдвэр гаргагчдад өөрийн үзээ хүргэх хамгийн энгийн арга хэлбэр бол шуудан, факс, цахим шуудангаар дамжуулан захидал илгээх явдал юм.*


**Санамж:** Албан захидал бичихдээ төрийн албан ёсны тогтсон үг хэллэгийг баримтлан бичнэ. Албан бичиг нь найруулгын хувьд ямар нэгэн алдаа мадаггүй, товч тодорхой, ойлгомжтой, энгийн, өгүүлж буй зүйл нь утга төгөлдөр байвал та бүхний саналыг үр дүнтэй шийдвэрлэхэд нөлөөлөх болно. Албан захидал бичихдээ албан бичгийн стандарт, найруулга зэрэгт сайтар анхаараарай.

## 4.4 ХҮНИЙ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ НЬ ЗӨВ ҮҮ?



- Хүний эрхийг ямар нэгэн байдлаар хязгаарлах шаардлагатай юу?
- Хэрэв тийм бол ямар тохиолдолд хүний эрхийг хэрхэн хязгаарлах вэ?
- Хүний эрхийг хязгаарлаж буй тодорхой жишээ баримтыг дурдана уу?
- Хүний эрхийн хязгаарлалтын талаар мэдэх нь яагаад чухал вэ?

Аливаа эрх, эрх чөлөө нь туйлын биш бөгөөд ямагт үүрэг хариуцлагыг өөртөө агуулж байдаг тухай бид өмнөх хичээлээр үзсэн билээ. Түүнээс гадна эрх мөн хязгааргүй боломж биш бөгөөд тодорхой хэм хэмжээ, хуулийн хүрээнд хязгаарлагддаг. Хүний эрхийн хязгаарыг тогтоосон хэм хэмжээ нь ёс суртахуун, эрх зүй, хүнлэг байх, шударга байх зэрэг ойлголттой салшгүй холбоотой. Аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол зэргээс улбаалж хүний эрх гэдэг ойлголтыг хуулийн хүрээнд хязгаарлах тухай үзэл санаа гарсан билээ.



*“Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй”*

**Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн  
2 дахь хэсэг**

Зайлшгүй нөхцөл байдал үүссэн, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгын үүднээс гагцхүү хуулиар хүний эрхийг хязгаарлах нь ардчилсан нийгэмд төрөөс хүний эрхийг хамгаалах, хүний эрхийг хангах чухал зарчим юм. Хүний эрхийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хязгаарлах нь бусдын эрх, эрх чөлөөг хөндөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой тул зарим талаар хүний эрхийг хангах арга хэмжээ болдог. Тодруулбал, гоц халдварт өвчин дэгдэх үед тухайн орон нутагт байгаа хүмүүст хөл хороо тогтоож, зорчих эрхийг нь тодорхой хугацаанд хязгаарладаг. Энэ нь халдварт өвчин олон нийтэд тархаж, иргэдийн эрүүл мэнд доройтох, эрүүл мэндээр хохирохоос урьдчилан сэргийлж буй арга хэмжээ юм.

**Гол санаа.** “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгийн хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.”

**Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг”**

Ардчилсан нийгэмд хүний эрхийг дараах хоёр тохиолдолд хязгаарладаг. Эхнийх нь бусдын эрх, эрх чөлөөг зөрчсөн этгээдийн тодорхой эрхийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хязгаарладаг. Хоёрдугаарт үндэсний аюулгүй байдал, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор онцгой нөхцөл байдал үссэн үед зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүний эрхийг хязгаарладаг.



### Хамтран ажиллаарай

#### Хүснэгт 4.3 Хүний эрхийг хязгаарлах үндэслэл

ХЭТТ-д заасан хүний эрх	Эрх хязгаарлах үндэслэл	Эрхийг хязгаарлах үндэслэлтэй эсэх
Чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрх 18 дугаар зүйл	Хэн нэгнийг арьс үндсээр нь дайрч доромжлон үндэстний цөөнхийн эсрэг хучирхийлэлд турхирчээ.	
Хувийн эрх болон гэр бүлийн амьдралыг хүндлэх 12 дугаар зүйл	Сурвалжлагч нэгэн алдартай хүний хувийн амьдралын талаарх таагүй мэдээллийг сонинд нийтлэн олон хүнд тараажээ.	
Эрх чөлөөтэй байх эрх 3 дугаар зүйл	Хэн нэгнийг аллага үйлдэхээр завдсан гэмт хэрэгт буруутган широнд хорьсон байна.	

- Дээрх хүснэгтийг гүйцээж, харилцан ярилцаарай.
- Хүний эрхийг хязгаарлах үндэслэлтэй эсэх талаар өөрийн саналаа зохих хэсэгт бичээрэй.
- Боломжтой бол хүний эрхийн хязгаарлалтын талаар өөрсдийн мэдэх жишээг оруулж, тайлбараа бичээрэй.



### Гэртээ хийгээрэй

#### Захидал бичээрэй.

Та өөрийн аймгийн (дүүргийн) Засаг даргын дэргэдэх Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Ажлын хэсгийн гишүүнээр томилогдсон гэж үзье. Та Ажлын хэсгийнхээ анхны уулзалтад очихын өмнө иргээдийн эрх зүйн боловсролыг дэмжих талаар хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны жагсаалт гаргаж, саналуудаа ач холбогдоор нь дугаарлаарай. Ангийнхантайгаа энэ жагсаалтаа хэлэлцээд Засаг даргад зөвлөмж болох 5 хүртэлх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон захидал бичээрэй.

**Санамж:** Албан захидал бичихдээ төрийн албан ёсны тогтсон үг хэллэгийг баримтлан бичнэ. Албан бичиг нь найруулгын хувьд ямар нэгэн алдаа мадаггүй, товч тодорхой, ойлгомжтой, энгийн, өгүүлж буй зүйл нь утга төгөлдөр байвал та бүхний саналыг үр дүнтэй шийдвэрлэхэд нөлөөлөх болно. Албан захидал бичихдээ албан бичгийн стандарт, найруулга зэрэгт сайтар анхаараарай.

## 4.5. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ НУТГИЙН ЗАХИРГААНЫ ҮҮРЭГ БОЛОХ НЬ



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Эрх эдлэгч, үүрэг хүлээгч гэж хэн бэ? Та нар аль нь вэ?
- “Эрх эдлэгч”, Үүрэг хүлээгч” хэмээн ялган үзэх нь ямар ач холбогдолтой вэ?
- Зөвхөн эрхээ эдлээд, үүрэг хүлээхгүй байх боломжтой юу?
- Яагаад “Төр – Үүрэг хүлээгч” болдог вэ?

Иргэн-төр хоёр бол улс орон хэмээх нэгэн цогц зүйлийг бүрдүүлэгч бөгөөд өөр хоорондоо эрх тэгш харилцаатай байна. Хүний эрх нь иргэн төр хоёрын хоорондын эрх тэгш харилцааны хэм хэмжээг агуулдаг. Төр болон иргэн хоорондын харилцаанд эрх, үүрэг байнга хамт яригддаг. Өөрөөр хэлбэл, төр иргэнийхээ өмнө, иргэн нь төрийн өмнө хуулийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Иймд эрх, үүрэг хоёрыг нэг зоосны хоёр тал хэмээн нэрлэдэг билээ. Эрх үүргийн нэгдлийг хослуулах нь шударга ёсны зарчим юм. Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжид тусгалаа олж, баталгаажсан хүний эрхийн зарчмуудтай холбогдуулан “Эрх эдлэгч”, Үүрэг хүлээгч” гэх ойлголтууд гарч ирдэг. “Эрх эдлэгч”, “Үүрэг хүлээгч” аль аль нь өөрсдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлснээр тухайн нийгэм хөгждөг байна. Үүнд хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх болон хүний эрхийг зөрчихөөс татгалзах зэрэг бүхий л үүрэг, хариуцлагыг багтаан ойлгоно.

#### Эрх эдлэгч - Хүн

Хүний эрх нь хүн бүрд төрж мэндлэхэд нь хамт заяадаг төрөлх чанар тул хүн бүр - эрх эдлэгч болно. Гэхдээ хүн бүр бусдын эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ.

#### Үүрэг хүлээгч - Төр

Төр нь хүн эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх, бусдын эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх, хүний эрх зөрчигчдэд хариуцлага оногдуулах эрх хэмжээтэй тул төр - үүрэг хүлээгч болно.

Хүний эрхийн олон улсын тогтолцоо, гэрээ конвенц нь Засгийн газар ард түмнийхээ төлөө юу хийх тухай үндсэн чиглэлийг тодорхойлж өгдөг. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төр нь хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой байгууллага, тогтолцоог бүрдүүлэн ажилладаг. Үүнийг хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо гэнэ. Хүний эрхийн үндэсний тогтолцоонд хамрагдах байгууллагуудыг дараах байдлаар ангилан үздэг. Үүнд:

1. Төрийн байгууллагууд (төрийн ба нутгийн захиргааны байгууллагууд)
2. Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага
3. Иргэний нийгмийн байгууллагууд зэрэг болно.

Иймд Засгийн газар, түүний дотор орон нутгийн засаг захиргааны байгууллагууд эдийн засаг, нийгэм, соёлын талаар бодлого боловсруулж, төсөв хөрөнгө хуваарилах замаар хүний эрхийн хэрэгжилтийг хангана. Иргэд эрхээ эдлэх баталгааг бүрдүүлэхийн тулд орон нутгийн захиргааны байгууллагууд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

<b>Хүндэтгэх үүрэг:</b> Төр хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулна.	<b>Хангах үүрэг:</b> Төрийн зүгээс сургууль, эмнэлгийг байгуулах зэргээр хүн бүр эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
<b>ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААР ТӨРИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ</b>	
<b>Хамгаалах үүрэг:</b> Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх нь зөрчигдвэл сэргээн эдлүүлэх	<b>Ахиц дэвшил гаргах үүрэг:</b> Хүний эрхийн талаарх ололт амжилттаа бататгаж, ямагт ахиц дэвшил гаргах

Бүдүүч 4.3 Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүрэг

Төр иргэддээ нийгмийн халамжийн, боловсролын, эрүүл мэндийн, мэдээллийн зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Эдгээр үйлчилгээнь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу сүм, дүүрэг, баг, хороогоор дамжин хэрэгждэг. Төрийн үйлчилгээ нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын баримт бичгээр баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах зорилготой цогц үйл ажиллагаа юм.

Орон нутгийн захиргаа нь хүний эрхийг хангах, хамгаалах үүрэгтэй. Үүний тулд байгууллага бүр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, холбогдох чиглэлийн дагуу иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлдэг.



### Тохиолдол шинжлээрэй

Орон нутгийн захиргаа орчны бохирдлын талаар ямар үүрэг хүлээх вэ?

**Тохиолдол 1:** Иргэн Э нь 14 настай бөгөөд тэдний гэр Улаанбаатар хотын агаарын бохирдол хамгийн ихтэй гэр хороололд амьдардаг. Тэр энэ жилээс эхлэн бие нь өвдөх болсон тул эмчид үзүүлтэл уушгины багтраа хэмээх онош тавьжээ. Тэрээр байнга эмчийн хяналтад байж, үнэ ихтэй эмийг өндөр тунгаар уух болов. Өвлийн нэгэн өглөө агаарын бохирдлын индекс зөвшөөрөгдөх хэмжээнээс дээш гарахад түүний бие эрс муудаж, эмнэлэгт хэвтлээ.

Агаарын бохирдлын шалтгаан болон хүүгийн бие өвдсөн учрыг тайлбарлана уу?  
Үе тохиолдоос цаашид урган гарах үр дагаврыг тодорхойлон хэлэлцээрэй.

**Тохиолдол 2:** Орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдалд үндны ус, хог, бохир ус зайлцуулах, бие засах газрын асуудал багтдаг. Монгол Улсын нийт өрхийн 6.6 хувь нь хамгаалалтгүй эх үүсвэрээс үндны усны хэрэгцээгээ хангадаг, 50.9 хувь нь бохироо ил задгай асгадаг, 68,6 хувь нь зориулалтын бие засах газаргүй гэсэн судалгааны дүн гарчээ. Мөн ихэнх орон нутагт хог хаягдал зайлцуулах тогтолцоо сайтар хөгжөөгүй тул айл өрхийн гадна хог их хэмжээгээр хуримтлагддаг байна. Эдгээр тоо баримт нь эрүүл ахуй, ариун цэврийн асуудал орон нутаг дахь хамгийн тулгамдсан асуудлын нэг болохыг харуулж байна.

Энэ нөхцөл байдлыг сайжруулах, асуудлыг шийдвэрлэхийн тулд орон нутгийн захиргаад ямар арга хэмжээ авах вэ? Энэ тухай таамаглал дэвшүүлээрэй

Орон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн талаар “Нутгийн захиргааны хүлээх чиг үүрэг” бүдүүвчэд тохиолдол тус бүрээр гүйцээж бөглөнө үү.

- Орон нутгийн байгууллага, албан тушаалтан иргэдээс гаргасан өргөдөл гомдлыг хуулийн дагуу хэрхэн шийдвэрлэх вэ?
- Орон нутгийн захиргаа нь иргэдийн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах, ахиц гаргах үүргийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?
- Хүний эрхэд ээлтэй орон нутгийг хөгжүүлэх гол арга зам, гарц юу байх вэ?
- Энэ асуудлыг зөв, зохистой байдлаар шийдвэрлэхэд иргэд хэрхэн оролцох вэ?

#### Хүснэгт 4.3 Хүний эрхийн талаар нутгийн захиргааны хүлээх чиг үүрэг

Хүний эрхийн жишээ	Хангах	Хамгаалах	Ахиц дэвшил гаргах
Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх			
Байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх			

Нийгэмд сургууль, эмнэлэг, цагдаа, шүүх, мэргэжлийн хяналтын албад, яамд зэрэг олон тооны төрийн байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр байгууллага бүр хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах, ахиц дэвшил гаргах үүргийг биелүүлэхээр ажилладаг. Тухайлбал, иргэдийн сурч боловсрох эрхийг хангахаар сургууль, цэцэрлэгүүд ажиллаж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангахаар эмнэлгүүд, амь нас, эд хөрөнгө, аюулгүй байдлыг хангахаар цагдаа, шүүх зэрэг хуулийн байгууллагууд ажилладаг. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахын тулд бусдын эрхийг зөрчиж буй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль зөрчигчдөд хууль зүйн хариуцлага оногдуулах хүний эрхийг хамгаалж ажилладаг.

Төрийн байгууллага бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүний эрхийг хангах, хамгаалах талаар бусад байгууллагатай үйл ажиллагаагаа харилцан уялдуулж ажиллана. Хүний эрхийг хамгаалах төрийн механизм хангалттай ажиллаж чадахгүй бол ажиллахыг шаардах, хөндлөнгөөс нөлөөлөх үүргийг хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хүлээдэг.

Төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, улс төрийн баталгааг хангах, зохион байгуулалтын асуудлыг хэрхэн зохицуулдаг тухай бид 9 дүгээр ангидаа дэлгэрүүлэн судлах болно.



#### Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Агаар, хөрс, усны бохирдол хүний эрхийн зөрчил мөн үү? Танай орон нутагт ийм асуудал тохиолддог уу?
- Хэрвээ мөн бол хүний эрхийн ямар зарчмыг хэрхэн зөрчиж байна вэ?
- Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах талаар танай орон нутгийн захиргаа юу хийж байна вэ? Орон нутгийн байгууллага бүрд жишээ гарган ярилцаарай.
- Та бүхэн хүний эрхийн асуудлаар орон нутгийн байгууллагад хандаж байсан уу? Тэд таны дэвшигүүлсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ?
- Төрийн байгууллага, албан тушаалтанд хүний эрхийн зөрчлийн талаар гомдол мэдээлэл гаргах арга зам, ач холбогдлын талаар та юу мэдэх вэ?

## 4.6. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ - ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ

Нийгмийн ухаан – VIII сурах бичгийн “Хүний эрх ба хууль” бүлгээр хийсэн аялал тань төгсөж байна. Бүлэг сэдвийн хүрээнд хүний эрхийн түүх, олон улсын баримт бичгүүд, тэдгээрт баталгаажуулсан хүний эрхийн зарчмууд, эрх зүйн хэм хэмжээ нь нийгэм, орон нутгийн харилцааг хэрхэн зохицуулдаг тухай үзэж судаллаа. Энэ нь та нар төр, иргэний харилцааны тухай мэдлэгтэй, байгаль орчинд ээлтэй, сургууль, орон нутгийнхаяа хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах чадвартай, хариуцлагатай иргэн болоход тань зохих хувь нэмэр болно гэж найдаж байна.

Мөн нийгмийн харилцааг зохицуулж буй хууль, дүрэм журам бүхэн хүний эрхийг хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх, хохирлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг агуулж байдгийг та бүхэн мэдэж авлаа. Иймд төрөөс, ялангуяа орон нутгийн засаг захирагааны байгууллагын үзүүлж буй үйлчилгээнд хамрагдаж, эрхээ хамгаалуулах боломжтой. Иргэд төрийн байгууллагатай харилцах, гаргаж буй шийдвэрт нь саналаа тусгах, хууль бус үйлдлээс эрхээ хамгаалуулах олон боломж хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг. Энэ тухай та бүхэн дараагийн бүлэг болох Орон нутгийн удирдлага хичээлийн хүрээнд гүнзгийрүүлэн судалж, тэдгээрт иргэд хэрхэн оролцох, хяналт тавих боломжтой байдгийг мэдэж аваарай.



Зураг 4.7 НҮБ-ын баталсан Тогтвортой хөгжлийн зорилт

Доорх зурагт дэлхий нийтээрээ 2030 он гэхэд хүрсэн байхаар эрмэлзэн тэмүүлж буй Тогтвортой хөгжлийн зорилтуудыг харуулжээ. Эдгээр зорилт нь хүн төрөлхтөн ирж буй 15 жилд хүний эрх, шударга ёс, тэгш байдал, сайн сайхан байдлыг хүн бүрд авчрахын төлөө дэлхий нийтээр эв санаагаа нэгтгэж, хүчин чармайлт гарган хүрэх ёстой алсын хараа юм.

Харин энэ бүх зорилтыг хангах эхлэл цэг нь бидний орон нутгаас эхэлнэ. Тиймээс сурах бичгийн өмнөх үгт бичсэнчлэн “Дэлхийн түвшинд сэтгэж, нутгийн түвшинд үйлд” гэсэн зарчмын дагуу өөрчлөлтийг өөрсдөө санаачлан эхлүүлээрэй.

Өөрчлөлт хийхийн тулд бид юу хийж чадах вэ хэмээн Та нар асууж магадгүй. Бид өөрчлөлтийг өөрөөсөө, амьдарч буй орон нутгаасаа эхлэх ёстой. Бидний амьдарч буй орчинд хүний эрх зөрчигддөг ч бид уг зөрчлийг хэвийн зүйл гэж бодож, дассан байж магад. Тухайлбал, танай гудамж гэрэлтүүлэггүй харанхуй, хог хаягдал ихтэй, агаар, ус, хөрс бохирдсон, худалдаа, үйлчилгээний чанар хангалтгүй байж ч магадгүй. Мөн олон иргэд ядууралд өртөж, төрийн байгууллагууд хүнд суртал, чирэгдэлтэй байж магад. Тиймээс хууль журмыг сахин мөрдөж, өөрийн болон бусдын эрхийг хамгаалахын төлөө тэмцээрэй. Энэ нь зөвхөн өөрийн төлөө биш, харин иргэд эрхээ мэдэж, шаарддаг, төрийн байгууллагууд нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, иргэндээ үйлчилдэг ардчилсан нийгмийн зүй ёсны харилцаа юм.

Үүний үр өгөөж нь хүн бүрд, орон нутагт тань Тогтвортой хөгжил болж ирнэ.



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

1. Тогтвортой хөгжлийн зорилтууд ямар ач холбогдолтой вэ?
2. Хөгжлийн зорилтуудаа хамгийн чухлаас эхлэн эрэмбэлээрэй. Мөн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудлыг ялган тодорхойлоорой.
3. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг орон нутгийн бодит жишээнд тулгуурлан гэр бүлийнхээ гишүүдэд тайлбарлана уу.



### Хамтран ажиллаарай

Тогтвортой хөгжлийн зорилтуудад тулгуурлан “Хүний эрхэд ээлтэй орон нутаг”-ийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, анги хамт олондоо танилцуулаарай.

- Боловсрол, Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөр эрхлэлт, Байгаль орчин, Дэд бүтэц гэсэн 6 багт хуваагдана.
- Баг тус бүр судалгаа хийж, танай орон нутаг, тухайн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлно.
- Орон нутгаа хүний эрхэд ээлтэй болгохын тулд юуг хэрхэн өөрчлөх, ямар арга хэмжээ авч, хэрхэн зохицуулах шаардлагатайг тодорхойлно.
- Бүх баг өөрсдийн санал, хөгжлийн төлөвлөгөөг бусад багт танилцуулна.
- Багуудын дэвшилтэт санаа, хөтөлбөрийг нэгтгэн “Хүний эрхэд ээлтэй орон нутаг”-ийг хөгжүүлэх төлөвлөгөөний саналаа боловсронгуй болгож, хэрхэн хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт боловсруулж, нутгийн захиргааны байгууллагадаа цахим шуудангаар илгээнэ.



### Бие дааж ажиллаарай

- Дараах хүснэгтийг гүйцээж, хичээл бүрээ сэргээн санаарай.
- “Хүн бүр багш” аргаар энэхүү бүлэг сэдвийн хүрээнд олж авсан мэдлэг чадвараа бусад найз нөхөртэйгээ хуваалцаарай.

#### Хүний эрх ба хууль бүлэг сэдэв

	Судалсан сэдэв	Тулгуур ойлголт	Суралцсан мэдлэг, чадвар
1			
2			

# ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА



## ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Орон нутгийн удирдлага
- Нутгийн өөрөө удирдах ёс
- Шийдвэр гаргах үйл явц
- Засаг дарга
- Иргэдийн Нийтийн Хурал
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

## ЧАДВАР, ХЭРЭГЛЭЭ

- Орон нутгийн түвшинд бодлого, шийдвэр хэрхэн гардаг, түүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг судалж, нийтийн удирдлага гэж юу болохыг тодорхойлох
- Орон нутагт хүүхдийн талаар гаргасан шийдвэрийг судлан, шийдвэрт тусгах санал боловсруулах

## 5.1. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ МЭДЭЛ ХААНААС ЭХТЭЙ ВЭ?



### Тохиолдол шинжлээрэй

Нэгэн сумын төвд ганц байдаг хүүхдийн тоглоомын талбай нь харж хандах эзэнгүйгээс нурах шахсаны хажуугаар хүмүүс ихээр цуглан архи уудаг, гэмт хэрэг ч мэр сэр гардаг болсон байна. Иймд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тус тоглоомын талбайн газарт худалдаа үйлчилгээний төв барих шийдвэр гарчээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга энэхүү шийдвэрээ тайлбарлахдаа: Тус сумын төвийн хувьд алслагдмал, томоохон худалдаа үйлчилгээний төв байдаггүй, дээр нь бид ард иргэдийнхээ амар тайван амьдралыг бодож энэхүү шийдвэрийг гаргалаа” гэжээ. Гэтэл тус суманд үйл ажиллагаа явуулдаг “Залуучуудын дуу хоолой” ТББ: Энэ талбай нийтийн эзэмшлийн талбай учраас хүүхэд залуучууд амрах цэцэрлэгт хүрээлэн болох ёстой гэв. Харин эцэг эхчүүд: Энэ анх хүүхдийн тоглоомын талбай байсан тэр чигээрээ байх хэрэгтэй, харин ч засаж тохижуулах хэрэгтэй хэмээв.

**Хэний шийдвэр хамгийн оноөчтой, хүүхдийн эрх ашигт нийцсэн, шударга байна вэ?**

Та бүхэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “Залуучуудын дуу хоолой” ТББ, эцэг эхчүүдийн алийг дэмжиж буйгаараа гурван бүлэгт хуваагдан саналаа нэгтгэж дараах хүснэгтийг бөглөнө үү.

*Хүснэгт 5.1 Дэмжиж буй шалтгааныг тодруулах хуудас*

д/д	Талууд	Дэмжиж буй сурагчдын тоо	Дэмжиж буй үндэслэл
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		
2	“Залуучуудын дуу хоолой” ТББ		
3	Эцэг эхчүүд		



### Хамтран ажиллаарай

Дугуй ширээний ярилцлага хийгээрэй. Ярилцлагын асуулт:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг зөвтгөх ямар үндэслэл байна вэ?
- Залуучуудын дуу хоолой ТББ-ын байр суурийг зөвтгөх ямар үндэслэл байна вэ?
- Эцэг эхчүүдийн байр суурийг зөвтгөх ямар үндэслэл байна вэ?
- Дээрх тохиолдолтой адилхан үйл ажиллагааг та бүхэн мэдэх үү? Хэрхэн шийдвэрлэсэн бэ?
- Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын шийдвэр хэнд ашигтай вэ?
- Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг хэвээр үлдээх нь зөв үү?
- Хэрэв шийдвэрийг өөрчлөх бол ямар үндэслэл байж болох вэ?

### Дугуй ширээний ярилцлага хийхэд анхаарах зүйл:

- Эхлээд ширээнүүдийг тойруулан тавьж бүгд нүүр нүүрээ харж суух боломжтой болгож бэлтгэх
- Ярилцлагыг удирдан явуулах хөтлөгчтэй байх
- Хэлэлцэж тохирсон цаг хугацаатай байх. Үүнд нэг хүний ярих хугацаа, нийт ярилцлагын хугацаа гэх мэт орно
- Бусдыг хүндэтгэх, сонсох
- Товч тодорхой, баримт нотолгоотой ярих нь чиний давуу тал болно.



### Гэртээ хийгээрэй

**Даалгавар:** Иргэдийн Нийтийн Хурал /ИНХ/ - ын талаар сурвалжилга хийх

**Зорилго:** ИНХ-ын үйл ажиллагааны онцлог, иргэдийн оролцооны талаар мэдээлэл цуглуулах

**Аргачлал:** Эцэг, эх, ойр дотны болон таньдаг хүмүүсийнхээ хүрээнд асуулт хариулатын аргаар сурвалжилна. Оролцогчдынхоо нас, хүйс, боловсролыг бичиж аваарай.

#### Хүснэгт 5.2 Сурвалжилгын асуулт:

Асуулт: Та баг хорооныхоо Иргэдийн Нийтийн Хуралд оролцдог уу?

ИНХ-д оролцдог хүмүүсээс асуух асуулт	ИНХ-д оролцдоггүй хүмүүсээс асуух асуулт
<ul style="list-style-type: none"> <li>▪ Та ИНХ-ын үйл ажиллагаанд тогтмол оролцдог уу?</li> <li>▪ Та хамгийн сүүлд ямар асуудлыг хэлэлцэхэд оролцсон бэ?</li> <li>▪ ИНХ ямар эрх мэдэлтэй байгууллага вэ?</li> <li>▪ ИНХ –д оролцохын ач холбогдол юу вэ?</li> <li>▪ ИНХ-д оролцохгүй байхын сүл тал юу вэ?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Та яагаад ИНХ-д оролцдоггүй вэ?</li> <li>▪ Хүмүүс яагаад ИНХ-д оролцдоггүй вэ?</li> <li>▪ Оролцохгүй байснаар ямар нэгэн бэрхшээлтэй тулгарч байсан уу?</li> <li>▪ ИНХ ямар эрх мэдэлтэй байгууллага гэж та боддог вэ?</li> <li>▪ ИНХ –д оролцохын ач холбогдол юу вэ?</li> </ul>

#### Сурвалжилгын үр дүнг нэгтгэх:

Та бүхэн гэрийн даалгавраар хийсэн сурвалжилгын үр дүнг дараах ажлын хуудсыг ашиглан нэгтгээрэй.

#### Хүснэгт 5.3 Сурвалжилгын үр дүнг нэгтгэх хуудас

Ерөнхий үзүүлэлт		
Хүйс	Эр	
	Эм	
Нас	18-25	
	26-50	
	51 дээш	
Боловсрол	Дээд	
	Тусгай дунд	
	Бага, дунд	
	Боловсролгүй	

ИНХ-ын үйл ажиллагаанд тогтмол оролцдог эсэх?			ИНХ-ын үйл ажиллагаанд оролцдоггүй шалтгаан?		
Тогтмол	Заримдаа	Хааяа	1.	2.	
ИНХ ямар эрх мэдэлтэй байгууллага вэ?					
1.	2.	3.	4.	5.	6.

### Асуултад хариулаарай

- Хэдэн насны хүмүүс хуралд идэвхтэй оролцож байна вэ?
- Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэн нь идэвхтэй оролцогч байна вэ?
- Хуралд оролцдог хүмүүсийн ихэнх нь ямар боловсролтой хүмүүс байна вэ?
- Эндээс ямар ямар дүгнэлт гаргаж болох вэ?

### Орон нутгийн эрх мэдлийн эх үндэс хаана байдаг вэ?

Хүснэгт 5.4 Орон нутгийн удирдлагын тогтолцоо

Монгол Улсын засаг захираганы нэгжүүд	Орон нутгийн удирдлага	Орон нутгийн удирдлагын бүтэц
Аймаг, нийслэл	Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) Аймаг нийслэлийн Засаг дарга	ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчид, албаны алба Засаг Даргын Тамгын Газар
Сум, дүүрэг	Сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) Сум дүүргийн Засаг дарга	ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчид, албаны алба Засаг Даргын Тамгын Газар
Баг, хороо	Баг хорооны ИНХ Баг хорооны Засаг дарга	ИНХ-ын тэргүүлэгчид Засаг Даргын албаны алба

Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал нь:

- Баг, хорооны Засаг даргыг сонгох, алжаас чөлөөлөх
- Эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх
- Зарим иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх
- Баг, хорооны иргэдээ шагналд тодорхойлох
- Өөрийн нутаг дэвсгэрт байгалийн баялгийг хэрхэн ашиглахыг хэлэлцэх зэрэг эрх үүрэгтэй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь:

- Сум, дүүрэг, аймаг, нийслэлийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх
- Засаг даргыг томилох, алжаас чөлөөлөх
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийг хэлэлцэн батлах зэрэг эрх үүргийг хэрэгжүүлдэг.

Хурлын тэргүүлэгчид нь:

- Бүх шатны хурал жилд цөөн тоогоор хуралддаг бөгөөд хурлын чөлөө цагт тодорхой зүйлийг шийдвэрлэж ажилладаг тэргүүлэгчид гэж байдаг.


Засаг дарга нь:

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харьяалах нутаг

дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн. Жишээ нь: Сумын Засаг дарга сургуулийн захиралд үүрэг өгөх эрхтэй.

Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд оролцож байгаа иргэд Засаг даргаа 4-н жилд нэг удаа сонгодог бол, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сонгодог. Засаг даргад хуралдаанд оролцсон хүмүүсийн олонхын буюу 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг сонгон баталгаажуулдаг.

Бүдүүч 5.1 Орон нутгийн удирдлага хэрхэн бүрддэг вэ?



### Өөрийгөө сориорой

Би ..... аймгийн / нийслэлийн ..... сумын / дүүргийн ..... багт/хороонд амьдардаг.

- Манай багийн / хорооны Засаг даргыг ..... гэдэг
- Манай сумын / дүүргийн Засаг даргыг ..... гэдэг
- Манай аймгийн / нийслэлийн Засаг даргыг ..... гэдэг
- Манай багийн / хорооны ИНХ-ын даргыг ..... гэдэг
- Манай сумын / дүүргийн ИТХ-ын даргыг ..... гэдэг
- Манай аймгийн / нийслэлийн ИТХ-ын даргыг ..... гэдэг

**Гол санаа.** Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1 –д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн заасан байдаг. Тэгвэл орон нутгийн удирдлагыг бүрдүүлэхэд гол үүргийг иргэд гүйцэтгэж байгаа учраас орон нутгийн эрх мэдлийн эх үндэс иргэдэд байдаг байна.

Сүүлийн жилүүдэд орон нутгийн бие даасан байдлыг дэмжих, тодорхой хэмжээний эрх мэдлийг орон нутагт олгох нь улс орны хөгжлийн нэгэн чухал үзүүлэлт хэмээн төр засгийн зүгээс хэрэгжүүлэхийг эрмэлздэг болжээ. Үүнтэй холбоотой гарч ирж буй нэг асуудал бол нутгийн өөрөө удирдах ёсны тухай асуудал юм.

### Нутгийн өөрөө удирдах ёс

Тодорхой нутаг дэвсгэрт аж төрөн суугаа хүмүүс, тэдний төлөөлөл өөрсдийн амьдрал аж ахуйд хамаатай бүхий л асуудлыг орон нутгийнхаа санхүү эдийн засгийн боломждоо тулгуурлан хууль тогтоомжийн хүрээнд хамтран шийдвэрлэх эрх мэдлийг Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг.



Зураг 5.1 Улс орны хөгжлийн нэг үндэс бол орон нутгийн бие даасан байдал юм.

Өөрийн орон нутагтаа тулгамдаж байгаа асуудлыг иргэд өөрсдөө эсвэл тэдний төлөөлөл хэлэлцэж шийдвэрлэх нь хэд хэдэн давуу талтай. Үүнд:

- Орон нутгийн түвшинд бүх асуудлыг шийдвэрлэдэг болсноор иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ ойрхон болно.
- Орон нутаг бие даасан эрх мэдэлтэй болсноор орон нутгийн хөгжилд нааштай үр нөлөө бий болно.
- Ардчилал, хүний эрхийг хамгаалах боломж улам бүр бэхэжнэ.

Өөрөөр хэлбэл, орон нутгийн удирдлага нь иргэдэд ойр, тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгож хурдан шийдвэрлэх боломж өндөр байдаг. Орон нутгийн удирдлага нь иргэдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд иргэд татвараа төлөх хүсэл эрмэлзэлтэй болж, өөрийн төлсөн татварын зарцуулалтын талаар санаа тавих болно. Ийнхүү иргэдэд ойр засаглал байна гэдэг нь ил тод, хариуцлага өндөр байх боломжийг нэмэгдүүлдэг.

Орон нутгийн удирдлага нь нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлдэг билээ.

### Хүснэгт 5.5 Орон нутгийн удирдлагын чиг үүрэг

Орон нутгийн удирдлага		
Ялгаа:	Нутгийн өөрөө удирдах байгууллага	Төрийн удирдлага
Хэрэгжүүлэгч:	Иргэдийн Нийтийн Хурал, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Засаг дарга
Эрх мэдлийн эх сурвалж:	Иргэдийн хурлаар болон сонгуулиар сонгогдох	Дээд шатны Засаг дарга томилох
Ажиллах хэлбэр:	Хуралдаан	Засаг даргын тамгын газар
Хугацаа:	Дөрвөн жил	Дөрвөн жил

## 5.2. ОРОН НУТАГТ ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ВЭ?



### Асуудал шийдвэрлээрэй

Монгол улсын иргэн бүр өөрийн орон нутагт тулгамдаж байгаа бэрхшээлтэй асуудал болон тэрхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн байгууллага албан тушаалтан юу хийх ёстой талаар санал бодлоо илэрхийлэх нөлөөлөх боломжтой. Энэхүү эрхийг бидний амьдарч буй ардчилсан нийгэм олгож байдаг.

Та бүхэн дараах таван алхмын дагуу өөрийн орон нутагт тулгамдаад бүй асуудлыг шийдвэрлэх хувилбарыг гаргаарай.

**Алхам 1.** Өөрийн орон нутаг дахь олон нийтийн өмнө тулгарсан шийдвэрлэвэл зохих асуудлыг олж тодорхойлно.

Тулгамдсан асуудлын хүрээ.

1. Сургуульд тулгардаг асуудлууд; /Сурагчдын олж авсан мэдлэг чадвар, хүүхдийн хүмүүжил, эрх гэх мэт/
2. Хүүхэд залуучуудын өмнө тулгардаг асуудал; / Сөрөг зан үйл, биеэ авч явах соёл, харилцаа, чөлөөт цаг гэх мэт/
3. Байгаль орчинтой холбоотой асуудлууд; /хог хаягдал, усны эх, ан амьтдыг хамгаалах гэх мэт/
4. Суурь эрх чөлөөтэй холбоотой асуудлууд; /Үг хэлэх, хэвлэн нийтлэх, сонгуульд оролцох гэх мэт/
5. Нийгмийн орчинтой холбоотой асуудлууд; /Сургууль цэцэрлэгийн ойролцоо архи тамхи зарах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэд бүтэц гэх мэт/

Дээрх таван үндсэн асуудлын хүрээнд 5-6 хүүхэд нэг баг болон дараах ажлын хуудсыг ашиглан өөрсдийн сонгосон асуудлыг тодорхойлно.

*Хүснэгт 5.6 Асуудлыг тодорхойлж дүн шинжилгээ хийх хуудас*

1	Багийн гишүүдийн нэрс	
2	Огноо	
3	Сонгосон асуудал	
4	Энэхүү асуудлыг хамгийн чухал гэж үзсэн үндэслэл нь юу вэ?	
5	Энэхүү асуудлыг хариуцдаг төрийн ямар байгууллага, албан тушаалтан байдаг вэ?	

**Алхам 2.** Бүлгээрээ судлах асуудлаа сонгоно. Багууд өөрсдийн сонгосон асуудлыг товч танилцуулж багуудын сонгосон асуудал дээр олонхын саналаар 1 асуудлыг судлахаар сонгож авна.

**Алхам 3.** Сонгосон асуудалд холбогдох мэдээллийг цуглуулна. Өөрөөр хэлбэл, аngiaraa сонгосон асуудлаа илүү тодорхой болгохын тулд нэмэлт мэдээлэл хаанаас, яаж авахаа шийднэ.

Алхам Зыг хийхдээ эхлээд ангид хэрхэн ажиллах зааварчилгааг багш өгөөд гэрийн даалгавраар гүйцэтгэнэ

#### Хүснэгт 5.7 Нэмэлт мэдээлэл цуглуулахад анхаарах зүйл

Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга
Номын сан /танай орон нутагт байгаа бүх номын сан/	Номын санд суух, номын санчаас тусламж авах
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл / ТВ, радио, сонин, сэтгүүл /	Үзэх, сонсох, унших
Орон нутгийн захиргаа	Биечлэн уулзах, утсаар ярих, захидал бичих
Эрдэмтэн судлаачид	Мэдээллийн самбар, цахим хуудсыг ашиглах
Интернет	Уулзах, утсаар ярих, цахим харилцаа тогтоох
	Унших, судлах

Санамж: Мэдээллийн эх сурвалжуудыг баг тус бүрд өөр өөрийг өгч мэдээлэл цуглуулах нь илүү тохиромжтой байдаг.

#### Мэдээлэл цуглуулах хуудас

Мэдээллийн эх сурвалж:	.....
Мэдээлэл цуглуулсан хүний нэр:	.....
Огноо:	.....
Судалж байгаа асуудал:	.....
Цуглуулсан мэдээлэл:	1. ....
	Гарын үсэг: .....

#### Мэдээлэл боловсруулах аргачлал

- Багийн гишүүдийн цуглуулсан мэдээллийн хуудсыг багийн ахлагч хурааж авна.
- Цуглуулсан мэдээллээ нягтлаад танай багийн сонгож авсан асуудалтай шууд болон шууд бус хамааралтай гэсэн 2 хэсэг болгоно.
- Мэдээллийн эх сурвалжийн төрөл болон агуулгын хувьд давхцаж байгаа мэдээллүүдийг нэгтгэнэ.

**Алхам 4.** Мэдээллээ ашиглан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг баг бүрдээ гаргаж дараа нь нэгтгэн ажлын төлөвлөгөө гаргана.

Эхлээд гэртээ цуглуулж ирсэн мэдээллийг сонсоод дараа нь мэдээлэл цуглуулсан багуудын бүх гишүүдийн төлөөллийг оруулсан 5-6 хүнтэй баг дахин байгуулна. Багууд тухайн асуудлаа шийдвэрлэх 1-2 хувилбарыг боловсруулна. Үүний дараах аргачлалаар нэгтгэнэ.

#### Хүснэгт 5.8 Хувилбаруудыг нэгтгэх

д/д	Хувилбарууд	Нэгтгэсэн нь
1	Хувилбар – 1	1.
2	Хувилбар – 2	
3	Хувилбар – 3	2.

Нэгдсэн санал гаргаад түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар нэмэлт санал ангийн хамт олноос авч эцсийн байдлаар бэлэн болгоно. Үүний дараа ажлын төлөвлөгөөг дараах загварын дагуу хийнэ.

#### Хүснэгт 5.9 Ажлын төлөвлөгөө гаргах

д/д	Хийх ажлын нэр	Хугацаа	Хариуцах эзэн	Хүлээгдэж буй үр дүн


**Алхам 5.** Орон нутагт тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх санал болон ажлын төлөвлөгөөг өөрсдийн амьдарч буй орон нутгийн захиргаанд өөрсдийн төпөөлөл болон багшийн оролцоотой хүргүүлнэ.

#### Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явц

Орон нутагт гарч буй шийдвэрүүд нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчөөгүй, нийтийн эрх ашигт харшлаагүй байх хэрэгтэй. Мөн өөрийн орон нутгийн иргэдийн санал, хүсэлт, байр суурийг тусган улмаар тэдний оролцох боломжийг бүрдүүлсэн байж сая хэрэгжихэд илүү хялбар болно.

**Гол санаа.** Орон нутгийн түвшинд гарагаас тушаал, тогтоол, дүрэм журам зэрэг шийдвэрүүдийг тухайн шатны Иргэдийн Нийтийн Хурал эсвэл Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын тэргүүлэгчид гаргахаас гадна бүх шатны Засаг дарга нар гаргадаг байна. Гарч буй шийдвэрүүд нь асуудлыг тодорхойлох, асуудлыг судлах, шийдлийн хувилбар боловсруулах, шийдвэр гаргах, шийдвэрийг хэрэгжүүлэх гэсэн үе шатыг дамжина.

#### Орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцын зураглал



Бүдүүгч 5.2 Орон нутагт шийдвэр гаргах үйл явц

Орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явц нь дээрх дэс дарааллын дагуу явагдах шаардлагатай байдаг бөгөөд орон нутгийн удирдлагаас хамаарч зарим үе шат алдагдах тохиолдол байна.

1. Бодлого, шийдвэр санаачлах. Орон нутгийн түвшинд бодлого шийдвэр аль түвшинд гарахаас хамаарч хурлын төлөөлөгч, намын бүлэг, засаг дарга, түүний ажлын алба санаачилдаг. Зарим тохиолдолд дээрх санаачлах эрх бүхий албан тушаалтнууд иргэдийн санал хүсэлт дээр тулгуурлан бодлого, шийдвэрийг санаачилж болдог.
2. Боловсруулах. Гарч буй бодлого, шийдвэрийн агуулга, цар хүрээ, найруулга зэргийг мэргэжлийн ажилтнууд эсвэл, хурлын төлөөлөгчид, Засаг даргын ажлын алба боловсруулдаг.
3. Хэлэлцэх. Тухайн бодлого, шийдвэр хаанаас гарахаас шалтгаалж, ИТХ-ын эсвэл ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар, Засаг даргын ажлын албаны хурлаар

хэлэлцүүлдэг. Мөн мэргэжлийн зөвлөхүүд болон ард иргэдээр хэлэлцүүлэх тохиолдол гарч болно.

4. Батлах. Орон нутгийн удирдлагаас гарах бодлого, шийдвэрийг ИНХ, ИТХ-ын тэргүүлэгчид тогтоол гарган, бүх шатны Засаг дарга нар захирамж, тушаал гарган баталдаг.
5. Хэрэгжүүлэх. Гарсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх нь нэг талаас тухайн асуудлыг хариуцсан төрийн байгууллагын алба, хэлтэс, нөгөө талаас орон нутгийн иргэдтэй шууд холбоотой.
6. Үнэлгээ хийх. Гарсан бодлого шийдвэр хэрхэн хэрэгжиж байгаад мэргэжлийн байгууллага, хүмүүс үнэлгээ хийдэг. Ингэж үнэлгээ хийснээр тухайн бодлого, шийдвэр амьдралд хэрхэн нийцэж буй байдал, хэрхэн түүнийг засаж сайжруулах вэ? гэсэн асуудал гарч ирдэг.

### 5.3. ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ШИЙДВЭР ГАРГАХАД БИД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?



#### Асуудал шийдвэрлээрэй

Сум дүүргийн ИТХ-д төлөөлөгчөөр ажиллах хүнийг шалгаруулах болно.

#### Нэр дэвшигчид:

**Доржийн Батаа.** Физикийн багш мэргэжилтэй боловч сургууль төгсөөд л өөр мэргэжлээр ажилласан. Одоо ИТХ-д төлөөлөгчөөр ажилладаг. Тэрээр боловсролыг чанартай болгох, хувийн сургуулиудын сургалтын төлбөрийг багасгах нь зүйтэй. ЕБС-ийн багш нар хангалтгүй боловсрол эзэмшүүлж байна гэж үздэг.

**Болдын Чимгээ.** Бүрэн дунд боловсролтой, хувиараа бизнес эрхэлдэг. Хэд хэдэн сургуулийн үдийн цай хөтөлбөрийн ханган нийлүүлэгч хийдэг байна. Тэр боловсролыг чанартай болгоё гэвэл төрөөс томоохон санхүүжилт хийж, үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй гэдэг. Мөн хувийн сургуулиуд өндөр төлбөртэй байж л чанартай боловсрол олгоно гэдэг.

*Хүснэгт 5.10 Нэр дэвшигчдийн давуу ба сул талыг тодорхойлох нь*

д/д	Нэр	Давуу тал	Сул тал
1	Д. Батаа	1. 2.	1. 2.
2	Б. Чимгээ	1. 2.	1. 2.

*Хүснэгт 5.11 Нэр дэвшигчдийн үнэлгээний хуудас /1-3 оноо өгнө/*

д/д	Шалгуур	Нэр дэвшигчид	
		Д. Батаа	Б. Чимгээ
1	Иргэдийг төлөөлөх чадвар		
2	Ажил үүргээ үнэнчээр хийх чадвар		
3	Боловсролын хөгжилд хандах хандлага		
4	Хувийн ашиг сонирхлоо намжаах чадвар		

Дээрх гурван нэр дэвшигчийн давуу болон сул талыг өөрсдийн түвшинд тодорхойлж үнэлгээ өгсний дараа хэнийг нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгох талаар санал хураагаарай.



### Тохиолдол шинжлээрэй

Өвөрхангай аймгийн Хужирт сумын сурагчдын парламент “Сурагчдын нэг өдөр”-ийг санаачлан хүүхдүүд, Засаг даргаас эхлээд жирийн албан хаагч зэрэг бүхий л ажлыг нэг өдөр хийсэн байна. Төрийн зарим албан хаагчид хүүхдүүдийн шийдвэрлэсэн асуудлыг дэмжиж жинхэнэ утгаар нь ашиглахаар болсон байна. Тухайлбал: ИТХ-ын Тэргүүлэгчдийн үүрэг гүйцэтгэсэн сурагчид сургууль завсардалтыг бууруулах зорилгоор 9,10 дугаар ангийн сурагчдыг зуны амралтаар нь албан бус сургалтад тодорхой урамшуулалтайгаар багшлуулж байх тогтоол гаргасан нь томчуудын дэмжлэгийг авчээ. Мөн ойн байцаагчаар ажилласан сурагч хулгайн мод бэлтгэж байгаа хүнийг илрүүлж 65 000 төгрөгийн тогтууль ногдуулсан бол багийн даргаар ажилласан сурагч багийнхаа өрхийн судалгааг бүдүүвч зургаар гаргасныг төрийн ажилд ашиглахаар болжээ.

Эх сурвалж: Нэг өртөнц-Өсвөр үе. ТББ. “Ардчилалд Сурагчдын оролцоо” төслийн тайлан. 1998 он.

### Харилцан ярилцаарай

- Та нарын үе тэнгийнхэн, томчуудын нэгэн адил асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай юу?
- Дээрх тохиолдолтой ижил ямар нэгэн тохиолдлын талаар мэдэх үү?
- Хэрвээ дээрх тохиолдолтой ижил боломж олдвол та бүхэн хамгийн түрүүнд ямар асуудлыг шийдвэрлэх вэ?

### Захидал бичээрэй

Та бүхэн өөрсдийн амьдарч буй сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хандаж боловсролын болон сургуулийн орчинд тулгамдаж буй асуудлыг шийдүүлэхээр захидал бичээрэй.

### Орон нутгийн түвшний бодлого, шийдвэрт хүүхдүүд оролцох боломж

**Гол санаа.** Аливаа оролцооны асуудал нь нэг талаас оролцогчдын хүсэл сонирхол, идэвх санаачилга, нөгөө талаас төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс оролцох боломжийг нээлттэй, чөлөөтэй байлагах тухай асуудал байдаг. Орон нутгийн түвшний бодлого шийдвэрт хүүхдүүд оролцох тухай асуудал ч энэ хүрээнд яригдана.

Хүүхдүүд та бүхэн танай орон нутагт хүүхдийн эрх ашигтай холбоотой гарч буй бодлого, шийдвэрт өөрийн дуу хоолойг хүргэх, шийдвэр гаргагчидтай уулзах, зөвлөлдөх, нөлөөлөх боломжийг ашиглах нь хүүхдэд ээлтэй бодлого, шийдвэр гарахад ихээхэн нөлөөтэй байдаг.

Орон нутагт гарч буй бодлого шийдвэрт хүүхдийн оролцоог хангахад чухал үүрэг гүйцэтгэх субъект бол хүүхдийн эрхийг хамгаалах зорилго бүхий төрийн болон төрийн бус байгууллагууд, мөн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд байдаг. Үүний нэг нь сум, аймаг, нийслэлийн Хүүхдийн нэгдсэн зөвлөл билээ.



Хүүхдийн нэгдсэн зөвлөл нь тухайн орон нутагт хүүхдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд насанд хүрэгчдэд нөлөөлж, хамтран ажилладаг сонгуулт байгууллага юм.

Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагаа нь хүүхдийн чуулганаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, тухайн орон нутагт хүүхдийн талаар явуулж буй үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаар өөрсдийн санал бодлоо илэрхийлэхэд нь хүүхдүүдэд туслах, холбогдох байгууллага, хүмүүст хандан шийдвэр гаргахад оролцох буюу нөлөөлөхөд чиглэгддэг.

Хүүхдийн нэгдсэн зөвлөл нь тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага болон хүүхэд гишүүнчлэлтэй Төрийн бус байгууллага (ТББ) –ын салбар нэгжүүдийн төлөөллөөс бүрдэнэ. Эдгээр байгууллагууд өөрсдийгөө төлөөлж чадах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн дуу хоолойг хүргэх төлөөллөө ардчилсан сонгуулиар сонгож, нэгдсэн зөвлөлд оруулдаг.



### Эх сурвалжтай ажиллаарай

Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2008 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолын нээдүүзээр хавсралт

#### “ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

/2008-2010 он/

**Таас: Хүүхэд өсвөр үеийнхний оролцоог нэмэгдүүлэх талаар**

- 5.1. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг чадваржуулахад төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- 5.2. Боловсрол, соёлын газрын дэргэдэх “Эрдэм” телевизийн үйл ажиллагааг тогтмолжуулж хүүхдийн нэвтрүүлгийн болон дуу хөгжмийн студи байгуулах
- 5.3. Хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
- 5.4. Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн дэргэд байнгын ажиллагаатай “Мини парламент” байгуулж ажиллуулах
- 5.5. Аймгийн Хүүхдийн төлөө төвөөс сум бүрд хүрч ажиллах, арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол хангаж ажиллах

**Зургаа: Хүүхдийн байгууллагын чадаехыг сайжруулах талаар**

- 6.1. Хүүхдийн байгууллагын орон тоог нэмэгдүүлж чадавхыг бэхжүүлэх
- 6.2. “Хүүхдэд ээлтэй” Засаг дарга шалгаруулах болзлыг жил бүр зарлан дүгнэх
- 6.3. Сум бүрд “Хүүхдийн элч” ажиллуулах, сургах, чадавхжуулах
- 6.4. Нийгмийн ажилтныг сургууль бүрд ажиллуулж, мэргэшүүлэх

### Баримт бичигт дүн шинжилгээ хийх арга

1. Хэлбэрийн хувьд:

- А. Баримт материалын төрлийг тодорхойлно. /хууль, дүрэм, ухуулах хуудас, сонины нийтлэл, номын хэсэг/
- Б. Бичигдсэн он сар өдөр буюу цаг хугацаа, газрыг тодорхойлно.
- В. Зохиогч хэн бэ? Хэнд зориулсан байна?
- Г. Баримт материалыг бичсэн /гаргасан/ шалтгаан юу вэ?
- Д. Баримт материалыг бодит байдалтай болон бусад материалтай харьцуулна.

2. Агуулгын хувьд:

- А. Баримт материалын гол санаа юу байна вэ?
- Б. Шинэ ойлголт, үг хэллэг, нэр томъёо байгаа эсэх?
- В. Баримт материалд далд утга санаа байна уу? Тэр нь юу вэ?

3. Үнэлгээ:

- А. Баримт материалын ач холбогдол? Б. Өөрийн үнэлгээ, дүгнэлтийг өгөх
- Б. Баримт материалын алдаа дутагдлыг илрүүлж улмаар сайжруулах боломж байгааг тодорхойлох

*Хүснэгт 5.12 Агуулгын шинжилгээ хийх хуудас*

Агуулгын шинжилгээ			
Хүүхдийн оролцоог хэрхэн дэмжих байна?	Хүүхдийн оролцооны байгууллага, нэгжийн талаар?	Хүүхдийн оролцоог хангах үүргийг хэнд ногдуулсан байна вэ?	Хүүхдийн байгууллагыг хэрхэн дэмжих байна вэ?
✓ ....	✓ ....	✓ ....	✓ ....
✓ ....	✓ ....	✓ ....	✓ ....



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

Танай орон нутагт дээрх хөтөлбөрийн заалтууд хэрэгжих боломжтой эсэхийг ярилцана уу?

Хэрэгжих боломжтой заалтууд	Хэрэгжих боломжгүй заалтууд
✓ ....	✓ ....
✓ ....	✓ ....
✓ ....	✓ ....

## 5.4. БҮЛГИЙН ДУГНЭЛТ

Хүүхдүүд та бүхэн энэхүү бүлэг сэдвийн хүрээнд орон нутгийн эрх мэдлийн үндэс хаана оршдог, орон нутгийн удирдлагын тогтолцоо, орон нутагт бодлого шийдвэр хэрхэн гардаг, тэдгээр хүүхдийн оролцоо ямар байж болох талаар товч судалсан. Ийнхүү судлахдаа орон нутгийн түвшинд хүүхэдтэй холбоотой гарсан шийдвэрийг шинжлэн судлах, бодлого боловсруулах үйл явцыг өөрсдийн түвшинд хэлэлцэн хэрэгжүүлэх, тодорхой жишээ тохиолдолтой ажиллах зэрэг дээрх агуулгын хүрээг өөрийн түвшинд эзэмшсэн.



### Хамтран ажиллаарай

Дөрвөн багт хуваагдан “Хүүхэд хөгжлийн хөтөлбөр” ажлыг гүйцэтгээрэй.

1. Иргэдийн хурлын төлөөлөгчдийн баг “Бидэнд ямар хөтөлбөр хэрэгтэй вэ?” сэдвээр дараах ажлыг хийнэ.

- Танай орон нутгийн удирдлага “Хүүхэд хөгжлийн хөтөлбөр” гаргахаар болсон тул Иргэдийн хурлын төлөөлөгчдөд уг хөтөлбөрт оруулах 3-5 заалт боловсруулах үүрэг оногдов.
- Багаараа ярилцан эдгээр заалтыг боловсруулж, яагаад уг хөтөлбөрт оруулах хэрэгтэй гэж үзэж байгаа үндэслэлээ гаргаарай.

2. Орон нутгийн захиргааны баг. “Хөтөлбөрийг хэрэгжүүлье” сэдвээр дараах ажлыг хийнэ.

- Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг орон нутгийн захиргаанд даалгасан тул хөтөлбөрийг олон нийтэд танилцуулах, сурталчлах, хэрэгжүүлэх 3-4 арга хэмжээ боловсруулж бусад багт тайлбарлаарай.

3. Орон нутгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн баг. “Хүүхэд хөгжлийн хөтөлбөр” боловсруулахдаа иргэд, эцэг, эх, сурагчид, багш нар, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулахаар болсонтой холбогдуулан орон нутгийнхаа Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн өмнөөс сум/дүүргийн Засаг даргадаа хүсэлт гаргана. Хүсэлт нь “Хүүхэд хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулахад олон нийтийг хэрхэн оролцуулах талаарх 3-5 арга хэмжээг багтаасан байна.

4. Сурагчдын баг. “Сургуулийн захиргаанаас явуулж байгаа үйл ажиллагаа зөв, шударга, хариуцлагатай байж чаддаг уу?” сэдвээр дараах ажлыг хийнэ.

- Нэгэн сургуулийн удирдлага “Хүүхэд хөгжлийн хөтөлбөр”-т санал өгөхдөө сурагчдын төлөөллийг оролцуулаагүй байна. Энэ нь бидний эрхийг зөрчиж байна гэж олон сурагчид үзсэн учир сургуулийн захиргаатай уулзаж санал солилцоо болов.
- Санал солилцох уулзалт дээр сургуулийн захиргаа, багш нарт тавих 3-аас доошгүй санал гаргаж, түүний үндэслэлийн талаар танилцуулахад бэлтгэнэ.



### Эргэцүүлэн хэлэлцээрэй

- Орон нутагт гардаг шийдвэрийн төрлийг нэрлэнэ үү.
- Эдгээр шийдвэрийг гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтныг нэрлээрэй.
- Орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэд оролцохын давуу тал болон ач холбогдол юу вэ?
- Өөрийн орон нутагт хүүхдийн талаар гаргах шийдвэрт тусгах санал боловсруулаарай.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>ХЭТТ</b>	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
<b>НҮБ</b>	Нэгдсэн үндэстний байгууллага
<b>АНУ</b>	Америкийн нэгдсэн улс
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ИНХ</b>	Иргэдийн нийтийн хурал

## ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

**Байгууллага** - Нийтлэг зорилгод хүрэхийн тулд үйл ажиллагаа нь хууль ёсны удирдлага, чиг үүрэг, хэм хэмжээгээр зохицуулагдсан бүлэг

**Баримт** - Бодитой, тодорхой, нягтлан шалгаж болохуйц мэдээлэл

**Баялаг** - Хүмүүсийн хэрэгцээг хангах зориулалттай материаллаг ба материаллаг бус эд зүйлс

**Бизнес** - Ашиг орлого авчрах бүхий л төрлийн үйл ажиллагаа

**Бүлэг** - Тодорхой зорилго, зорилтыг гүйцэтгэхээр хоорондоо харилцан холбогдсон хоёр болон түүнээс дээш тооны хүнээс бүрдсэн зохион байгуулалттай нэгдэл

**Гэр бүл** - Гэрлэлт болон цусан төрлийн холбоогоор холбогдсон, нэгдмэл амьдрал бүхий хүмүүсийн нэгдэл

**Гэрээ** - Тодорхой эрх, үүргийг бий болгох, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн хувь хүн, байгууллагуудын хооронд хийсэн хэлцэл

**Зах зээл** - Худалдагч ба худалдан авагчдын хоорондын харилцан үйлчлэл

**Зөрчилдөөн** - Талуудын сонирхол, зорилго, эрх ашгийг хөндсөн санал зөрөлдөөн

**Иргэн** - Тухайн улс орны хууль ёсны харьялал бүхий хүн

**Иргэний эрх** - Тухайн улсын хуулиар иргэддээ тогтоож өгсөн эрх, эрх чөлөө

**Иргэний үүрэг** - Тухайн улсын хуулийн дагуу иргэдийн биелүүлбэл зохих шаардлагууд

**Иргэдийн төлөөлөгчдийн хурал** - Аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага

**Иргэдийн нийтийн хурал** - Баг, хорооны нутгийн өөрөө удирдах байгууллага

**Конвенц** - Тодорхой асуудлыг хэлэлцэн тохирч баталсан олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл

**Материаллаг соёл** - Байшин барилга, хөшөө дурсгал, археологийн олдвор, машин техник гэх мэт тодорхой биетээр оршин байх соёлын хэлбэр

**Мэдээлэл** - Харилцаагаар дамжуулж буй аливаа юмс үзэгдлийн талаарх тодорхой дохио, тэмдэг, мэдлэг

**Нийгэм** - Хүмүүсийн хамтын амьдрал, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр, өөр хоорондоо харилцан үйлчлэлцэж буй хувь хүмүүс, бүлэг, байгууллагууд, тэдгээрийн хоорондын харилцааны цогц

**Нийгмийн харилцаа** - Хувь хүмүүс, бүлэг, байгууллагуудын хооронд үүсэж буй тогтвортой, олон талт хэлхээ холбоо

**Нийгмийн эрх** - Нийгмийн амьдралд оролцох, аж байдлаа хангахтай холбоотой эрх

**Нийлүүлэлт** – Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээ

**Нэр төр** - Аливаа хүнийг өөрөө болон нийгмийн зүгээс үнэлсэн үнэлэмж

**Орлого** - Тодорхой хугацаанд олж буй үр ашгийн мөнгөн илэрхийлэл

**Оролцоо** - Тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцох байдал, идэвх

**Орон нутгийн соёл** - Тухайн нутгийн зон олны хөгжлийн үндэс болж буй, эрт эдүгээд эрхэмлэсээр ирсэн, бас хойч үедээ өвлүүлэн үлдээх хүсэлтэй бүхий л үнэт зүйлс

**Оюуны соёл** - Шашин, домог үлгэр, зан заншил, баяр наадам, байгаль ертөнцтэй холбоотой мэдлэг, шинжлэх ухаан, боловсрол, урлаг гэх мэт биет бус соёлын хэлбэр

**Орон нутгийн нийгмийн орчин** - Хүмүүсийн ажиллаж, сурч, амьдарч буй орчин дахь хүмүүс хоорондын харилцаа, нийгмийн бүлэг, байгууллагуудын хүрээ юм.

**Өмч** - Ямар нэгэн үнэт чанар бүхий юмс үзэгдэл, тэдгээрийн ашиглалт, хэрэглээ

**Үнэ** - Иргэдээс бараа үйлчилгээг худалдан авахдаа төлж буй мөнгөн дүн

**Үйлдвэрлэлт** - Хүний хэрэгцээ хангах зорилгоор үйлдвэрлэлийн нөөцийг ашиглан бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах үйл явц

**Үндсэн хууль** - Тухайн улсын хувьд даган мөрдөх гол хууль

**Пакт** - Хүний эрхийн асуудлаар улс орнуудад үүрэг хүлээлгэдэг олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл

**Сайн дурын үйл ажиллагаа** - Өөрийн хүсэл эрмэлзэлээр үнэ хөлсгүйгээр орон нутаг нийгмийнхээ төлөө хийж байгаа үйл ажиллагаа

**Соёлын дурсгалт газар** - Хүний болон хүн, байгаль хоёрын харилцан үйлчлэлийн дүнд бий болсон гайхамшигт бүтээлүүд, мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутаг

**Соёлын нэвчилт** - Соёлын зүйл нэг бүлгээс, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явц

**Соёлын хожимдол** - Соёлын материаллаг талд хэт их ач холбогдол өгч, хэрэглээг шударга үнэн, хүнлэг сэтгэлээс эрхэмд үзэх явдал даамжирснаас болж нийгэмд үүсдэг сөрөг үр дагавар

**Соёлын үнэт зүйл** - Улс орны соёлын уламжлалд өндөр ач холбогдол бүхий үнэт зүйлс

**Тунхаглал** - Ямарваа нэгэн асуудлаар улс орнуудыг тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийгuriалсан олон улсын баримт бичиг

**Төр** - Нийгмийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, нийтлэг үйлчлэх шийдвэрийг гаргагч, албадлага, хуч хэрэглэх онцгой эрх бүхий засаглалын аппараттай, хууль ёс уламжлал, зан заншлын дагуу, олгогдсон эрх нь тухайн нутаг дэвсгэрт заавал хэрэгжих хүчинтэй байдаг улс төрийн институт

**Хууль** - Төрөөс тогтоосон заавал биелүүлэх хэм хэмжээний цогц

**Хүний эрх** - Хүн болж төрсний хувьд заясан боломжууд

**Хэм хэмжээ** - хүмүүсийн харилцаа, нийгмийн дэг журмыг зохицуулж байдаг зарчим, шаардлагууд

**Эрэлт** – худалдан авагчдын хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авч чадах боломжит бараа үйлчилгээний тоо хэмжээ

**Эрх зүй** - Нийгмийн харилцааг зохицуулах зорилгоор төрөөс тогтоогдож, зан заншил, хууль зүйн зүй зохистой, хэм хэмжээт байдлын үйлчлэн зохицуулагч тогтолцоо